

Сарлагийн арьс шир ба био-арьсан
бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг
бэхжүүлэх” төсөл



Ургамлын идээлэгтэй сарлагийн
арьсан бүтээгдэхүүнийг Европын
орнууд уруу экспортлох гарын авлага

Олон нийтэд нээлттэй түгээхийг хязгаарлах тухай

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүжилттэй “Сарлагийн арьс шир ба био-арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд боловсруулсан бөгөөд Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Зохиогчийн эрх

© 2024 European Profiles S.A.

Энэхүү гарын авлагын агуулга нь Европын Холбооны гишүүн орнуудын дагаж мөрдөх, холбогдох хуулиар хамгаалагдсан.

Агуулга

1.	ТАНИЛЦУУЛГА.....	8
2.1	Арьс ширний зах зээл, хэмжээ, эргэлт	10
2.2	Дотоодын үйлдвэрлэл	12
2.3	Импорт/экспорт	14
2.4	Өрсөлдөөний шинжилгээ.....	17
2.5	Бөөний үнэ.....	18
2.6	Хэрэглэгчийн өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн чиг хандлага.....	19
2.7	Маркетингийн суваг/сүлжээ.....	21
2.8	Европын онцгой давуу тал/ хязгаарлалттай орнууд, харьцуулсан шинжилгээ.....	21
2.9	Зорилтот зах зээлийг боломжид нь үндэслэн сонгох	23
3.	МОНГОЛООС ЕВРОПЫН ОРНУУД РУУ ЭКСПОРТОД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД.....	24
3.1	Бүртгэл, тусгай зөвшөөрлийн процесс	24
3.1.1.	Ерөнхий мэдээлэл.....	24
3.1.2.	Мал, амьтны гаралтай түүхий эдийн экспортын гэрчилгээ авах.....	25
3.1.3.	Олон улсын мал эмнэлэгийн гэрчилгээ авах	25
3.1.4.	Гарал үүслийн гэрчилгээ	26
3.1.5.	Экспортын тохирлын гэрчилгээ авах	27
3.2	Гаалийн хяналт, шалгалтын үйл явц	27
3.3	Тээвэр, ложистик.....	32
3.4	Татвар, үнэ тариф.....	33
3.4.1.	Үнэ тариф	33
3.4.2.	Татвар	35
3.4.3.	Бусад хязгаарлалт	36
3.5	Экспортын гэрчилгээ авахад шаардагдах бичиг баримтууд.....	36
4.	ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛИЙН ИМПОРТЫН ШААРДЛАГА	37
4.1	Малын гаралтай бүтээгдэхүүний худалдаатай холбоотой дүрэм, хязгаарлалт	37
4.2	Бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага	38
4.3	Европын Холбооны дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх	40
4.4	Стандартууд ба гэрчилгээ	43
4.5	Шошго, баглаа боодлын шаардлага.....	44
4.5.1.	Шошго	44
4.5.2.	Сав, баглаа, боодол.....	49
4.6	Ургамлын идээлгээр идээлэх арга, арьс ширэн бүтээгдэхүүний чанарын шаардлага	50
4.7	Татвар, хураамж.....	52
4.8	Шаардлагатай бичиг баримт	54
4.8.1.	Арьс шириийг түүхийгээр нь импортлох гарал үүслийн гэрчилгээ	54
4.8.2.	Гаалиар нэвтрэх бичиг баримт.....	55
4.3.3.	Санал зөвлөмж	56
5.	ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖИТ ТҮНШҮҮД/ХАМТРАГЧИД	58

5.1. Танилцуулга	58
5.2. Европын Холбооны түншүүд болон үйлчлүүлэгчидтэй харилцаа тогтоох стратеги	58
5.2.1. Ерөнхий мэдээлэл.....	58
5.2.2. Өвөрмөц дүр төрх, загвар бүхий өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний багцыг бий болгох	59
5.2.3. Үзэсгэлэн,яармаг худалдаанд оролцох	59
5.2.4. Европын Холбооны гол аж үйлдвэрүүдийн холбоодтой харилцаа холбоо тогтоох	60
5.3. Санал болгож буй боломжит бизнесийн түншүүд ба үйлчлүүлэгчид.....	62
5.3.1. Арьс ширний үйлдвэрүүд.....	62
5.3.2. Гутал, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон брендүүд.....	63
Хавсралт 1. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний худалдаатай холбоотой Монгол улсын хууль тогтоомж.....	67

Товчлол

€	Euro <i>Евро</i>
APICCAPS	Portuguese Footwear Industry Association <i>Португалийн гутлын аж үйлдвэрийн холбоо</i>
AQL	Acceptance quality limit/level <i>Хүлээн авах чанарын хязгаар/төвшин</i>
BCP	Border control point <i>Хилийн хяналтын цэг</i>
CAGR	Compound annual growth rate <i>Жилийн нийлмэл өсөлтийн хурд</i>
CITES	Convention on International Trade in Endangered Species <i>Ховордсон ан, амьтдын олон улсын худалдааны тухай конвенц</i>
COTANCE	Confederation of National Associations of Tanners and Dressers of the European Community <i>Европын нийгэмлэгийн арьс шир, хувцас үйлдвэрлэгчдийн үндэсний холбоо</i>
EC	European Commission <i>Европын комисс</i>
ELSEVIE	Hellenic Association of Footwear Manufacturers and Exporters <i>Грекрийн гутал үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо</i>
ESPR	Eco-design for Sustainable Products Regulation <i>Тогтвортой бүтээгдэхүүний зохицуулалтад зориулсан эко дизайн</i>
EU	European Union <i>Европын Холбоо</i>
FICE	Federación de Industrias del Calzado Español <i>Испанийн гутлын үйлдвэрүүдийн холбоо</i>
GSP	General System of Preferences <i>Хөнгөлөлтийн ерөнхий систем</i>
HNWI	High-net-worth individuals <i>Өндөр орлоготой хувь хүмүүс</i>
HS	Harmonized System <i>Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем</i>
ICT	International Council of Tanners <i>Арьс шир үйлдвэрлэгчдийн олон улсын зөвлөл</i>
INCO	International Cooperation <i>Олон улсын хамтын ажиллагаа</i>

INESCOP	Instituto Tecnológico del Calzado y Conexas <i>Испанийн гутал, дагалдах хэрэгслийн технологийн институт</i>
IP	Intellectual property <i>Оюуны өмч</i>
ITDM	International Trade Development in Mongolia <i>Монгол улсад гадаад худалдааг хөгжүүлэх төсөл</i>
LWG	Leather Working Group <i>Дэлхийн арьс ширний нийгэмлэг (групп)</i>
MALI	Mongolian Association of the Leather Industry <i>Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо</i>
MNCCI	Mongolian National Chamber of Commerce and Industry <i>Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим</i>
MNT	Mongolian tugrik <i>Монгол төгрөг</i>
MS	Member States <i>Гишүүн орнууд</i>
NFC	Near-field communications <i>Ойр талбарын харилцаа холбоо</i>
OEKO-TEX	International Association for Research and Testing in the Field of Textile and Leather Ecology <i>Бөс бараа, арьс ширний экологийн салбарын судалгаа шинжилгээний олон улсын холбоо</i>
PCA	Partnership and Cooperation Agreement <i>Түншлэл, хамтын ажиллагааны гэрээ</i>
REACH	Registration, Evaluation, Authorization and Restriction of Chemicals <i>Химийн бодисыг бүртгэх, үнэлэх, зөвшөөрөл олгох, хязгаарлах/хориглох/</i>
RSL	Restricted substance lists <i>Хязгаарлагдмал бодисын жагсаалт</i>
SME	Small and medium-sized enterprises <i>Жижиг дунд үйлдвэрүүд</i>
SYL	Sustainable Yak Leather <i>Сарлагийн арьсан бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл</i>
TRAM	Trade-related Assistance for Mongolia <i>Монголын худалдааг дэмжих төсөл</i>
UCPD	Unfair Commercial Practices Directive <i>Шударга бус арилжааны үйл ажиллагааны заавар</i>

UK	United Kingdom <i>Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улс</i>
UN	United Nations <i>Нэгдсэн Үндэстний Байгууллага</i>
UNCTAD	United Nations Conference on Trade and Development <i>НҮБ-ын Худалдаа ба хөгжлийн бага хурал</i>
USD	United States dollar <i>АНУ-ын доллар</i>
UV	Ultraviolet <i>Хэт ягаан туяа</i>
WOAH	World Organisation for Animal Health <i>Дэлхийн ан, амьтны эрүүл мэндийн байгууллага</i>
WTO	World Trade Organisation <i>Дэлхийн худалдааны байгууллага</i>
ZDHC	Zero Discharge of Hazardous Chemicals <i>Химийн аюултай бодисын хог хаягдал</i>

1. ТАНИЛЦУУЛГА

Ургамлын идээлэгтэй сарлагийн арьсан бүтээгдэхүүнийг Европын зах зээлд экспортлох энэхүү гарын авлагыг Европын Холбооны гишүүн орнууд, Их Британи зэрэг тэргүүлэх ач холбогдол бүхий улс орнуудын худалдааны шаардлагуудыг нарийвчлан судалсны үндсэн дээр боловсруулсан бөгөөд ялангуяа Монгол улсын ургамлын идээлэгтэй сарлагийн арьсан бүтээгдэхүүний кластерийн экспортлогчдын бүтээгдэхүүнүүд эрэлт өндөртэй улс орнуудын талаар тусгасан болно.

SWITCH-Asia хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Сарлагийн арьс шир ба био-арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд Монгол улсад ургамлын идээлэгтэй сарлагийн арьс шир ба био-арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх 30 арга хэмжээний нэг нь энэхүү экспортын гарын авлагыг бэлтгэн

Нэр:	<i>Сарлагийн арьсан бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл (SYL) Төсөл</i>
Байрлал:	Монгол улс (Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай аймгууд)
Санхүүжилт:	Европын Холбооны (ЕХ) буцалтгүй тусламж
Хугацаа:	Дөрвөн жил (2021 оны 12 сараас 2025 оны 12 сар).
Зорилтууд (дунд хугацааны):	<ul style="list-style-type: none"> • Ургамлын идээлэгт сарлагийн арьс боловсруулалтыг дэмжих • Үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, • Нөөцийн үр ашгийг сайжруулах, • Тойрог эдийн засгийн туршлагыг нэвтрүүлэх.
Зорилтууд (урт хугацааны)	Кластерийн гишүүдийг дэлхийн үйлдвэрлэл хэрэглээний сүлжээнд нэгтгэх.
Хэрэгжүүлэлт:	Долоон ‘хамтрагч’ байгууллагын консорциум
	<ol style="list-style-type: none"> 1. Грек улс дахь Vakakis and Associates S.A. 2. Грек улс дахь European Profiles S.A. (EP), 3. Грек улс дахь гутал үйлдвэрлэгчид ба экспортлогчдын холбоо (ELSEVIE), 4. Испани улсын Гутал, дагалдах хэрэгслийн технологийн институт (INESCOP), 5. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), 6. Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо (МАШҮХ), 7. Брэнд Гутал ХХК, Монгол улс

гаргах явдал билээ.

Төслийн анхаарлын төвд байгаа үндсэн мэдээлэл:

- Сарлаг,
- Ургамлын идээлэгт арьс шир,
- Кластерууд
- Монгол улс

Төслийн вэбсайтаас (www.sustainableyakleather.eu) эдгээр мэдээллийг авах боломжтой. ЕХ-ны Монголын Худалдааг дэмжих (TRAM, 2018-2022) төслөөс эхлэн хийгдэж буй ургамлын идээлэгтэй сарлагийн арьс, кластерын ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж байгаа бөгөөд Монгол улсад гадаад худалдааг хөгжүүлэх “ITDM 2023-2026” төслөөр дамжуулан дэмжин ажиллана.

Экспортын гарын авлагыг бэлтгэх явцад хийгдсэн судалгаагаар Монгол улсаас дараах түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжтойг тодорхойлов. Үүнд:

- ургамлын идээлэгтэй сарлагийн краст арьс (өнгө засал хийгээгүй арьс),
- өнгө засал хийсэн ургамлын идээлэгтэй сарлагийн арьс шир,

- ургамлын идээлэгтэй сарлагийн арьсан бүтээгдэхүүн.

Уг судалгаанд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний худалдаатай холбоотой Монгол улсын холбогдох хууль тогтоомж, гарал үүслийн гэрчилгээ, тэдгээрийн олон улсын хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг нягтлан, харьцуулан шинжилсэн болно. Түүнчлэн худалдааны хөнгөлөлт гэх мэт онцгой давуу талуудыг эрх зүй, зах зээлийн зохицуулалтын орчны хүрээнд судлан үзсэн нь Монгол улсын экспортлогчдыг дэмжих дорвитой дэмжлэг болно гэж үзэж байна.

Судалгааны үр дүн нь худалдааны хууль эрх зүйн шаардлагыг хангах, итгэл үнэмшлийг хөгжүүлэх, "чанартай бүтээгдэхүүн", "чанартай үйлчилгээ" гэсэн нэр хүндийг бий болгоход чиглэсэн "дотоод" ур чадварын ач холбогдлыг онцолж байна.

Экспортын гарын авлагын анхны хувилбарыг ургамлын идээлэгтэй сарлагийн арьс ширний кластерийн бүх гишүүдэд нэг өдрийн сэдэвчилсэн семинарын үеэр (8-р сарын 29) танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд Монголын Арьс Шир Үйлдвэрлэлийн Холбоо (МАШҮХ), Европын Холбоо болон Олон улсын худалдааг дэмжих ITDM төслийн төлөөлөгчид оролцлоо. Семинарын үеэр гарсан санал хүсэлтийн үр дүнд зарим нэмэлт тэмдэглэл, тайлбарыг энэ гарын авлагад тусгасан болно. Жишээ нь гэрчилгээ олгох ба хэрэглэгчийн чиг хандлагын талаар (веганизм) гэх мэт.

Экспортын гарын авлага нь уншигчдыг ерөнхий мэдээллээр хангах бөгөөд экспорт, маркетингтай холбоотой өөрчлөлтийг шаардлагатай тохиолдолд цаг тухай бүрт шинэчилж байх хэрэгцээг харгалзан үзэж энэхүү гарын авлагыг “Сарлагийн арьс шир ба био-арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх” төсөл дуусахаас өмнө дахин шинэчлэх төлөвтэй байна.

2. ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ: ЕВРОПЫН ХОЛБООНЫ ГИШҮҮН ОРНУУД БА БУСАД ОРНУУД

2.1 Арьс ширний зах зээл, хэмжээ, эргэлт

Мал, амьтны гаралтай арьс, ширийг идээлж боловсруулах замаар өндөр чанартай, удаан эдэлгээтэй материал үйлдвэрлэж, зах зээлд тогтвортой борлуулах боломжтой. Эс бөгөөс анхдагч түүхий эд, хагас боловсруулсан түүхий эд муудаж, үр ашиггүй үрэгдэх нь олонтоо тохиолддог. Арьс, ширийг идээлж төрөл бүрийн бүтээгдэхүүн хийх нь эртнээс уламжлагдан өвлөгдөж ирсэн нарийн-чимхлүүр ажиллагаа шаарддаг үйлдвэрлэлийн төрөл юм. Арьс шир нь гутал, хувцас, тавилга гэх мэт төрөл бүрийн эд зүйлийг хийхэд ашиглагддаг бөгөөд мөөгөнцөртөхгүй, химийн урвалд тэсвэртэй, удаан эдэлгээтэй олон төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглаж байна.

Дэлхийн арьс ширний зах зээлийн хэмжээ 2022 онд 39.6 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2022-2030 он хүртэл жилийн нийт өсөлтийн хурд (CAGR) 3.6% -иар өсч, 2030¹ он гэхэд 52.5 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Дэлхийн арьс ширний зах зээлд тансаг зэрэглэлийн бараа, дагалдах хэрэгслийн эрэлт хэрэгцээ цаашид нэмэгдэх хандалагатай байна. Арьс, шир нь цүнх, гутал, бүс, түрийвч болон бусад загварын дагалдах хэрэгсэлд ихэвчлэн хэрэглэгддэг дээд зэрэглэлийн материал юм. Хөгжингүй орнуудын иргэдийн орлого өсөж, тансаг зэрэглэлийн барааны эрэлт нэмэгдэж байгаа нь дэлхийн арьс ширний зах зээлийн өсөлт нэмэгдэх таатай боломжийг бүрдүүлсээр байна.

КОВИД-19 цар тахлын улмаас Итали улсын арьсан эдлэлийн экспорт 2019 онд 12,4 тэрбум евро байсан бол 2020² онд 9,6 тэрбум евро болж 13%-иар буурсан хэдий ч Европ дахь цар тахлын хорио цээр дууссанаас хойш зах зээл аажмаар сэргэж байна. Арьс шир, түүнтэй холбоотой бараа, бүтээгдэхүүний салбар нь 36,000 орчим аж ахуйн нэгжээс бүрддэг бөгөөд 48 тэрбум еврогийн³ эргэлтийг бий болгодог. Эдгээр аж ахуйн нэгжүүдэд нийт 435,000 орчим хүн ажиллаж байна. Европын Холбооны улсууд чанартай арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр тэргүүлдэг бөгөөд тугалын арьсаар хийсэн бүтээгдэхүүн илүү эрэлт ихтэй. Европын Холбооны арьс ширний үйлдвэрүүд нь ихэвчлэн гэр бүлийн, жижиг дунд үйлдвэрүүд (ЖДҮ) байдаг ба бүс нутгийн төвлөрлөөс шалтгаалан аж үйлдвэр нь орон нутгийн эдийн засагт гол үүрэг гүйцэтгэж, ажлын байр, баялгийн эх үүсвэр болдог.

Цар тахлын улмаас 2020-2021 онуудад бүх төрлийн арьс ширэн бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа дараах хүчин зүйлүүдээс шалтгаалж тасалдсан. Үүнд:

- эрчим хүчний доголдол, хязгаарлалт
- дэлгүүрүүд татан буугдсан, үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосон
- дэлхий даяарх хөл хорио

Мөн цар тахлын хорио цээр нь компаниудын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтвортой сүлжээг тасалдуулахад хүргэсэн.

Арьс ширэн бүтээгдэхүүн нь эрт дээр үеэс хэрэглэж заншсан уламжлалт соёлын нэг, тансаг байдлыг агуулсан бүтээгдэхүүн бөгөөд түгээмэл өргөн хэрэглээтэй байдгаараа


¹ Дэлхий - Арьс - Зах зээлийн шинжилгээ, урьдчилсан мэдээ, хэмжээ, чиг хандлага, ойлголт
Шинэчлэлт: COVID-19-ийн нөлөө.

² COTANCE & Eurostat <https://s4tclfbblueprint.eu/project/tclf-sectors/european-leather-industry/>

³ https://single-market-economy.ec.europa.eu/sectors/fashion/leather-industry/eu-leather-industry_en#:~:text=Economic%20importance%20of%20the%20industry,turnover%20of%20%E2%82%AC48%20billion


онцлог юм. Сүүлийн жилүүдэд чанартай, загварлаг гар цунх, дээд зэрэглэлийн савхин түрийвч болон бусад савхин эдлэлийн эрэлт нэмэгдэж байгаа нь арьсан эдлэлийн зах зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Мөн арьсан бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэлд төрөөс үзүүлж буй дэмжлэг нэмэгдсэн нь зах зээлийн өсөлтөд сайнаар нөлөөлж байна.

Гутал үйлдвэрлэлд (ялангуяа пүүзний хувьд) арьсан бус материалын хэрэглээ нэмэгдэж байгаа хэдий ч үйлдвэрлэсэн нийт арьс ширний тал орчим хувь нь гутлын үйлдвэрлэлд зориулагддаг юм



Зураг 1. Арьс ширний хэрэглээ, эцсийн бүтээгдэхүүнээр. 2019 он.

Хэдийгээр арьс ширний эрэлт нэмэгдэж байгаа хэдий ч бусад олон төрлийн түүхий эдийн үнэ буурсаар байна.



Зураг 2. Арьс ширний үнэ (12 сарын хөдөлж буй дундаж), АНУ, 1990-2020 он

Түүхий эдийн үнэ буурсанаар арьсан бүтээгдэхүүний үнийг хамгийн хямд түвшинд хүргэж байна.

Мөн бусад түүхий эдүүд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлд арьс ширтэй өрсөлдсөөр ирсэн бол сүүлийн жилүүдэд арьс ширийг хиймэл арьсаар орлуулах нь ихссэн. Хиймэл арьсаар хийгдсэн бараа бүтээгдэхүүний хувьд зарим дутмаг шинж чанартай:

- Арьс ширнээс хямд биш,
- Арьс ширний зарим чухал шинж чанар байхгүй,
- Арьс шир шиг хэрэглэгчидийн сэтгэл татах чанар дутмаг.

Түүнчлэн арьс ширэн бүтээгдэхүүний хэрэглээ буурахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судалвал:

- мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл,
- махны хэрэглээнээс татгалзах; цагаан хоолтнууд нэмэгдэх
- веганизм.

Эдгээр хүчин зүйлүүд нь богино хугацаанд арьс ширний эрэлтэд ноцтой нөлөөлөх магадлал багатай ч арьс ширний үйлдвэрүүд болон арьс ширний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний өөрчлөлт, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудын (SDGs) шаардлагуудыг харгалзан үзэх зэрэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй юм;

2.2 Дотоодын үйлдвэрлэл

Сүүлийн жилүүдэд малын, ялангуяа үхрийн идээлсэн арьс, шир болон түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүн нь дэлхийн өнцөг булан бүрт хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ ихтэй бүтээгдэхүүн болж байна. Арьсыг идээлж боловсруулах үйл явц нь арьсыг гэмтээх эрсдлийг бууруулж, арьсны бүтцийг сайжруулдаг. Арьс ширэн бүтээгдэхүүний зах зээлийг түүхий эд, төрөл, түгээлтийн сүлжээ, газарзүйн байршлаар нь ангилдаг.

Хүснэгт 1. Арьс ширэн бүтээгдэхүүний зах зээлийн сегментчилэл

Төрөл	Түгээлтийн сүлжээ	Газар зүйн байрлал
<ul style="list-style-type: none"> • Түүхий эд; арьс шир (үхэр, адуу, сарлаг гэх мэт), арьс (хонь, ямаа, экзотик/ховордсон гэх мэт) • Арьс идээлэх арга; эрдэс, хиймэл, ургамлын гэх мэт. 	<ul style="list-style-type: none"> • Оффлайн /энгийн/ жижиглэнгийн дэлгүүрүүд • Онлайн жижиглэнгийн дэлгүүрүүд 	<ul style="list-style-type: none"> • Хойд Америк • Европ • Ази, Номхон далайн орнууд • Дэлхийн бусад улс, орнууд

Арьс ширний үйлдвэрлэлд хэрэглэхгүй хаягдаж байгаа бүх төрлийн арьс, ширийг ашиглах боломжтой. Арьс ширэн түүхий эд нь арьс ширний үйлдвэрлэлийн гол бүтээгдэхүүн бөгөөд мөн өргөн хэрэглээний барааны дэд салбаруудад хэрэглэгдэх завсрын бүтээгдэхүүн юм.

Европын Холбооны комисс нь арьс ширний үйлдвэрлэлийн хамгийн чухал зах зээл болохыг өөрийн цахим хуудсандаа тэмдэглэсэн байна. Үүнд:

- Гутал, 41%
- Тавилга, 17%
- Автомашины үйлдвэр, 13%
- Савхин /арьсан/ эдлэл, 19%

- Хувцас, 8%
- Бусад 2%

Арьс ширний үйлдвэр нь үйлдвэрлэлийн янз бүрийн салбарт ашиглаж болох дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тухайлбал арьс ширний нийлмэл материал, гэрийн тэжээвэр амьтан, малын тэжээлийн үйлдвэрлэл, химийн бордоо, хүнсний болон гоо сайхны зарим төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэгддэг.

Европ дахь уламжлалт хэрэглээ болон өсөн нэмэгдэх эрэлт нь арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарын стратегийг улам боловсронгуй болгоход нөлөөлж байна. Европын арьс ширний үйлдвэрлэл нь байгаль орчны аюулгүй байдал, нийгмийн хариуцлага, чанар, технологи, шинэчлэлт, бүтээмж, дизайн, хэв маягаараа ямагт тэргүүлсээр байна.

Европын арьс ширний үйлдвэрүүд бүтээгдэхүүн үйлдвэрлэх төрлөөсөө хамааран улс орнуудын хэмжээнд ялгаатай байдаг. Франц, Итали, Португал, Испани зэрэг Өмнөд Европын арьс ширний үйлдвэрлэлийн хамгийн тод, онцгой, үнэ цэнэ бүхий төлөөллүүд нь ихэвчлэн жижиг, дунд үйлдвэрлэгчид байдаг. Эдгээр аж ахуйн нэгжүүд ихэвчлэн загварын салбарт арьс шир үйлдвэрлэх чиглэлээр мэргэшсэн байдаг. Мөн Австри, Голланд, Герман, Швед, Их Британи зэрэг төв, хойд Европын улсуудын арьс ширний салбарууд нь ихэвчлэн цар хүрээ ихтэй томоохон компаниудаас бүрддэг.

Европын арьс шир боловсруулах салбарт гол түүхий эд болох үхрийн ширний үйлдвэрлэл 80 гаруй хувийг эзэлдэг бол хонь, ямааны арьс дараагийн гол түүхий эдэд ордог. Европын Холбооны арьс ширний үйлдвэрлэлийн 99 орчим хувийг махны үйлдвэрийн малын дайвар бүтээгдэхүүнийг дахин боловсруулах үйлдвэрүүд эзэлдэг. Орчин үед тансаг зэрэглэлийн, чамин, өвөрмөц төрлийн арьсны хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, үнэ цэн өсөж байна.

Европын арьс ширний зах зээлд уламжлалт ёсоор тавны хоёр хувийг гутлын зах зээл эзэлсэн хэвээр байгаа боловч сүүлийн жилүүдэд арьс ширэн бүтээгдэхүүний тавны нэг орчим буюу 13 хувийг автомашины интерьер зэрэг бусад загварын чиглэлийн эрэлт нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна.

Европын Холбооны арьс ширний үйлдвэрүүд бүх үндсэн төрөл, хэрэглээний чиглэлээр зах зээлийн тэргүүлэх салбаруудад бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Дээд зэрэглэлийн хэрэглэгчдэд нийлүүлэх хувь хэмжээ нь дэлхийн нийт хэрэглээний 25%, дунджаас дээш үнэтэй зах зээлийн 34%-ийг Европын Холбооны улсуудаас нийлүүлж байна. Энэ нь ойролцоогоор 8.0 тэрбум еврогийн үнэ бүхий арьс ширний үйлдвэрлэл, 125 тэрбум еврогийн эргэлтийг бий болгож, 40,000 гаруй компани, 2.0 сая хүнийг ажлын байрыг бий болгож байна. Европ дахь арьс ширний үйлдвэрүүд нь нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийг эрхэмлэн ажилласаар байна.

Үхрийн шир (*B. taurus* ба *B. indicus*), хонь, ямааны арьс зэрэг уламжлалт эх сурвалжийн бус арьсыг тодорхойлоход "чамин арьс" гэсэн нэр томъёог ихэвчлэн ашигладаг. Ялангуяа (<https://www.leather-dictionary.com>) энэ нь дараах үед ашиглагддаг:

малын төдийлөн их хэрэглэдэггүй хэсэг; жишээ нь үхрийн ходоод гэдэсний бусад хэсэг эсвэл төдийлөн мэдэхгүй амьтны арьс, шир; жишээ нь хоёр нутагтан, шувууд, загас, хэвлээр явагчид болон бусад хөхтөн амьтад (сарлаг г.м).

Эхнийх нь малын аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс гаралтай байдаг бол сүүлийнх нь газар тариалан, мал аж ахуй эсвэл зэрлэг амьтдыг агнах (улам хүлээн зөвшөөрөгдөхгүй болж байгаа) байдлаар олж авсан материалуудыг багтаадаг.

Хэдийгээр сарлагийн арьс нь чамин гэж тооцогддог боловч энэ нь чамин зүйлсийн бусад жишээнүүдийн нэгэн адил амьтны тоо толгой цөөн байдагтай холбоогүй юм. Харин сарлаг маш хязгаарлагдмал газар нутагт тархсан (бусад гаршуулсан малаас ялгаатай) бөгөөд хүмүүс энэ амьтныг төдийлөн сайн мэддэггүйтэй холбоотой ажээ.

АРЬС ШИРНИЙ САЛБАР*


*АРЬСАН ЭДЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛЭЭС БУСАД

ЖИЛИЙН ХӨРӨНГИЙН ЭРГЭЛТ 8 ТЭРБУМ

Экспорт: 2.5 тэрбум

Импорт: 1.1 тэрбум

ЕВРОПЫН ХАМГИЙН ТОМ ҮЙЛДВЭРЛЭГЧИД:
тэрбум еврогоор



Нийт ажилчдын тоо 34 500

32% Арьс, гутлын салбарын ажилчдын нь 50-иас дээш насныхан байна



Source: COTANCE & Eurostat



НОМПАНИ

Нэг компанид дунджаар 21 ажилтан

Хүйсийн тэнцвэрт байдал



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ...

Европын холбооны арьс ширний үйлдвэрлэлийн 99% нь амьтны гаралтай бүтээгдэхүүнээр дахин боловсруулалт хийдэг

*Арьс шир, гутлын үйлдвэрүүдийн мэдээллийг нэгтгэсэн

Зураг 1. Арьс ширний үйлдвэрлэлийн ерөнхий зураглал

2.3 Импорт/экспорт

Олон улсын арьс ширний худалдааны томоохон төлөөлөгчийн хувьд Европ нь дэлхийн арьс ширний үйлдвэрлэлийн 25 орчим хувийг эзэлж, арьс ширэн бүтээгдэхүүний хамгийн том, байнгын эрэлттэй, хэрэглээ нь өсөж байдаг зах зээлийн нэг гэдгээрээ олон улсын арьс ширний бизнесийн салбарын тэргүүлэгч байсаар байна.

8 орчим тэрбум еврогийн эргэлттэй 2,000 гаруй компани, 40,000 орчим хүн тус салбарт ажиллаж байна. Европын арьс ширний үйлдвэрүүд дэлхийн зах зээлд⁴ өрсөлдөх чадвараар тэргүүлсээр байна. Европт үйлдвэрлэсэн арьс ширийг хамгийн өндөр стандарт, экологийн нарийн чанд шалгуураар экспортлодог учир дэлхийн өнцөг булан бүрд үйлдвэрлэгч, хэрэглэгчид хүлээн зөвшөөрч, ихээхэн сонирхдог.

Европын арьс ширний үйлдвэрүүд үхэр, тугалын болон (хонь, ямааны арьстай хамт) бүх төрлийн арьс ширийг эртний уламжлалтай, өвөрмөц чамин хийцээс эхлээд хувцасны арьс хүртэл боловсруулж төрөл бүрийн материал үйлдвэрлэж байна. Европын арьс шир, хувцас үйлдвэрлэгчдийн туршлага, өргөн мэдлэгийг олон улсын томоохон үзэсгэлэн яармагууд⁵ дээрээс харж болно. Дараах тоон үзүүлэлт нь олон улсын зах зээлд Европын арьс ширний эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

⁴ <https://www.euroleather.com/about-us/european-leather-industry#>

⁵ Арьс дээрх ноос/үс боловсруулах үйл явцыг тодорхойлоход ашигладаг.

Сүүлийн жилүүдэд Европын орнуудад боловсруулсан арьс ширний экспорт дэлхийн өнцөг булан бүрд мэдэгдэхүйц өссөн байна. Европын арьс ширний үйлдвэрлэлд ихэвчлэн жижиг, дунд үйлдвэрлэл зонхилдог. Шинэ, хөгжиж буй зах зээл дэх үйлдвэрлэгчид бизнесийн харилцаа холбоогоо хөгжүүлэх, Европын арьс ширний үйлдвэрлэгчидтэй нягт хамтран ажиллах сонирхолтой байдаг тул уян хатан байдал, дасан зохицох чадвар, эрэлт хэрэгцээнд хариу үйлдэл үзүүлэх уян хатан байдал зэрэг нь салбарын хамгийн чухал зарчим байдаг. Даян дэлхийн бизнесийн орчинд найдвартай түншлэлийг бий болгоход томоохон компаниуд технологийн хөгжлийн тэргүүн эгнээнд алхах чадавхаараа бусдаас давуу талтай байдаг. Эдгээр нь харилцагчийн үйлчилгээ, технологийн манлайлал, дизайн, чанар, загвар, маш сайн түүхий эдтэй байдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, Европын арьс ширний үйлдвэрлэгчдийн хүч чадалд бодитой хувь нэмэр оруулж, тасралтгүй шинэчлэгдэх, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, экспортыг дэмжих зэргээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь Европын бизнесүүд ирээдүйгээ итгэлтэйгээр харах боломжийг олгодог.


"Арьс ширэн эдлэл" гэсэн нэр томъёог (заримдаа "арьс ширэн бүтээгдэхүүн") үндсэн гурван ангиллаас (гутал, хувцас, бүрээс) гадна арьсаар хийсэн бусад олон зүйлийг тодорхойлоход ашигладаг.

Арьсан дагалдах хэрэгсэл гэх тодорхой ангилалд дараахь зүйлс орно.

- гар цүнх, түрийвч, цүнх, үүргэвч гэх мэт,
- бүс ба (цагны) оосор,
- малгайбээлий

"Арьс ширэн эдлэл" гэсэн нэр томъёог ерөнхийдөө бүх "арьс ширэн бүтээгдэхүүн"-ийг тодорхойлоход янз бүрээр ашигладаг. Төөрөгдөлд оруулахгүйн тулд зөвхөн "арьс ширэн эдлэл" ба "арьс ширэн бүтээгдэхүүн" гэсэн нэр томъёог ашигласан болно.

Европ бол арьсан эдлэлийн дэлхийн хамгийн чухал, томоохон импортлогчдын нэг юм. Европ руу импортлолсон арьсан эдлэлийн өртөг 2013 онд 6.0 тэрбум евро байсан бол 2018 онд 8.6 тэрбум еврод хүрч өссөн байна.




Source: Eurostat

Зураг 2. Европ руу импортлодог арьсан эдлэлийн импортын хэмжээ (тэрбум.евро).

2020 онд Хятад улс дэлхийн нийт экспортолсон арьс ширэн бүтээгдэхүүний үнийн дүнгийн 30.3 хувийг эзэлж экспортоороо дэлхийд тэргүүлж байна. Европын уламжлалт арьс ширний үйлдвэрийг тэргүүлдэг Франц, Итали улсууд дэлхийн экспортын үнийн дүнгийн 14.8 хувь, 17.8 хувийг тус тус эзэлж байна.


Европын Холбоо нь арьс ширэн дагалдах хэрэгслийн томоохон экспортлогч юм. 2018 онд 13.9 тэрбум еврогийн арьсан эдлэл экспортолсон нь 2013 оноос 9.6 тэрбум еврогоор өссөн байна. Европын Холбооны арьс ширэн дагалдах хэрэгслийн экспорт жилд дунджаар 7.6%-иар (2013-2018 оны хооронд) өссөн байна. 2018 онд Европын Холбооны хамгийн том экспортлогчид болох Итали, Франц улсуудын экспортын хэмжээ 6.2 тэрбум

евро, 4.3 тэрбум еврод тус тус хүрсэн байна. Дээр дурдсан хоёр улс нь Европын Холбооны арьсан эдлэлийн экспортын 76 гаруй хувийг үйлдвэрлэн бэлтгэдэг юм. Голланд улс энэ бүлгийн экспортын хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн бөгөөд жилд дунджаар 16.0%-иар өссөн байна. Одоогийн байдлаар Европ дахь арьс ширний эдлэлийн 9 дэх том экспортлогч болох Польш улс жилд дунджаар 21.0%-ийн өсөлттэй байна.



Зураг 3. Европоос экспортлодог арьсан эдлэлийн экспортын хэмжээ (тэрбум.евро).

Дараах зурагт Европын хамгийн чухал (арьс үйлдвэрлэгч) орнуудын бүтээгдэхүүний эргэлт, компаниудын тоо, ажилчдын тоог харуулав (эх сурвалж: COTANCE, Европын арьс шир үйлдвэрлэгч, хувцас үйлдвэрлэгчдийн үндэсний холбоодын нийгэмлэг)




Зураг 4. Европ дахь арьс ширний үйлдвэрүүдийн тойм зураглал; 2019.

2.4 Өрсөлдөөний шинжилгээ

Тус салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдийн тоо нэмэгдэж байгаа нь арьс ширний зах зээлийг Европт хөгжүүлэх гол хүчин зүйл болж байна. Франц, Итали, Их Британи зэрэг Европын орнуудад голчлон загварын салбар зонхилсон арьсан эдлэлийн үйлдвэрлэл

нэмэгдэж байна. Хэрэглэгчийн амьдралын хэв маягийн өөрчлөлт, орлогын өсөлт нь зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Европын Холбооны зөвлөлөөс арьсан гутлын салбар нь арьс ширний үйлдвэрлэлийн хамгийн том хувийг эзэлдэг гэсэн судалгааг гаргасан байна. Уян зөөлөн, хөнгөн жинтэй бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ хурдацтай өсөж байгаа тул олон тооны инноваци, технологийн дэвшил нь Их Британи дахь бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн эрэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Арьсан гутал нь бат бөх, сэтгэл татам чанараараа давуу талтай бөгөөд энгийн загварын гутлаас гадна үйлдвэрлэлийн зориулалттай, эдэлгээ даах чанартай, бат бөх гутлын хэрэглээ ч нэмэгдэх хандлагатай байна. Арьсан гутлыг ямар ч нөхцөлд өмсөж хэрэглэх боломжтой байдгаараа хэрэглэгчдийн дунд эрэлт ихтэй байдаг.

АРЬСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ%, ЕВРОПЫН УЛС ОРНУУД, 2021



Source: Mordor Intelligence



Зураг 5. Европын улс орнуудад арьсан бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувь (%);

Арьс ширний зах зээл нь маш өрсөлдөөнтэй бөгөөд цөөн хэдэн гол тоглогчтой. Үүнээс LVMH, Chanel, Hermes зэрэг компаниуд зах зээлийн гол тоглогчдын дунд хамгийн идэвхтэй байдаг. Samsonite, Prada, Bata зэрэг томоохон компаниуд бүтээгдэхүүнийнхээ төрлийг нэмэгдүүлж, Европын зах зээл дэхь оролцоогоо улам өргөжүүлж байна. Зах зээлээ тэлж, бараа бүтээгдэхүүнээ өргөжүүлэх нь салбартаа тэргүүлэгч болоход баримтладаг гол стратеги юм. Гол тоглогчид нь өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, зах зээлийн хөгжлийн стратеги бэхжүүлэхийн тулд өөрсдийн үйлдвэрлэлийн байгууламж болон жижиглэн худалдааны цэгүүдийг өргөжүүлэх шаардлагатай.

2.5 Бөөний үнэ

Уламжлалт хромын идээлэгтэй түүхий эд, арьс ширэн бүтээгдэхүүн олон улсын зах зээлд өргөн түгээмэл байдаг тул үнэ өртөгийн судалгаанууд олдоц ихтэй. 2020 оны цар тахал болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр үнийн өсөлттэй нүүр тулсан. Сарлагийн арьсан бүтээгдэхүүн тэр тусмаа ургамлын идээлэгтэй бараа бүтээгдэхүүний худалдаа борлуулалтын үнийг тогтвортой барихад ч мөн хүндрэлтэй байсан. Учир нь сарлагийн арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд харьцангуй жижиг үйлдвэрүүд зонхилж, цөөн тооны тусгай захиалгууд, онцгой загвар хийцтэй бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ихээхэн үүсч байсан нь үнийн индексийг өсөхөд нөлөөлж байсан.

2.6 Хэрэглэгчийн өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн чиг хандлага

Загварын салбар нь өндөр чанартай дээд зэрэглэлийн, загварлаг, тансаг арьсан бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг бий болгосон. Мөн өндөр орлоготой хүмүүсийн тоо улам нэмэгдэхийн хэрээр томоохон брендүүдийн худалдан авалт өсөж байгаа нь тансаг зэрэглэлийн арьсан бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлсээр байна. Арьсан эдлэл нь онцгой шинж чанартай бөгөөд ихэвчлэн өртөг өндөртэй байдаг. Сүүлийн үед синтетик /хиймэл/ арьсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсээр байгаа бөгөөд дараах хүчин зүйлүүдийг харгалзан хэрэглэгчид сонгон хэрэглэж байна. Үүнд:

- хямд,
- амьтанд ээлтэй,
- бараг бүх өнгөөр үйлдвэрлэх боломжтой,
- гялалзсан, гялгар байхаар үйлдвэрлэх боломжтой,
- чийгтэй даавуугаар амархан цэвэрлэх боломжтой,
- засвар үйлчилгээ бага шаарддаг,
- жинхэнэ арьс шиг амархан язардаггүй
- хэт ягаан туяанд тэсвэртэй.

Эдгээр хүчин зүйлүүд нь хэрэглэгчдийн дунд эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатай байна. Хиймэл арьсан бүтээгдэхүүн ч гэсэн гар аргаар хийгддэг тул жинхэнэ арьс шиг бат бөх. Зах зээл дээр хиймэл арьс шир нь наугахид, веган арьс, холтос даавуу, паалантай хөвөн, дахин боловсруулсан ПЕТ полиэфир зэрэг олон төрөл байх бөгөөд “Pleather”- ийг ихэвчлэн хиймэл арьсаар хийсэн хувцас үйлдвэрлэхэд ашигладаг. Энэ нь хуванцар түүхий эд ашигладгаараа жинхэнэ арьснаас хямд, хөнгөн байдаг. Хиймэл арьс нь амьтанд ээлтэй хуванцарыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь өнөө цагт хэрэглэгчдийн дунд эрэлт үүсгэж буй гол хүчин зүйл нь билээ. Гэвч хиймэл арьсны сул тал нь агаар, чийг нэвтрүүлэх чадвар муутай, өөрөөр хэлбэл “амьсгалдаггүй” учраас чийг татаж эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

Арьсан эдлэл нь бээлий, цүнх, гутал, цаг, тавилга гэх мэт төрөл бүрийн бүтээгдэхүүн байдаг. Хувцасны үйлдвэрлэлд арьс ширний эрэлт нэмэгдэж байгаа нь зах зээлийн өсөлтөд эерэгээр нөлөөлж болох гол хөдөлгөгч хүчин зүйлүүдийн нэг юм. Түүнчлэн, арьс ширний онцгой шинж чанарыг бусад нөөц, материалаас илүүд үздэг нь зах зээл дээрх эрэлт, борлуулалт нэмэгдэхэд нөлөөлдөг.

Хэрэглэгчдийн амьдралын хэв маяг, хэрэгцээ шаардлага өнгөрсөн арван жилийн хугацаанд ихээхэн өөрчлөгдсөн. Хуучин технологи, ялангуяа загварын бүтээгдэхүүн боловсруулах, зах зээлд гаргахад илүү их ашиглагдаж байгаа тул компаниуд бүтээгдэхүүний нэр төрлөөр хэрэглэгчийн хэрэгцээг хангах шинэ боломжийг судалж байна. Шинэлэг бүтээгдэхүүн боловсруулж, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд арьсны гадаргуугийн өнгө үзэмжийг улам сайжруулах боломжтой техник технологийг эзэмших шаардлагатай. Амьдралын хэв маягийн хурдацтай хувьсал, өөрчлөлт, чөлөөтэй зарцуулах орлого нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчид загварын бүтээгдэхүүнд илүү дуртай болж байна. Хэрэглэгчдийн орлого өсөхийн хэрээр амьжиргааны түвшингээ даган загварлаг бараа бүтээгдэхүүн хэрэглэх дуртай болсон байна. Тиймээс өсөн нэмэгдэх ийм хандлага нь зах зээлд үйл ажиллагаа явуулж буй тоглогчдод шинэ боломжийг бий болгож байна.

(Жинхэнэ) арьс, хиймэл арьстай холбоотой ерөнхий тайлбаруудын зарим нь хоорондоо зөрчилдсөн мэт санагдаж магадгүй юм. Гэхдээ ийм төрлийн арьс үйлдвэрлэж болно гэдгийг ойлгох хэрэгтэй, жишээлбэл:

Бага үнэ цэнэ. Хэрэглээний хамгаалалтын бээлийний материал (өөрөөр хэлбэл хаягдал арьс).

Дунд зэргийн үнэ цэнэ. Янзалсан, хямд үнэтэй гутланд зориулсан хэсэг (ердийн арьс, ширнээс)

Өндөр үнэ цэнэ. Өндөр үнэтэй тансаг эд зүйлс үйлдвэрлэхэд зориулагдсан бүрэн ширхэгтэй арьс (арьс, ширний харьцангуй бага хувийг эзэлдэг)

Европын арьс ширний бүтээгдэхүүний өрсөлдөөнтэй зах зээлд био суурьтай арьс гарч ирснээр маалингийн хөвөн эсвэл хөвөн утас (эрдэнэ шиш, далдуу мод, шар буурцаг болон бусадтай хослуулсан) зэрэг байгалийн мяндсан утсаар хийсэн хиймэл арьс нь зах зээлд байр сууриа эзлэсэн үйлдвэрлэгчдийн анхаарлын төвд байсаар байна. Био суурьтай арьс ширний үйлдвэрлэлийн процесс нь экосистемд сөрөг нөлөө үзүүлэхгүй давуу талтай.

Малын арьс өндөр өртөгтэй байгаа нь арьсыг байгалийн хямд өртөгтэй бүтээгдэхүүнээр орлуулах хэрэгцээг бий болгож байна. Дэлхийн хэмжээнд арьс ширэн түүхий эд хомсдолтой, чанарын шаардлага хангахгүй байгаа зэрэг нь арьс ширний үйлдвэрлэлд саад учруулж байна. Зах зээл дээр байгаа зарим төрлийн арьсан эдлэл хямд үнэтэй байдаг. Европын худалдан авагчид хоргүй могой, матар зэрэг мөлхөгч амьтдын чамин, хямд өртөгтэй арьс шир үйлдвэрлэх нийлүүлэгчдийг сонирхож байна. Эдгээр хүчин зүйлүүд нь зах зээлийн өсөлтийг хазаарлаж байна. Үүнээс гадна Европын Холбооны орнууд болон АНУ-ын Засгийн газрын зохицуулалтаар бусад үйлдвэрүүдийн адил олон төрлийн арьс шир идээлэх болон боловсруулах үйлдвэрүүдийг хааж байна. Засгийн газрууд арьс ширний хэрэглээтэй холбоотой хууль, дүрмийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь ирэх жилүүдэд зах зээлийн өсөлтийг хязгаарлах болно. Засгийн газрын бодлого нь хиймэл арьсны шинэ (хуванцар арьс гэх мэт) хувилбаруудыг зах зээлд гаргахад анхаарал хандуулж байна. Технологийн шинэчлэл, мэргэжлийн ур чадвар дутмаг байгаа нь арьсан эдлэлийн зах зээлд томоохон сорилт болж байна. Энэхүү салбарын хөгжилд арьс ширэн бүтээгдэхүүний чанар хамгийн чухал юм.

Арьс ширний хэрэглээ нь амьжиргааны түвшинтэй нягт холбоотой. 1990-ээд оны эдийн засгийн уналтаас хойш дэлхийн хэмжээнд тансаг зэрэглэлийн савхин эдлэлийн хэрэглээ нэмэгдэж Япон, Хятад, Энэтхэгийн жуулчид Европоос энэ төрлийн өндөр чанарын, тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүнийг ихээр худалдан авсаар байна. Энэ нь аялал жуулчлалтай холбоотой экспорт гэж үзэхээс илүү Европын дотоодын хэрэглээнд дээд зэрэглэлийн, чанартай, тансаг бүтээгдэхүүний эрэлт өссөөр байгааг харуулж байгаа юм. Өнөөгийн эдийн засгийн хямрал дуусмагц энэхүү эрэлт хэрэгцээ ойрын таваас арван жилдээ нэмэгдсээр байх төлөвтэй байна.

Иймд өнөөгийн зах зээлийн чиг хандлагад тусгай захиалгаар хийсэн тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь чухал болж байна. Энэхүү салбарт гутал, савхин хувцас хийх ур чадвар, арга туршлага арвин баялаг хэдий ч орчин үед зарим компаниуд тугал, тэмээн хяруул, матар, галучат (акулын арьс), гүрвэл гэх мэт төрөл бүрийн амьтны арьсаар хийсэн цагны оосор, хэтэвч, бүсийг үйлдвэрлэж байна. Мэдээж энэ нь Монгол улсад илүү их боломж олгох талбар болох юм. Монголчуудын уламжлалт нүүдэлчин мал аж ахуйн тогтолцооны нэг хэсэг болсон жил бүр тоо толгой нь өсөн нэмэгдэх сарлагийн арвин нөөц, ургамлын идээлэгт өндөр чанартай бүрэн ширхэгтэй арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүсэл эрмэлзэл нь Монгол Улсын давуу тал, зах зээлийн цоо шинэ боломж юм.

Арьс ширний үйлдвэрлэл цаашид хоёр үндсэн ангилалд хуваагдах төлөвтэй байна.

- Нэг талаас ихэвчлэн тансаг зэрэглэлийн савхин барааны зах зээл нь жинхэнэ мал, амьтны гаралтай чанартай, өвөрмөц чамин арьс, үнэтэй түүхий эд, дагалдах хэрэгсэлтэй хослуулан ашиглах бөгөөд олон улсын болон үндэсний нэр хүндтэй брэнд үйлдвэрлэгчдийн өндөр чанартай бүтээгдэхүүнийг дэлхийн өнцөг булан бүрт, аж үйлдвэржсэн болон хөгжиж буй орнуудын чинээлэг хэрэглэгчдэд өндөр үнээр борлуулах бололцоотой болж байна.
- Нөгөө талаас эсрэгээрээ хямд үнэтэй түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүнийг хямд үнээр ашиглах боломж гарна. Гар цүнхээс бусад бүх савхин эдлэлүүд нь илүү бат бөх, урт удаан хугацаанд ашиглагдахаар үйлдвэрлэгдэх болно. Чемодан, аяллын цүнх, үүргэвч, цүнх, тэр ч байтугай жинхэнэ арьсаар хийсэн эсвэл хиймэл арьсаар

хийсэн жижиг савхин эдлэлүүд үйлдвэрлэгчид болон борлуулагчдын итгэлийг улам бүр нэмэгдүүлнэ.

2.7 Маркетингийн суваг/сүлжээ

Арьс ширний үйлдвэрлэлийн маркетинг нь хэвлэл мэдээллийн суваг, үзэсгэлэн худалдаагаар дамжин олон нийтэд хүрдэг. Брэндүүд маркетингийн үйл ажиллагаагаа үндсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн мэдээллийн сувгуудаар дамжуулан явуулдаг. Түүнчлэн жил бүр өөр өөр улсуудад зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаагаар дамжуулан маркетингийн үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь:

- Линеапел, Итали,
- “Leather World”, Парис,
- “ILM Internationals” Арьсан эдлэлийн үзэсгэлэн, Герман
- Бусад

Сүүлийн жилүүдэд маркетингийн салбарт олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нөлөө хүчтэй болж байна. Брэнд, компаниуд маркетингийн чиглэлээр маш үр дүнтэй сошиал сурталчилгаа явуулдаг нь ажиглагдаж байна. Цахимжсан ертөнцөд нийгмийн сүлжээний нөлөө нэмэгдэх нь ойлгомжтой байна. Түүнчлэн бидний амьдралд саяхан нэвтэрсэн байршлын орчны харилцаа холбооны (NFC) програмууд нь брэндүүдэд бүтээгдэхүүнээ виртуал орчинд туршиж үзэх боломжийг олгодог. Орчин үед өдрөөс өдөрт түргэн хурдацтай хөгжиж буй цахим худалдаа нь маркетингийн салбарт технологийн хөрөнгө оруулалт болж байна. Дэлхийн өнцөг булан бүрд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүний хэрэглээг интернетээр дамжуулан маш хялбар бөгөөд үр дүнтэй сурталчилах боломжтой. Энэхүү технологиор үйлдвэрлэгчид, хэрэглэгчдэд хамгийн бага төсөв, цаг хугацаанд хүрч үйлчлэх боломж бүрдсэн байна.

2.8 Европын онцгой давуу тал/ хязгаарлалттай орнууд, харьцуулсан шинжилгээ

Арьс ширний үйлдвэрлэл нь дэлхий даяар тархсан бөгөөд Европын Холбооны арьс шир үйлдвэрлэгчид дараахь зүйлсээс ихээхэн хамааралтай байсаар байна:

- түүхий эд
- экспортын зах зээл

Европын Холбооны арьс ширний үйлдвэрлэл нь олон улсын зах зээлд хамгийн том нийлүүлэгч хэвээр байгаа боловч Ази, Америк гэх мэт дэлхийн бусад бүс нутагт арьс ширний үйлдвэрлэл хөгжиж, дэлхийн зах зээлд томоохон байр суурь эзэлж байна.

Итали, Францын арьс ширний загварын дагалдах хэрэгслийн худалдаа түргэн хурдацтай хөгжиж байна. Тэдний брэндүүд (жишээ нь: Hermes, Louis Vuitton, Goyard болон Longchamp; мөн Prada, Valextra, Loro Piano зэрэг бусад олон брэндүүд) уламжлалт болон шинэ хэрэглэгчдийн аль алийнх нь сонирхлыг маш их татсаар байна. Герман, Испани, Нидерланд, Их Британи зэрэг нь Европын дотоод болон гадаад зах зээлд өргөн хүрээг хамардаг томоохон зах зээл хэвээр байна.

Баруун Европын зах зээл нь Төв болон Зүүн Европын зах зээлээс илүү том бөгөөд өндөр хөгжилтэй. ЕХ-ны арьс ширний импортын гол зах зээл бол Франц, Итали, Герман, Их Британи, Нидерланд, Испани юм. Эдгээр зургаа нь нийлээд ЕХ-нд импортолж буй арьс ширний 80.7% -ийг эзэлдэг бөгөөд өмнөх таван жилд, жилд дунджаар 7.7%-ийн өсөлттэй байна. Зүүн Европын орнуудын импортын зах зээл барууныхаас өндөр хурдацтай хөгжиж байгаа хэдий ч харьцангуй жижиг хэвээр байна.

2021 онд Европын экспортын 57%-ийг Итали улс эзэлж байна. Түүний араас Герман, Испани, Польш улсууд нийт экспортын 22 хувийг бүрдүүлдэг. Франц, Австри,

Нидерланд, Бельги, Дани зэрэг улсууд нийт экспортын бага хувийг эзэлжээ. ⁶ 2012-2021 онд Итали улсын арьс ширний экспортын жилийн дундаж өсөлт 6.4% байв. Үүний зэрэгцээ Бельги (+6.2%), Польш (+3.6%), Дани (+2.6%) зэрэг улсууд эерэг өсөлт үзүүлсэн байна. Түүнчлэн Бельги нь 2012-2021 онд CAGR +6.2%-иар ЕХ-ны хамгийн хурдацтай хөгжиж буй экспортлогчоор тодорсон. Үүний эсрэгээр Испани (-3.8%), Франц (-5.0%), Австри (-7.4%), Герман (-8.3%), Нидерланд (-11.8%) мөн буурсан үзүүлэлттэй байна. 2012-2021 онд Польш, Бельги, Испанийн экспортын эзлэх хувь +3.7, +1.8, +1.5 тус тус өссөн байна.

2021 онд нийт импортын 65 орчим хувийг Итали улс эзэлсэн. Нийт импортын хэмжээгээр Испани 7%-р хоёрт орж, Польш (5.3%), Португал (4.6%) улсууд дараах байруудыг эзэлжээ. Герман, Румын, Франц улсууд дээрхи улсуудаас харьцангуй хоцорсон үзүүлэлттэй байна. 2012-2021 онуудад Италийн арьс ширний импортын жилийн дундаж өсөлт -3.0% байв. Үүнтэй адилаар Польш (-1.7%), Португал (-2.7%), Испани (-5.3%), Румын (-6.5%), Франц (-6.6%), Герман (-8.2%) зэрэг улсууд бүгд ижил хугацаанд буурах хандлагатай байна. 2012-2021 онуудад нийт импортод эзлэх Италийн байр сууриа мэдэгдэхүйц нэмэгдсэн бол Германы эзлэх хувь 2%-иар буурсан.

Судалгаанд хамрагдсан хугацаанд бусад орны импортын эзлэх хувь харьцангуй тогтвортой байна. Итали нь ЕХ-ны импортын арьс ширний хамгийн том зах зээл бөгөөд нийт үнийн дүнгийн 29%-ийг эзэлдэг. Франц улс нийт дүнгийн 11 хувийг эзэлж жагсаалтын хоёрдугаарт орж Герман улс 8.2%-ийг бүрдүүлсэн байна. Италид арьс ширний импорт 2012-2021 оны хооронд жилийн дундажаар 6.2%-иар буурчээ. Бусад улс орнуудад жилийн дундаж үзүүлэлт нь Франц 1.2%, Герман 7.8%-ийн өсөлттэй байна.

Европын арьс ширний үйлдвэрлэгчид хоёр төрлийн худалдааны саадтай тулгардаг:

- бэлэн арьс ширний экспортод зарим төрлийн саад учирч байгаа
- түүхий эдийн хүртээмж хязгаарлагдсан

Түүхий эдийн хүртээмж хязгаарлагдмал байгаа нь Европын арьс ширний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварт ихээхэн муу нөлөөлж байна.

Европын арьс ширний үйлдвэрлэгчид Европын дотоодын зах зээлээс түүхий эд олж авах нь улам хүндрэлтэй болж байгаа тул бусад бүс нутаг, гадаад зах зээлээс түүхий эдийг авахад ихээхэн анхаарал хандуулж байна. ЕХ-ны гишүүн бус олон орнууд арьс, ширний түүхий эдийг экспортлохыг хориглож, хязгаарлалт тавьдаг. Европын Холбооны зөвлөлийн дэмжиж байгаа Дэлхийн худалдааны байгууллагын бусад гишүүн орнуудаас гаргасан экспортын бүх хязгаарлалтыг бүхэлд нь цуцлах саналын хамт Дэлхийн худалдааны байгууллагын хүрээнд зах зээлийн хүртээмжийг сайжруулах ажил нэн тэргүүнд хүлээгдэж байна. Европын Холбоо нь 2008 онд Европын үйлдвэрүүдийн шаардлагатай түүхий эдийг шуурхай хангах зорилгоор "Европын түүхий эдийн хэрэгцээний өсөлт, ажлын байрыг хангах санаачилга" гэсэн нэгдсэн стратегийг боловсруулан гаргасан.

Итали, Францыг дэлхийн болон Европын загварын зүрх, өлгий ч гэж нэрлэдэг. Энэ нь үйлдвэрлэл, худалдааны хувьд давуу талыг авчирдаг боловч өрсөлдөгч Хятадын үйлдвэрлэлийн хүчин чадал өндөр, үнэ хямд байгаа нь эдгээр орнуудын хувьд ихээхэн сул тал болдог.

⁶ ЕХ-ны арьс ширний зах зээлийн тайлангийн шинжилгээ ба 2020 он хүртэлх таамаглал, Indexbox, <https://www.indexbox.io/store/eu-leather-market-report-analysis-and-forecast-to-2020/>

2.9 Зорилтот зах зээлийг боломжид нь үндэслэн сонгох

Өмнөх хэсгүүдэд өгөгдсөн бүх мэдээлэл нь хамгийн түгээмэл түүхий эдийг ашиглан үйлдвэрлэсэн арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүнтэй холбоотой. Тухайлбал:

- үхрийн арьс шир (Бос таурус, Б. индикус) мөн тугалын арьс
- арьс (Овис ба Капра төрөл зүйл) түүний дотор хурга, ишигний жижиг арьс.

Зарим чамин зүйлсийг эс тооцвол эдгээр нь арьс ширний үйлдвэрт хэрэглэгддэг түүхий эдийн ихэнх хэсгийг бүрдүүлдэг.

Хүснэгт 2. Арьс ширний үйлдвэрлэлийн түүхий эдийн төрөл⁷

Эх сурвалж	Бүх арьс ширний эзлэх хувь %
Үхэр	65
Хонь/Хурга	15
Гахай	11
Ямаа/Ишиг	8
Бусад	1

Дээр дурдсан мэдээллийн дийлэнх нь эрдэс, ялангуяа хромын исэл ашиглан идээлэх арьс ширтэй холбоотой бөгөөд ургамал ашиглан идээлэх арьс нь дэлхийн нийт бүтээгдэхүүний дөнгөж 10 орчим хувийг эзэлдэг. Ийм учраас ургамлын идээлэгтэй сарлагийн арьс нь дэлхийн арьс ширний үйлдвэрлэлийн маш бага хувийг эзэлж байна.

- ашигласан түүхий эд болон
- хэрэглэсэн идээлэх арга.

Арьс ширний дийлэнх хэсгийг гутал, хувцас үйлдвэрлэлд их хэмжээгээр хэрэглэдэг атал ургамлын идээлэгтэй арьс, ялангуяа сарлагийн арьсаар хийсэн нь маш бага бөгөөд ховор зах зээл юм. Ирээдүйн худалдан авагчид ургамлын идээлэгтэй сарлагийн арьс, савхиар хийсэн гутал хувцас нь эрдэст идээлэгтэй үхрийн арьсан хувцаснаас илүү сайн байдаг гэж сонгон хэрэглэх эсэх нь эргэлзээтэй юм. Харин чанарын ялгаа, давуу талы олж мэдсэн цагт худалдан авах сонирхол эрэлт нэмэгдэх магадлалтай. Үүнд:

- Анхдагч үйлдвэрлэл; Бэлчээрийн ургамал иддэг, цаг агаарын эрс тэс нөхцөлд амьдрах чадвартай хагас зэрлэг (нүүдлийн) мал аж ахуй.
- Хэв маяг/зураглал; чөлөөтэй, Малын чанар, үүлдэр угсааг байнга сайжруулдаг.
- Боловсруулалт; Химийн бус байгалийн (уламжлалт), аргаар бэлддэг.
- Байгаль орчинд ээлтэй, тогтвортой.

Ургамлын идээлэгтэй сарлагийн арьс нь маш олон сонирхолтой, өвөрмөц шинж чанартай тул түүнийг эрдэст идээлэгтэй арьстай харьцуулах шаардлагагүй ч гэсэн мэдээлэл дутмагаас үүдэн зарим сөрөг үр дагавар гарч болох юм.

- **"Сарлагийн арьс бусад арьснаас илүү бат бөх"**. Бусад арьснаас илүү бат бөх гэсэн нотолгоог хаана байна вэ? Суналт болон уян хатан чанар хэр зэрэг вэ?
- **"Сарлагийн арьс бусад арьснаас илүү эдэлгээ сайтай."** Гэхдээ ихэнх арьс нь удаан эдэлгээтэй байдаг тул сарлагийн арьс илүү бат бөх байсан ч хэр илүү удаан эдэлгээтэй байдаг вэ? Нотлох баримт хаана байна вэ? Хэрэв ялгаа байгаа бол энэ нь үнэхээр үнэн магадтай юу?
- **"Сарлагийн арьс бусад арьснаас илүү чанартай."** Аль талаараа илүү дээр вэ? Эрэгтэй гутал үйлдвэрлэхэд илүү тохиромжтой юу, нотлох баримт нь хаана байна вэ?

⁷ <https://www.carlfriedrik.com/int/magazine/what-is-leather-made-out-of>

Чанарын хамгийн сайн тодорхойлолт нь "зорилгодоо нийцэх байдал" гэж хүлээн зөвшөөрвөл ургамлын идээлэгтэй сарлагийн арьс үйлдвэрлэгчид түүний өвөрмөц шинж чанар, давуу талыг ирээдүйн худалдан авагчдад сайтар ойлгуулах хэрэгтэй.

Үүнд:

- Урт удаан хугацаанд хэрэглэхэд бат бөх, сэтгэл ханамж, таашаал өгөх байгалийн шинж чанар давуу.
- Сарлагийн бүтээгдэхүүн нь уламжлалт амьдралд хамгийн тохиромжтой, үр ашигтай байсаар ирсэн.
- Бага хэмжээгээр, ихэвчлэн гараар, органик материалаар, онцлог байдлаар үйлдвэрлэсэн байгалийн материал

Дэлхий даяар ургамлын идээлэгтэй сарлагийн арьс нь арьс ширний үйлдвэрлэлд маш бага хувийг эзэлдэг хэдий ч энэхүү онцгой, өвөрмөц шинж чанар, ач холбогдолтой бүтээгдэхүүний талаар дэлхийн зах зээлийн мэдээлэл маш бага байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Гар аргаар боловсруулсан, ургамлын идээлэгтэй арьс шир ба арьсан бүтээгдэхүүнүүд нь жуулчдад зориулсан бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэхэд ихээхэн тохиромжтой байдаг. Ургамлын идээлэгтэй сарлагийн арьсыг Монголд боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь арилжааны ач тустай байх юм. Монголд үйлдвэрлэсэн арьс ширний дийлэнх хэсгийг өв уламжлалаа хадгалсан гар урлал, загварын төрөл зүйлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглахад илүү давуу талтай. Бүтээгдэхүүнийг Европ, ялангуяа Франц, Италийн дээд зэрэглэлийн болон тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүнтэй харьцуулан судалж тэдний маркетинг, зах зээлийн эрэлтэд нийцүүлж чадвал илүү үр дүнтэй байх болно .

3. МОНГОЛООС ЕВРОПЫН ОРНУУД РУУ ЭКСПОРТОД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

3.1 Бүртгэл, тусгай зөвшөөрлийн процесс

3.1.1. Ерөнхий мэдээлэл

Европын Холбооноос жижиг, эмзэг эдийн засагтай, далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын худалдаанд учирч байгаа бэрхшээлийг онцлон авч үзэж, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг дэмжих чиглэлээр явуулж буй худалдааны бодлого болох Хөнгөлөлтийн ерөнхий систем / ХЕС /-ийн шинэ журмаар “сайн засаглал, тогтвортой хөгжлийн” болзлыг хангасан эмзэг эдийн засагтай орныг ХЕС-т хамруулж, 7,200 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх шинэ хөнгөлөлтийг /GSP+/ бий болгосон.

Тус Хөнгөлөлтийн ерөнхий систем буюу GSP+-ийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй 7,200 бараа бүтээгдэхүүн гаалийн тарифын хөнгөлөлт эдэлдэг. Энэхүү хөнгөлөлтийг гарал үүслийн гэрчилгээ, шууд тээвэрлэх нөхцөл боломж, баримт бичгийн баталгаажуулалтын үндсэн дээр эдлэх боломж үүсэх тул холбогдох баримт бичгийг нөхцөл, журмын дагуу бүрэн бүрдүүлэх шаардлагатай юм.

Савхи бол байгалийн гаралтай материал бөгөөд үүнийг хийсэн арьс ширний адил олон талаараа харилцан адилгүй байдаг. Тугалын арьс, үхрийн шир, бухын арьс нь физик, химийн найрлагаараа эрс ялгаатай. "Ижил төстэй" үхрийн арьс хүртэл нэг нь нөгөөгөөсөө ялгаатай байдаг. Түүнээс гадна нэг ширний хувьд ч байршлаасаа хамааран физик, химийн найрлага өөр өөр байх нь бий. Эдгээр ялгааг (зарим үхэр, хонь, ямааны хувьд) сайтар судалж, энэ талаар нийтэлжээ. Арьс ширний сайн технологичийн нэг ажил бол арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд илүү нийцтэй материалаар хангах, арьс ширийг идээлэн боловсруулах явцад эдгээр ялгааг багасгахыг хичээх явдал юм. Гэсэн хэдий ч ялгаа байсан хэвээр байгаа тул, ялангуяа сарлагийн арьсны физик, химийн шинж чанарын талаар нийтлэгдсэн мэдээлэл бага эсвэл огт байхгүй тохиолдолд "А арьс" нь "В арьс" -аас илүү бат бөх гэж хэлэхэд хэцүү юм.

Монгол Улс баримтлах шаардлагатай олон улсын стандарт, хууль тогтоомжид тааруулах нь GSP+-ийн хөнгөлөлт эдлэх суурь болох юм. Эдгээрийн ихэнхийг Монгол Улсын Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн худалдааны тухай хууль, тогтоомжийн 1-р хавсралтад тусгасан болно.

Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлд зааснаар мэдүүлэгч буюу экспортлогч нь гаалийн мэдүүлэгтээ барааны дагалдах бичиг баримтыг хавсаргаж гаалийн байгууллагад өгөх үүрэг хүлээдэг ба үүнд гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, тээврийн бичиг баримт, тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг болон хуульд заасан бусад баримт бичгийг бүрдүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагаа хамаардаггүй байна.

Дээрх хууль тогтоомжийн дагуу хаана, хэрхэн хандаж, ямар гэрчилгээ буюу баримт бичгийг бүрдүүлэх талаар дор тайлбарлав.

3.1.2. Мал, амьтны гаралтай түүхий эдийн экспортын гэрчилгээ авах

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн экспортлоход экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх шаардлага тавигддаг.

Уг гэрчилгээг авахдаа:

- Гаалийн ерөнхий газрын цахим системд нэвтрэх;
- Үйлчилгээний талаарх мэдээлэлтэй танилцах;
- Үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрөх;
- Үйлчилгээний хүсэлтийг илгээх;
- Хүсэлтийн үр дүнг хүлээн авах дарааллын дагуу хандах ба дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
 - Гаалийн ерөнхий газарт хандсан албан хүсэлт;
 - Хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар;
 - Худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг /Англи хэлээр бичигдсэнээс бусад тохиолдолд монгол хэл дээр баталгаат орчуулгаар орчуулсан байх/;
 - Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ /Мал эмнэлгийн ерөнхий газар/;
 - Арилжааны гэрчилгээ
 - Сав баглаа, боодлын мэдээлэл /тоо хэмжээ/ Англи хэлээр/;
 - Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
 - Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл;
 - Арьс, шир, ноос, ноолуурыг боловсруулсан газрын тодорхойлолт, стандартын шинжилгээний дүн /шаардлагатай тохиолдолд/;

Хүсэлт шийдвэрлэх хугацаа: хуульд зааснаар 14 хоног, ихэнхдээ ажлын 7 хүртэлх хоног

3.1.3. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авах

Мал, амьтны эрүүл мэнд, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн баталгаажуулалтын мал эмнэлгийн гэрчилгээ нь дотоодод "мал эмнэлгийн гэрчилгээ", олон улсын худалдаанд "олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ" байх бөгөөд цахим болон хэвлэмэл хэлбэртэй байна.

Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлогч иргэн, хуулийн этгээд нь хүсэлтээ дор дурдсан мэдээлэл, баримт бичгийн хамт мал эмнэлгийн байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт, мал эмнэлгийн гэрчилгээ;
- Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг;
- Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;
- Хүсэлт гаргагч нь мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа;
- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, хэмжээ, боловсруулалтын байдал (хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, хөргөсөн, шинэ гэх мэт), савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл;
- Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил;

Мал эмнэлгийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн мэдээлэл, хүсэлт, Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл, экспортлогч орны халдварт өвчний мэдээллүүдийг үндэслэн импортлох мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг олгох эсэхийг шийдвэрлэнэ.

Хүсэлт шийдвэрлэх хугацаа: хууль зааснаар 14 хоног, ихэнхдээ ажлын 2-3 хүртэлх хоног байдаг.

Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш амьд мал, амьтанд 1 сар хүртэл, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд 5 дугаар сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 31-нийг хүртэлх хугацаанд 21 хоног, 10 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 4 дүгээр сарын 30-ныг хүртэлх хугацаанд 30 хоног хүчинтэй байна.

Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрчилгээ олгосон байгууллага хүчинтэй байх хугацаандаа гэрчилгээг хүчингүй болгох эрхтэй гэдгийг анхаарах нь чухал:

- экспортлож буй улс орон, бүс нутагт мал, амьтны худалдааны хорио цээрт өвчин гарсан,
- хүн, малын эрүүл мэндэд эрсдэл үүсэх нөхцөл үүссэн үед гэрчилгээг олгосон байгууллага хүчингүй болгож болно.

3.1.4. Гарал үүслийн гэрчилгээ

Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлд зааснаар мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор тодорхой баримт бичгийг гаалийн байгууллагад гарган өгөх үүрэгтэй байдаг ба үүнд хилээр нэвтрүүлэх барааны гарал үүслийг нотлох баримт бичиг буюу гарал үүслийн гэрчилгээ хамаарна. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь хэсэгт зааснаар МҮХАҮТ нь барааны гарал үүслийг гэрчлэн гэрчилгээ олгодог.

Манай улс дэлхийн өндөр хөгжилтэй 37 /Австрали, Беларус, Канад, Япон, Шинэ Зеланд, ОХУ, Норвеги, АНУ, Турк, Лихтенштейн болон Европын Холбооны улс орноос Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу худалдааны болон гаалийн тарифын хөнгөлөлт

эдэлдэг. Энэхүү хөнгөлөлтийг Гарал үүслийн гэрчилгээ⁸ FORM A-ын үндсэн дээр авдаг байна. Уг үйлчилгээг авахдаа

- МҮХАҮТ-ын цахим хуудас дахь гарал үүслийн гэрчилгээ хэсэгт хандан <http://certorigin.membership.mn:8080/front/garaluuselReg> холбоосын дагуу хүсэлтээ илгээх;
- Цахим шуудангийн хаягаар нэхэмжлэх хүлээн аваад төлбөр төлөх;
- Цахим шуудангийн хаягаар гэрчилгээ бэлэн болсон тухай мэдэгдэл очсоны дараа ирж гэрчилгээгээ авах дарааллын дагуу хандах ба дараах баримт бичгийг бүрдүүлнэ:
 - Гадаад худалдааны гэрээний хуулбар /бараа худалдах, худалдан авах/;
 - Үнийн нэхэмжлэх, Сав баглаа боодлын жагсаалт /Invoice, Packing list/;
 - Тухайн компани, аж ахуйн нэгжийн хүчин төгөлдөр бүхий улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хувь хүний хувьд иргэний үнэмлэхний хуулбар;
 - Тухайн бараанд авсан тусгай зөвшөөрөл болон чанар, эрүүл ахуйн гэрчилгээний хуулбар гэх мэт.

Хүсэлт шийдвэрлэх хугацаа: хүсэлт амжилттай илгээгдсэнээс хойш 1-2 цаг

3.1.5. Экспортын тохирлын гэрчилгээ авах

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.11.-т зааснаар "тохирлын гэрчилгээ" гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцсэнийг тодорхойлсон баримт бичгийг ойлгох бөгөөд дараах баримт бичгийг Стандарт, хэмжил зүйн газарт гарган өгч гэрчилгээг авна. Үүнд

- Иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл /маягт 1-ийн дагуу;
- Иргэний үнэмлэхийн/хувь хүн/ буюу аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Худалдах, худалдан авах гэрээ;
- Бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн дүнгийн мэдүүлэг;
- Бүтээгдэхүүнд сорилт, туршилт хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;

Хүсэлт шийдвэрлэх хугацаа: 2 цаг

Дүгнэлт: Дээр дурдсан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу экспортлогч нь Гаалийн ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Мал эмнэлгийн ерөнхий газар зэрэг байгууллагатай цахимаар болон бичгээр харилцан хүсэлт гаргах ба нийт 7 хүртэлх өдрийг дээрх баримт бичиг бүрдүүлэх үйл ажиллагаанд зарцуулах төлөвтэй байна.

3.2 Гаалийн хяналт, шалгалтын үйл явц

Экспортлогч аж ахуйн нэгж аливаа бараа бүтээгдэхүүнийг экспортод гаргах үйл ажиллагаанд

- 2008 онд батлагдсан Монгол Улсын Гаалийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон
- Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих

⁸ Гарал үүслийн гэрчилгээ нь гаалийн бүрдүүлэлтэд шаардагддаг бөгөөд худалдаа арилжааны нэхэмжлэх дээр гарал үүслийн тухай мэдээлэл тодорхой байх хэрэгтэй.

нийтлэг журам”-ыг баримтлан гаалийн улсын байцаагч холбогдох хяналт, шалгалт хийнэ.

Ингэхдээ экспортлогч аж ахуйн нэгж хуульд заасан гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн байх шаардлагатай. Гаалийн бүрдүүлэлт гэдэг нь гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн үеэс гаалийн бичиг баримтыг, шаардлагатай тохиолдолд барааг шалгах, ногдуулсан татварыг төлсний дараа барааг олгох, эсхүл гаалийн хилээр гаргахыг зөвшөөрөх хүртэлх цогц үйл ажиллагааг хэлдэг.

- гаалийн байгууллагад бараагаа мэдүүлэх,
- шаардлагатай гаалийн бичиг баримтыг бүрдүүлэх,
- барааны үзлэг шалгалтад хамрагдах (шаардлагатай бол),,
- холбогдох татварыг төлөх
- барааг хилээр гаргах гаалийн зөвшөөрөл авах.

Монгол Улсын Гаалийн байгууллагын албан ёсны мэдээллийн дагуу экспортын гаалийн бүрдүүлэлт дараах үе шаттай явагдана:

- Мэдүүлэх
- Гаалийн бичиг баримтыг шалгах;
- Бараа, тээврийн хэрэгслийг шалгах;
- Гаалийн болон бусад татварыг ногдуулж, барагдуулах;
- Гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх

“Мэдүүлэх” гэдэгт гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаарх шаардлагатай бүх мэдээллийг гаалийн мэдүүлгийн маягтын дагуу бичиж, холбогдох бичиг баримтын хамт гаалийн байгууллагад өгөхийг ойлгоно.

Гадаад худалдаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж экспортын барааны мэдээллийг гаалийн байгууллагад мэдүүлэхдээ “Гаалийн цахим үйлчилгээний систем” /www.gaali.mn/-д хандаж “Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг” /цаашид “гаалийн мэдүүлэг” гэх/-ийг цахимаар нөхөн бичнэ. 2021 оны 4-р улирлаас эхлэн гаалийн байгууллагад экспорт, импортын бүтээгдэхүүнийг мэдүүлэхээс татвар төлөх хүртэлх үйл ажиллагаа бүрэн цахимжсан.

Бүтээгдэхүүн экспортлогч нь “Гаалийн цахим үйлчилгээний систем” /www.gaali.mn/-д байрлах мэдүүлгийн маягыг бөглөн бараагаа мэдүүлэх бөгөөд дагалдах бичиг баримтыг “PDF” файлаар хавсаргаж илгээнэ. Иргэн, аж ахуйн нэгжээс илгээсэн гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллага цахимаар хүлээн авч гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийг хийх бөгөөд бичиг баримтын болон экспортын бүтээгдэхүүний холбогдох шалгалтыг хийсний дараа татварын нэхэмжлэлийг цахимаар хүргүүлж төлбөр тооцоо хийх боломжтой болсон.

Гаалийн цахим үйлчилгээний системд экспортын барааны гаалийн мэдүүлэг хийх үйл явц дараах процессын дагуу явагдана.

1. Системд нэвтрэх	Гаалийн цахим үйлчилгээний системд нэвтрэхийн тулд нэг удаагийн нууц үг, цахим гарын үсэг, эсвэл интернэт банкны аль нэгийг сонгоно.
2. Онлайнар мэдүүлэг бөглөх	Өгөгдсөн маягтын шаардлагатай хэсгүүдийг бөглөж хил гаалиар нэвтрүүлэх гэж буй бараа бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийн баримт бичгийг цахим хэлбэрээр хавсаргана.
3. Цахим мэдүүлгүүдийг хүлээн авч тараах	Системээр дамжин ирсэн өргөдөл хүсэлтийг хүлээн авч хянах байцаагч нь дагалдаж буй бичиг баримтын үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хариуцна.
4. Гаалийн хяналтын бүсийн шалгалт	Баримт бичгүүд, бараа бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслүүдийг хяналт шалгалтаар оруулж татвар авна.
5. Гаалийн болон бусад татвар төлөх	Гаалийн байцаагчийн ноогдуулсан татвар, хураамжийг төлөх шаардлагатай.

6. Хяналт шалгалт, баталгаажуулалт	Шаардагдах гаалийн хяналт шалгалтанд хамрагдсаны дараа экспортлохыг зөвшөөрнө.
------------------------------------	--

Гаалийн цахим үйлчилгээний системд иргэн:

- нэг удаагийн код ашиглан эсхүл
- интернэт банкны эрхээр нэвтрэн үйлчилгээ авна.

Харин аж ахуйн нэгж, байгууллага зөвхөн “Байгууллагын тоон гарын үсэг” ашиглан системд нэвтэрнэ.

Системд нэвтэрсний дараа гаалийн мэдүүлэг бөглөхдөө бараатай холбоотой дараах 4 мэдээллийг оруулж мэдүүлгийн маягтыг бөглөнө. Үүнд:

- Үндсэн мэдээлэл
- Ачаа эргэлтийн мэдээлэл
- Бараа бүтээгдэхүүний мэдээлэл
- Бичиг баримтын мэдээлэл

Үндсэн мэдээлэл. Энэ хэсэгт худалдах, худалдан авахтай холбоотой хэлцлийн мэдээлэл оруулах бөгөөд дараах талбаруудыг бөглөн хадгалах товчийг дарж үргэлжлүүлснээр дараагийн алхамд шилжинэ.

Талбарын нэр	Тайлбар
Гаалийн бүрдүүлэлт	Гаалийн бүрдүүлэлт эсвэл Импорт/Экспортын аль тохиромжтой нэг сонголтыг хийнэ.
Мэдүүлгийн төрөл	Системд тодорхойлсон төрлүүдээс сонгоно.
Бүрдүүлэлтийн горим	Системээс тодорхойлсон төрлүүдээс сонгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг https://gaali.mn/categories/procedure холбоосоор авах боломжтой.
Гаалийн байгууллага	Барааг мэдүүлэх гаалийн байгууллагыг сонгоно.
Мэдүүлсэн огноо	Барааг гаалийн байгууллагад мэдүүлж байгаа он, сар, өдрийг сонгож оруулна.
Илгээгч	Эхний талбарт барааг илгээгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний харьяалагдах улсын нэрийг сонгож оруулна. Нэр хэсэг дээр барааг илгээгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэрийг нөхөн бичнэ. Илгээгч иргэний нэр, хаягийг кирилл үсэгт хөрвүүлэх шаардлагагүй бөгөөд, эхний үсгийг томоор бусад үсгийг жижгээр бичнэ. Жишээ нь: Erlian Jiayu Trading Co.,Ltd г.м Мөн хаяг, утас зэрэг мэдээллийг бичиг баримтыг үндэслэн бичнэ.
Илгээгч улс	Тээврийн бичиг баримтад бичигдсэнээр бараа бүтээгдэхүүнийг илгээгч улсыг сонгоно.
Хүлээн авагч улс	Тээврийн бичиг баримтад бичигдсэн барааг хүлээн авагч улсыг сонгоно.
Санхүүгийн хувьд хариуцагч	Гадаад худалдааны төлбөр тооцоо хийсэн санхүүгийн хувьд хариуцагчийн регистрийн дугаар, нэр, банкны нэр, дансны дугаар, хаягийн мэдээллийг оруулна. Санхүүгийн хувьд хариуцагч нь мэдүүлэгч өөрөө бол тухайн хэрэглэгчийн мэдээлэл системээс автоматаар бөглөгдөнө.
Илгээх үеийн тээврийн хэрэгсэл	Системээс тодорхойлсон тээврийн төрлүүд болон илгээх улсаа сонгоно.
Хилийн боомт	Хил нэвтэрсэн боомтын нэрийг оруулах ба ачааны мэдээллээс автоматаар татагдана.
Гэрээлэгч улс	Бараа нийлүүлэхээр гэрээ байгуулсан гадаад гэрээлэгчийн харьяалагдах улсын нэрийг сангаас сонгоно.
Бараа нийлүүлэх нөхцөл	Гадаад худалдааны гэрээ хэлцлийн дагуу талуудын харилцан тохирсон бараа нийлүүлэх нөхцөлийг инкотермсийн нэр томъёог ашиглан сангаас сонгож оруулна. EXW (үйлдвэрээс шууд ачуулсан), FOB (тавцанд хүргэх), CIF (тээвэр болон даатгал төлсөн), DDU (хүргэлтийн хураамж төлсөн) гэх мэт.
Хэлцлийн код	Системээс тодорхойлсон төрлүүдээс сонгоно.
Төлөлтийн код	Тухайн барааны татварын төлөлтийг ямар аргаар хийж байгааг сангаас сонгоно. Жишээ нь: Бэлэн мөнгө тушаасан-101, Бэлэн бусаар тушаасан -201, Урьдчилсан төлбөрөөс суутгал хийсэн-301 гэх мэт.
Валютын төрөл	Гэрээ хэлцэлд заасан үнийн валютын төрлийг сонгох ба тухайн валютын төгрөгтэй харьцах ханш автоматаар тооцогдоно.
Хэлцлийн ерөнхий дүн	Үнийн нэхэмжлэхийн үнийн дүн буюу тухайн ачилтад хамрагдах бүх барааны нийт үнийн дүнг өмнө сонгосон валютаар илэрхийлж бичнэ. Жишээ нь:

	Гэрээнд 119 тонн цагаан будааг 1 тонныг нь 600 ам.долларын үнээр худалдан авахаар гэрээ байгуулсан ба барааны нийт үнийн дүн 71400 ам.доллар байна. Энэ тохиолдолд хэлцлийн ерөнхий дүн дээр 71400 гэсэн тоо утгыг оруулна.
Бүрдүүлэлтийн хураамж	Систем цаанаасаа бодож мөнгөн дүн тавина.
Тээврийн зардал	Монгол улсын хилийн боомт хүртэлх барааг тээвэрлэх, ачих буулгах, шилжүүлэн ачихад гарсан хэлцлийн буюу гэрээний үнэнд ороогүй дараах зардлын дүнг бичнэ. Үүнд: ✓ Тээврийн зардал, тээврийн болон экспортын бичиг баримт бүрдүүлэхэд гарсан зардал, тээврийн хэрэгсэл болон чингэлэг ашиглалтын хөлс, түрээсийн төлбөр; ✓ Тээвэрлэлтийн үед барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачих болон арчлан хамгаалахад гарсан зардал.
Даатгалын хураамж	Даатгалын хураамж буюу тээвэрлэлт, ачих буулгах, хадгалахтай холбоотой гарч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор хийсэн, тухайн барааг хүргэхтэй холбоотойгоор Монгол улсын хилийн боомт хүртэл гарах бусад үйл ажиллагаатай холбоотой зардлууд буюу хэлцлийн ба гэрээний үнэнд ороогүй даатгалын зардлуудыг бичнэ.
Нэмэгдэх зардал	Хэлцлийн үнэнд нэмэгдвэл зохих тээвэрлэлт, даатгалын зардлаас бусад, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн IV, V бүлэгт заасан бусад нэмэгдэх зардлын дүнг бичнэ.
Хасагдах зардал	Хэлцлийн буюу гэрээний үнд орсон бөгөөд тусдаа ялгарч харагдах тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн, гадаад худалдаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндэслэлтэй мэдээ баримтад тулгуурлан дараах зардлыг хасаж тооцно. Үүнд: ✓ Тоног төхөөрөмжийг импортолсны дараа суурилуулах, угсрах, засварлах болон техникийн туслалцаа үзүүлэх, сургалт явуулах зардал; ✓ Хил гаалиар оруулсны дараах тээврийн зардал; ✓ Импортлогч орны гаалийн болон бусад татвар.

Ачаа эргэлтийн мэдээлэл оруулах: “Ачаа эргэлтийн мэдээлэл” хэсэгт бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээлэл оруулна.

Талбарын нэр	Тайлбар
Хилээр нэвтрүүлж буй тээврийн хэрэгсэл	Эхний хэсэгт барааг Монгол улсын хил гаалиар гаргах үеийн тээврийн хэрэгслийн төрлийг сонгоно, дараагийн хэсэгт тээврийн хэрэгслийн харьяалагдах улсыг сонгоно.
Тээврийн хэрэгслийн дугаар	Тээврийн хэрэгслийн дугаарыг бичнэ. Энэ нь ачааны мэдээллээс автоматаар татагдах ба зөв татагдсан эсэхийг тулган шалгана.
Ачих буулгах газар	Барааг буулгах газар, өртөөний кодыг эхний хэсэгт, нэрийг дараагийн хэсэгт бичнэ.
Барааны байршил	Барааг гаальд мэдүүлэх үед тухайн бараа байрлаж буй гаалийн хяналтын бүсийг сонгож оруулна.
Гаалийн бүсэд орсон огноо	Гаалийн хяналтын бүсэд оруулсан он, сар, өдрийг оруулна.

Барааны мэдээлэл оруулах: “Барааны мэдээлэл” хэсэгт барааны ангилал, нэр, марк, баглаа боодол, тоо хэмжээ, үнэ, жин гэх мэт бараатай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл нөхөн бичих бөгөөд “Бичсэнээс хуулах”, “Бараа нэмэх” гэсэн 2 төрлөөр барааны мэдээлэл оруулах боломжтой.

Талбарын нэр	Тайлбар
БТКУС-ийн код	БТКУС (барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем) буюу Барааны ангиллын кодыг Уялдуулсан системийн дагуу заавал 8 оронтой ангиллын

	кодыг сангаас сонгож оруулна. Жишээ нь бусад аргаар чанарын хамгаалалт хийсэн байдлаар 16 кг-аас ихгүй жинтэй, бүтэн, хавтгайгаар зүсээгүй үхрийн арьс, ширийн ангиллын код 4101.20.91 гэж харагдана.
Барааны нэр болон кодоор хайлт хийж ангиллын кодыг сонгох боломжтой. БТКУС-тай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг https://gaali.mn/hscod/mn холбоосоор авах боломжтой.	
Гарал үүслийн улс	<ul style="list-style-type: none"> Барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг үндэслэн гарал үүслийн улсын нэрийг сонгож оруулна.
Тарифын төрөл	Барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг үндэслэн тарифын төрлийг сонгож оруулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ Нэн тааламжтай тариф: - ДХБ-ын гишүүн орнууд болон Беларус Улсын гарал үүсэлтэй бараанд хэрэглэнэ. Гарал үүслийг нотлох баримт хавсаргасан байна. ✓ Ердийн тариф: - Гарал үүслийг нотлоогүй тохиолдолд ердийн тарифыг хэрэглэнэ. Нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. ✓ Хөнгөлөлтгүй тариф: - Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу Япон Улсын гарал үүсэлтэй бараанд хэрэглэнэ. ЭЗТХ-ийн гарал үүслийн гэрчилгээ хавсаргана.
Оноосон нэр	Барааны ерөнхий нэрийг бичиж таслал тавин, тухайн барааг тодотгосон онцлог шинжийг бичнэ.
Үйлдвэрлэгч	Барааг үйлдвэрлэсэн компанийн нэрийг бичнэ.
Марк (Модель)	Барааны брэнд нэр, стандарт, артикул, загвар, сорт зэргийг тухайн барааны онцлогтой уялдуулан бичнэ. Барааны брэнд нэрийг хэлцэлд туссан байдлаар нь бичих бөгөөд гадаад нэрийг кирилл үсэгт хөрвүүлэхгүй. Эхний үсгийг томоор бусад үсгийг жижгээр бичнэ. Тухайлбал: Esse, Tide, Ariel гэх мэт. Стандартын үсгэн тэмдэглэгээг том үсгээр бичнэ.
Онцлог шинж	Барааны зориулалт, агууламж, онцлог шинж, чанар, зэрэг, техникийн үзүүлэлт, хүчин чадал, хэмжээ, барааны шинж байдал, тодорхойлолт, савлагаа бичнэ. Жишээ нь: Тамхи 1 хайрцаг*50 блок*10ж/х*20ш, бохь 20мг, ник 1.6мг; Шампунь тэжээлийн, чийгшүүлэгчтэй, 1 хайрцаг*6ш*250мл, с/жин-53гр, үс арчилгаа.
Бусад мэдээлэл	Дээрх талбаруудад ороогүй боловч тухайн барааны үнэ, ангилалд нөлөөлөх бусад мэдээллийг оруулна.
Үйлдвэрлэсэн он	Барааны үйлдвэрлэсэн он бичнэ.
Бар код	Тухайн барааны бар кодыг оруулна.
Квот	
Хэлцлийн нэгж үнэ	Гэрээ хэлцэлд туссан хэмжих нэгжээр илэрхийлсэн нэгж үнийг оруулна. Дээрх жишээний дагуу хэлцлийн нэгж үнэ нь 600 ам.доллар.
Хэлцлийн тоо хэмжээ	Барааны гэрээ хэлцэлд тохирсон хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн нэгжийн тоо хэмжээг оруулна. Жишээ нь: Нотлох бичиг баримтад 119 тонн гэж заасан бол хэлцлийн тоо хэмжээ нь 119 бөгөөд хэмжих нэгж нь тонн байна. Хэлцлийн тоо хэмжээ хүснэгтэд 119, харин тонн гэсэн хэмжих нэгжийг сангаас сонгож оруулна.
Ангиллын нэгж үнэ	БТКУС-ийн ангилал хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн суурь нэгж үнийг программаас автоматаар тооцож гаргадаг.
Ангиллын тоо хэмжээ	БТКУС-ийн ангилал хүснэгтэд Уялдуулсан системийн дагуу 8 оронгийн түвшинд ангиллын кодыг бичихэд ангиллын хэмжих нэгж идэвхэжнэ. Ангиллын хэмжих нэгж нь хэлцлийн хэмжих нэгжээс өөр байгаа тохиолдолд ангиллын тоо хэмжээг тооцон гаргахдаа хэлцлийн хэмжих нэгжийн тоон утгыг ангиллын хэмжих нэгжээр илэрхийлж, хэлцлийн тоо хэмжээгээр үржүүлж тооцно. Жишээ нь: Цагаан будааны хэлцлийн хэмжих нэгж нь тонн бол Уялдуулсан системийн дагуу ангиллын хэмжих нэгж нь кг байдаг. Иймд цагаан будааны хэлцлийн тоо хэмжээ 119 тонн, ангиллын тоо хэмжээ 119,000 кг болно.

Шилжих коэффициент	БТКУС-ийн ангилал хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн суурь нэгж үнийг программаас автоматаар тооцож гаргадаг.
Баглаа боодол	Эхний хэсэгт тухайн барааны баглаа боодлын тоо ширхгийг, дараагийн хэсэгт баглаа боодлын хэмжих нэгжийг сонгож оруулна.
Цэвэр жин	Цэвэр жин (net weight) бараатай хамт хэрэглэгчид очих, жижиглэн худалдаалахаар борлуулагдах баглаа боодлын жинг цэвэр жинд оруулж тооцож кг-аар илэрхийлж бичнэ.
Бохир жин	Хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн зориулалттай баглаа боодлын жинг бохир жинд оруулан тооцож кг-аар илэрхийлнэ. Бохир жин (gross weight) барааны доторх болон гаднах хайрцаг, шуудай, торх, шил гэх мэт тооцсон жинг ойлгоно. Өөрөөр хэлбэл бохир жин гэдэг нь барааны жинд түүний гаднах баглаа боодлыг оруулсан жин юм.

Бичиг баримтын мэдээлэл оруулах. “Бичиг баримтын мэдээлэл” хэсэгт худалдааны болон бусад дагалдах бичиг баримтын электрон хуулбарыг хавсаргах бөгөөд барааг мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтуудыг PDF форматаар хавсаргаж оруулна.

Талбарын нэр	Тайлбар
Бичиг баримтын нэр	Хавсаргах бичиг баримтын нэрийг системд тодорхойлсон төрлөөс сонгож оруулна. Системд тодорхойлсон төрөлд байхгүй бичиг баримт оруулах бол “Бусад” сонголтыг сонгон оруулахыг анхаарна уу.
Дугаар	Хавсаргах бичиг баримтын дугаарыг гараар бичиж оруулна.
Огноо	Хавсаргах бичиг баримтын огноог гараар бичиж оруулна.
Хуудас	Хавсаргах бичиг баримтын хуудасны тоог гараар бичиж оруулна.
Файл	“Файл” хэсэгт дарж тухайн бичиг баримтыг PDF форматаар хавсаргаж оруулна.
Тайлбар	Нэмэлт шаардлагатай тайлбар оруулах бол гараар бичиж оруулна. Энэ талбар нь заавал бөглөх шаардлагагүй талбар юм.

Дээр дурдсан нийт 4 мэдээллийг системд үнэн зөв, бүрэн оруулснаар гаалийн мэдүүлгийг илгээх бөгөөд барааны мэдээлэл хоорондоо ямар ч зөрүүгүй эсэхийг систем автоматаар шалган алдаа байхгүй тохиолдолд “Илгээх” товч идэвхжин мэдүүлгийн мэдээллийг гаалийн байгууллага хүлээн авах боломжтой болно. Тус алхмыг хийсний дараагаар гаалийн мэдүүлэг “Хүлээн авсан” төлөвт шилжих ба ингэснээр гаалийн мэдүүлгийг засварлах боломжгүй болох юм.

Гаалийн мэдүүлгийн мэдээлэл болон дагалдах бичиг баримтыг бараатай тулган шалгаж, биет үзлэг хийсний дараа гаалийн хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч, ахлах байцаагч нар баталгаажуулж зөвшөөрснөөр гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно. Мөн “Гаалийн үйлчилгээний цахим систем”-ийн “Нүүр хуудас”-ны мэдүүлгийн дугаар оруулах хэсэгт мэдүүлгийн дугаараа оруулан тухайн мэдүүлгийн явцын мэдээллээ харж, хянах боломжтой.

3.3 Тээвэр, ложистик

Европын Холбоонд боловсруулсан сарлагийн арьс экспортлоход эхнээс нь сайтар төлөвлөсөн ложистикийн төлөвлөгөө шаардлагатай. Тээвэрлэлт, бичиг баримт, гаалийн бүрдүүлэлт зэрэг ложистикийн мэдээлэл нь боловсруулсан арьсыг зорьсон газартаа цаг тухайд нь аюулгүй хүргэхэд чухал үүрэгтэй. Энэ бүлэгт боловсруулсан сарлагийн арьсыг Европын Холбоонд экспортлоход шаардагдах ложистикийн мэдээллийн тоймыг оруулсан болно.

Тээвэрлэлт нь Европын Холбоонд боловсруулсан сарлагийн арьс экспортлох ложистикийн хамгийн чухал асуудлын нэг юм. Арьс ширийг аюулгүй, цаг тухайд нь тээвэрлэхийн зэрэгцээ тээвэрлэх явцад гэмтээхгүй байх шаардлагатай. Тээврийн горим

нь ачааны хэмжээ, хүрэх газар хүртэлх зай, хүргэлтийн хугацаа, зардлын тооцоо зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна.

Автомашинны тээвэр: Европын Холбооны орнууд уруу боловсруулсан сарлагийн арьс (арьс ба/эсвэл арьсан бүтээгдэхүүн) тогтмол, бага хэмжээгээр тээвэрлэхэд автомашинны тээвэр тохиромжтой. Автомашинны тээвэр нь экспортлогчийн хаалганаас барааг хүлээн авагчийн хаалга руу шууд хүргэх боломжийг олгодог уян хатан тээврийн хэлбэр юм.

Төмөр замын тээвэр: Төмөр замын тээвэр нь боловсруулсан сарлагийн арьс ширийг Европын Холбооны орнууд уруу тээвэрлэх, ялангуяа их хэмжээний ачаа тээвэрлэхэд зардал багатай хувилбар байж болно. Автомашинны тээвэртэй харьцуулахад бүтээгдэхүүнийг их хэмжээгээр найдвартай, аюулгүй тээвэрлэх төрөл юм. Гэхдээ нэг анхаарах зүйл нь автомашинны тээвэр шиг уян хатан биш бөгөөд хилийн боомтуудад нэмэлт ачилт, шилжүүлэн ачихыг шаарддаг тул сайн төлөвлөөгүй тохиолдолд тооцоолоогүй нэмэлт зардал гарах эрсдэлтэй.

Агаарын тээвэр: Агаарын тээвэр нь боловсруулсан сарлагийн арьсыг Европын Холбооны орнууд уруу экспортлох хамгийн хурдан тээврийн хэлбэр юм. Энэ нь яаралтай тээвэрлэлт хийхэд тохиромжтой хэдий ч хамгийн үнэтэй тээврийн төрөл бөгөөд их хэмжээний арьс ширэн бүтээгдэхүүний хувьд тохиромжгүй тээвэрлэлтийн хэлбэрт тооцогдож байна.

Агаарын тээвэр нь хамгийн үнэтэй (ойролцоогоор кг нь 4.00 доллар) байдаг бол автомашин болон төмөр замаар тээвэрлэх нь хамаагүй хямд буюу ойролцоогоор кг тутам нь тус бүр 0.25 доллар болон 0.15 доллар байдаг⁹.

3.4 Татвар, үнэ тариф.

3.4.1. Үнэ тариф

Ерөнхий мэдээлэл

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дагуу мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн үнийг тодорхойлж, гаалийн байгууллагад мэдүүлэх ба ингэхдээ дурын, эсхүл зохиомол үнэ хэрэглэхийг хориглодог. Гаалийн үнийг тодорхойлохдоо хэд хэдэн аргыг ашиглаж болох ба тухайн аргыг мэдүүлэгч буюу экспортлогч нь өөрөө сонгож болдог бөгөөд өөрийнхөө сонгосон гаалийн үнийг тодорхойлох арга болон гаалийн үнийг тодорхойлсон бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй байдаг. Тухайн бичиг баримт нь бодитой мэдээлэл дээр үндэслэгдсэн, тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн байх нь зохимжтой бөгөөд гаалийн үнийг тодорхойлох арга болон гаалийн үнийг мэдүүлэгч үнэн зөв, бодитой тодорхойлсон эсэхийг гаалийн байгууллага шалгаж, шийдвэр гаргана.

Европ руу импортлох үеийн татвар, үнэ тарифтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг 4.7. -р хэсэг буюу татвар хураамж хэсэгт орууллаа

Гаалийн үнийг тодорхойлоход ашигласан бичиг баримт баталгаажуулаагүй, эсхүл түүнд тусгагдсан мэдээлэл зөрсөн, бүрэн бус, тоон үзүүлэлт нь хангалтгүй байсан эсхүл мэдүүлэгч гаалийн үнийн үнэн зөвийг нотолж чадаагүй бөгөөд гаалийн байгууллага мэдүүлэгчийн тодорхойлсон үнийг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд гаалийн байгууллагын өөр аргаар тодорхойлсон үнээс гаалийн болон бусад татварыг ногдуулж, мэдүүлэгчээр төлүүлдэг бөгөөд мэдүүлэгч гаалийн байгууллагаас тодорхойлсон гаалийн үнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол гаалийн байгууллагаас уг үнийг тодорхойлсноос хойш 45 хоногийн дотор нэмэлт нотлох баримт гарган өөрийн мэдүүлсэн үнийг үнэн зөв гэдгийг нотолсон тохиолдолд гаалийн байгууллага нь мэдүүлэгчийн тодорхойлсон

⁹ <https://super-internationalshipping.com/freight-europe-mongolia/>

үнийг үндэслэн гаалийн үнийг шинээр тогтоож болох зохицуулалттай. Гаалийн үнийг магадлан шалгах явцад гарсан зардлыг мэдүүлэгч хариуцдаг тул гаалийн үнийг зохих аргыг ашиглан үндэслэлтэйгээр тогтоох нь чухал байдаг.

Экспортын барааны гаалийн үнэ нь Монгол Улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцөлөөр тодорхойлогдох ба дараах аргыг дор дурдсан дарааллын дагуу хэрэглэнэ:

- хэлцлийн үнийн арга;
- зардлаас тооцох үнийн арга;
- нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга;
- зах зээлийн мэдээлэл, судалгааны арга.

Хэлцлийн үнийн арга. Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлоход хэлцлийн үнэд Монгол Улсын хил хүртэл уг барааг хүргэхэд барааны дараах зардал, төлбөр ороогүй бол нэмж тооцно:

- тээврийн зардал;
- тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн болон экспортын бичиг баримт, бүрдүүлэлтийн хураамж, даатгалын шимтгэл, түүнчлэн барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачихад гарсан зардал.

Дараах тохиолдолд экспортын барааны үнэлгээнд хэлцлийн үнийн аргыг хэрэглэхийг хориглоно:

- хэлцэл нь гаалийн үнийг тодорхойлох боломжгүй нөхцөлөөр хийгдсэн бол;
- худалдагч болон худалдан авагч нь харилцан хамаарал бүхий этгээдүүд бөгөөд энэ хамаарал нь хэлцлийн үнэд мэдэгдэхүйц нөлөөлсөн бол.

Зардлаас тооцох үнийн арга. Хэлцлийн үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд зардлаас тооцох үнийн аргыг хэрэглэнэ. Зардлаас тооцох үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо Монгол Улсын нутаг дэвсгэрт орших үйлдвэр, экспортлогч аж ахуйн нэгж, байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодит бичиг баримт, мэдээлэлд тулгуурлаж нэгж үнийг тодорхойлно.

Энэ аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо тухайн барааны нэгжид шууд болон шууд бус байдлаар шингэсэн дараахь зардал, үнийг нэмж тооцно:

- үнийг нь тодорхойлж буй барааг үйлдвэрлэхтэй холбогдсон дараахь зардал;
- үйлдвэрлэгчээс тухайн бараанд бүрэлдэхүүн хэсэг болгон хэрэглэсэн түүхий эд, үндсэн болон туслах материалын үнэ;
- барааг үйлдвэрлэхтэй холбогдон гарах шууд болон шууд бус үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардал;
- үйл ажиллагааны болон удирдлагын зардлын тухайн бараанд ногдох хэсэг;
- цахилгаан, дулаан, уур ус, холбоо, түрээсийн зардлын тухайн бараанд ногдох хэсэг;
- үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн элэгдлийн тухайн бараанд ногдох хэсэг;
- тухайн бараанд ногдох татвар.
- тухайн барааг Монгол Улсын хил хүртэл тээвэрлэх, ачих буулгах, хадгалах, шилжүүлэн ачих зардал, тэдгээртэй холбоотой даатгалын шимтгэл;

Дээр дурдсан зардал, төлбөр, ашиг нь статистикийн болон татварын байгууллагад бүртгэгдсэн тухайн салбарын аж ахуйн нэгжийн дундаж үзүүлэлттэй ойролцоо бус, их зөрүүтэй бол зардлаас тооцох үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлохыг хориглодог.

Нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга: Хэлцлийн болон зардлаас тооцох үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох

боломжгүй бол нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргыг хэрэглэнэ. Экспортын барааны гаалийн үнийг нэг, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар тодорхойлохдоо тухайн үед буюу ойролцоо хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийж Монгол Улсаас экспортлосон нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийг ашиглана.

Нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо дараахь үзүүлэлтийг харгалзан үзнэ:

- харьцуулан жиших барааны үнэ нь тухайн, эсхүл өөр бусад аж ахуйн нэгж, байгууллагын хэлцлийн үнэ байх;
- харьцуулан жиших бараа нь үнэлж байгаа бараатай нэгэн зэрэг, эсхүл 60-аас дээшгүй хоногийн дотор экспортлогдсон байх.
- дээрх хугацаанд харьцуулан жиших хэд хэдэн хэлцлийн үнэ байвал олон тохиолдсон үнийг сонгоно.

Зах зээлийн мэдээлэл, судалгааны үнийн арга: Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох сүүлчийн арга нь зах зээлийн мэдээлэл, судалгааны үнийн арга болно. Зах зээлийн мэдээлэл, судалгааны аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо олон улсын худалдааны практик, тухайн үеийн дэлхийн зах зээлийн үнийн дараах мэдээлэл, судалгааг үндэслэнэ:

- экспортлогчийн нийтэд зориулан тараасан үнийн жагсаалт, лавлагаа, интернетийн мэдээлэл;
- гадаад худалдааны болон гаалийн статистикийн мэдээ зэрэг олон нийтэд зориулсан мэдээ, мэдээлэл;
- барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох экспортлогчдын гэрээ, түүний үнэ зэрэг болно.

Гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд гаалийн болон бусад татвар ногдуулах бөгөөд энэ заалт нь гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх бараанд нэгэн адил хамаарна. Гаалийн болон бусад татвар ногдуулах суурь нь барааны гаалийн үнэ, түүний тоо хэмжээ байна. Гаалийн болон бусад татварыг барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тариф, валютын ханшаар тооцож төгрөгөөр ногдуулах ба хэрэв бичиг баримтын бүрдүүлэлтийг урьдчилан хийсэн өдрөөс гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх өдөр хүртэлх хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш болон тарифын хувь хэмжээнд өөрчлөлт орсон бол гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа тариф, валютын ханшийг баримталдаг.

Экспортлогч буюу татвар төлөгч нь гаалийн болон бусад татвар төлөх зорилгоор гаалийн байгууллагын дансанд урьдчилгаа төлбөр хийж болох бөгөөд уг урьдчилгаа төлбөрт хүү тооцохгүй ба гаалийн болон бусад татварыг төлсөн, гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, эсхүл хэсэгчлэн төлүүлэх шийдвэр гарсан эсхүл гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргасан тохиолдолд гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болдог.

3.4.2. Татвар

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг үндэслэн гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд гаалийн болон бусад татвар ногдуулах бөгөөд гаалийн болон бусад татвар ногдуулах суурь нь барааны гаалийн үнэ, түүний тоо хэмжээ байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 3-т зааснаар гаалийн болон бусад татварыг барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тариф, валютын ханшаар тооцож төгрөгөөр ногдуулах ба хэрэв бичиг баримтын бүрдүүлэлтийг урьдчилан хийсэн өдрөөс гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх

өдөр хүртэлх хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш болон тарифын хувь хэмжээнд өөрчлөлт орсон бол гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа тариф, валютын ханшийг баримтлан төлнө.

Гаалийн болон бусад татвар төлөх баталгааг банк гаргаж болох ба тэдгээр татварыг төлөх баталгааны хугацаа дуусмагц татвар төлөх үүргийг банк хүлээнэ. Мөн татвар төлөгч нь гаалийн болон бусад татвар төлөх зорилгоор гаалийн байгууллагын дансанд урьдчилгаа төлбөр хийж болох бөгөөд уг урьдчилгаа төлбөрт хүү тооцдоггүй байна.

Гаалийн болон бусад татварыг төлсөн эсхүл гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргасан тохиолдолд экспортлогчийн гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болно.

3.4.3. Бусад хязгаарлалт

Гаалийн тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар "тарифын бус хязгаарлалт" гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тоон хязгаарлалт тогтоох болон бусад арга хэмжээг ойлгодог ба мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нь уг төрөлд хамаарахгүй тул экспортын үйл ажиллагаанд аливаа хязгаарлалт үүсэхгүй байна.

3.5 Экспортын гэрчилгээ авахад шаардагдах бичиг баримтууд

Мал, амьтны гаралтай түүхий эдийн экспортын гэрчилгээ авах дараах баримт бичиг шаардлагатай:

- Гаалийн ерөнхий газарт хандсан албан хүсэлт;
- Хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар;
- Худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг /Англи хэлээр бичигдсэнээс бусад тохиолдолд Монгол хэл дээр баталгаат орчуулгаар орчуулсан байх/;
- Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ /Мал эмнэлгийн ерөнхий газар/;
- Сав баглаа, боодлын мэдээлэл /тоо хэмжээ/ Англи хэлээр/;
- Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
- Улсын байцаагчийн дээж авсан тухай тэмдэглэл;
- Арьс, шир, ноос, ноолуурыг боловсруулсан газрын тодорхойлолт, стандартын шинжилгээний дүн /шаардлагатай тохиолдолд/;

Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад шаардлагатай бичиг баримтыг *Олон улсын малын эмчийн гэрчилгээ* нэртэйгээр 3.1.3-т жагсаасан болно. Гарал үүслийн гэрчилгээ авахад шаардлагатай бичиг баримтыг *Гарал үүслийн гэрчилгээ* нэртэйгээр 3.1.4-т жагсаасан. *Экспортын тохирлын гэрчилгээний* бичиг баримтыг Экспортын тохирлын гэрчилгээ нэртэйгээр 3.1.5-д жагсаалаа.

4. ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛИЙН ИМПОРТЫН ШААРДЛАГА

4.1 Малын гаралтай бүтээгдэхүүний худалдаатай холбоотой дүрэм, хязгаарлалт

1974 оноос хойш Европын Холбоо нь мал, амьтны эрх ашгийг хамгаалах үүднээс тав тухтай байлгах, аюулгүй байдлыг хангах хүнлэг хууль тогтоомж, дүрэм журмуудыг батлан гаргасаар байна. Европын Холбооны журамд зааснаар амьтдыг мэдрэхүйтэй амьд биет/бодгаль гэж үздэг учраас Европын Холбооны гишүүн орнууд нь мал, амьтны амьдрах орчин нөхцлийг тав тухтай байлгахыг шаарддаг бөгөөд Европын Холбооны бодлогыг хөдөө аж ахуй болон дотоод зах зээлдээ нэвтрүүлэх болон хэрэгжүүлэхдээ зохих ёсоор анхаарч үзэх ёстой.

Өнөөдөр Европын Холбооны фермийн мал, амьтны амьдрах орчны тухай хууль нь шувуу, тугал, гахайн аж ахуйг (тодорхой заалттай) хамарч байна. Мөн үүнд бүх төрөл, зүйлийн амьтдын нядалгаа, тээвэрлэлтийн үйл ажиллагаа багтана. Энэ хууль нь олон улсын хамгийн дэвшилтэт хууль, эрхзүйн баримт бичгүүдийн нэг юм. Ялангуяа Европын Холбоо өндөглөгч тахианы уламжлалт торонд хориг тавьж, хээлтэй мэгжийг бүлэг бүлгээр байрлуулахыг шаарддаг.

Гишүүн орнууд дүрэм журмын өдөр тутмын хэрэгжилтийг голчлон хариуцдаг бол Европын Холбооны Комисс хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг. Европын Холбооны мэргэжилтнүүд эрх бүхий байгууллагууд холбогдох албан ёсны хяналт, шалгалтыг хийж байгаа эсэхийг хяналт тавих үүднээс аудитын шалгатыг тогтмол хийдэг.

Европын Холбоо нь дэлхий дээрх хамгийн боловсронгуй, амьтны эрүүл мэндийн тухай дэвшилтэт хууль тогтоомжтой нийгэмлэг юм. Энэхүү тэргүүлэх байр суурь нь урт хугацаанд ашиг тустай боловч заримдаа (жишээлбэл) мал, амьтдын амьдрах орчин нөхцөл стандарт доогуур орнуудаас хямд бүтээгдэхүүн импортлох тохиолдолд Европын Холбооны үйлдвэрлэгчдийн болон (Европын Холбооны хэрэглэгчдийн) хориг саадтай учирч болзошгүй юм.

Европын Холбооны үйлдвэрлэгчид нь дэлхийн хэмжээнд өрсөлддөг учраас Европын холбооны бус хэрэглэгчид ЕХ-ны бүтээгдэхүүний мал, амьтдын тав тухтай аюулгүй орчинд амьдрах өндөр стандарт, шаардлагын талаар мэддэг байх хэрэгтэй.

Европын Холбооны амьтдын сайн сайхны төлөөх олон улсын үйл ажиллагаагаа дэмжин ажиллах шаардлагатай юм.

Эдгээр үйл ажиллагаа нь олон улсын байгууллагуудын түвшинд явагддаг бөгөөд тухайлбал ДАЭМБ (өмнө нь АТОУБ гэгддэг байсан) нь мал, амьтдын тав тухтай амьдрах орчин нөхцлийн талаархи олон улсын цуврал хэд хэдэн стандартыг баталсан. Европын Холбоо нь мөн мал, амьтдын аюулгүй байдлын стандартыг хэрэгжүүлдэг (гуравдагч тал) улсуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр хийдэг. Гуравдагч талын улсуудтай мал, амьтдын аюулгүй байдлын талаар туршлага судлах, мэргэжилтэн харилцан солилцох зэрэг бусад төрлийн харилцааг хөгжүүлэх боломжтой.

Европын Холбооны мал, амьтдын аюулгүй байдлын шаардлага нь амьд амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг импортлоход мөн хамаарна. Эдгээр нь хоёр үндсэн чиглэлд чухал ач холбогдолтой:

- хүнсний хэрэглээнд зориулсан нядалгааны үед амьтантай харьцах дүрэм журмыг мөрдөх
- амьд амьтдыг тээвэрлэхтэй холбоотой аюулгүй байдлын шаардлагыг хангах

Зарим бүтээгдэхүүний импортын хувьд мал, амьтдын аюулгүй байдлын шаардлагыг Импортын гэрчилгээнд баталгаажуулалтын хэлбэрээр тусгаж гарал үүслийн улсын мал

эмнэлгийн байгууллага, мал, амьтан болон нийтийн эрүүл мэндэд тавигдах шаардлагуудын хамт баталгаажуулсан байх шаардлагатай.

Сарлаг үржүүлэх, арьс ширийг нь боловсруулах Европын Холбооны сүүлийн үеийн шийдвэрүүдийн дагуу (2022 оны 2-р сарын 16. Страсбург) мал, амьтныг тохиромжтой нөхцөлд зөв өсгөж үржүүлэх асуудал мал, амьтны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын журмыг боловсруулсан. Энэ нь мал, амьтдын амьдрах орчин нөхцөл, хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжоор хамгаалагдсан болно.

Сарлагийн арьсан бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх цөөн хэдэн уламжлалт технологи байдаг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шинэ технологийг нэвтрүүлэхэд дараах нөхцлүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- байгаль орчинд илүү ээлтэй,
- арилжааны хувьд ашигтай,
- дэлхийн стандартад нийцсэн.

Хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд стандартын шаардлага хангасан барилга байгууламжууд, орчин үеийн техник, технологи болон мэдлэг туршлага аль аль нь чухал шаардлагатай бөгөөд Монгол Улсын эдийн засагт бодит үр дүнгээ өгөх юм. Энэхүү зөв зохион байгуулалт нь сарлаг үржүүлгийн зонхилох бүс нутагт эерэг нөлөө үзүүлэх бөгөөд улмаар малчид, үйлдвэрлэгчдэд эдийн засгийн үр өгөөжөө өгөх юм.

4.2 Бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага

Бараа, бүтээгдэхүүнийг импортлох нь хүн, амьтан, ургамал, эрүүл мэнд, улмаар байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх ёстой. Тиймээс бараа, бүтээгдэхүүн болон худалдан авагчийн аюулгүй байдлыг хангахын тулд Европын Холбооны орнууд руу импортлох үйл явцад дараах баримт бичиг шаардлагатай. Үүнд:

Нэг. Мал, амьтны хорио цээрийн газраас авсан гэрчилгээ: Хэрэв "арьс шир" эсвэл "арьс ширэн бүтээгдэхүүн" гэсэн ангилалд хамаарах аливаа зүйл нь мал, амьтны хорио цээрийн газрын дүрэмд хамаарах бол ийм бүтээгдэхүүнийг импортлогчид Улсын мал, амьтны хорио цээрийн албанаас гарал үүслийн гэрчилгээ авах шаардлагатай.

Хоёр. Малын эмчийн гэрчилгээ: Хэрэв бүтээгдэхүүн нь түүхий арьс, ургамлын идээлэгтэй боловсруулсан бүтээгдэхүүн байвал тус гэрчилгээг авах шаардлагатай. Сарлагийн арьсыг хагас боловсруулан оруулж ирсэн тохиолдолд Мал эмнэлгийн Ерөнхий газар албан ёсны баримт бичиг гаргаж болно. Европын Холбооны орнууд руу мал, амьтан болон мал, амьтны гаралтай бараа, бүтээгдэхүүн импортлох ерөнхий шаардлага нь Европын Холбооны хууль тогтоомжид заасан эрүүл мэндийн гэрчилгээтэй байх шаардлагатай. Тус гэрчилгээнд импортын зөвшөөрөл авахад хангагдсан байх шаардлагатай нөхцлүүд болон хяналт шалгалтын талаар тусгасан болно.

Хэрвээ бараа, бүтээгдэхүүн нь бэлэн бүтээгдэхүүн бол эрүүл мэнд, аюулгүй байдлын гэрчилгээ шаардлагагүй. Хүнсний хэрэгцээнд зориулагдаагүй мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг Европын орнууд уруу импортлохдоо хүн, мал, амьтны эрүүл мэндэд тавигдах ерөнхий шаардлагыг үргэлж дагаж мөрдөх ёстой. Энэ нь аюулгүй байдлыг өндөр түвшинд хангах, хүн, мал, малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Эрүүл мэндийн ерөнхий шаардлага нь туршилт, баталгаажуулалт, эдгээр бүтээгдэхүүнийг хадгалах, савлах нөхцөлтэй холбоотой байдаг.

Европын Холбооны хууль, дүрмийн (ЕХ) 2017/625 (CELEX 32017R0625) (Албан Ёсны Хяналтын Журам - OCR) дагуу энэ төрлийн бүтээгдэхүүнийг зөвхөн гуравдагч орнуудаас авсан тохиолдолд Европын орнууд руу импортлох боломжтой. Бүтээгдэхүүний ангилал тус бүрээр тухайн сонгосон улс орнуудын жагсаалтыг мөн

гаргасан байдаг. Бүтээгдэхүүнүүдтэй хамт шаардлагатай бүх гэрчилгээнүүд дагалдсан байх ёстой. Тэдгээр нь мөн ЕХ-ны гишүүн орнуудын Хилийн Хяналтын Постууд (BCPs)-ын хяналт, шалгалтыг амжилттай давсан байх ёстой. Олон нийт болон мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тодорхой нөхцлийг биелүүлэхтэй холбогдуулан эдгээр шаардлагыг дагаж мөрдөх ёстой.

Европын Холбооны эрх баригчид бараа, бүтээгдэхүүний улмаас аюултай өвчний дэгдэлт үүсэх зэрэг олон нийтийг хамарсан болон мал, амьтны эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдал үүсэх тохиолдолд тухайн гуравдагч орны импортыг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн түдгэлзүүлэх болон түр зуурын хориг арга хэмжээ авч болно.

Шаардлагатай гэрчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг Европын Холбооны тусгай хууль дүрэмд ашиглах гэрчилгээний загварын хамт тусгасан болно. Гэрчилгээнд албан ёсны малын эмч эсвэл байцаагч (холбогдох гэрчилгээнд заасан) гарын үсэг зурсан байх шаардлагатай бөгөөд мал, амьтан болон мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг баталгаажуулах тухай Зөвлөлийн 96/93/ЕС дугаар зааврын заалтуудыг дагаж мөрдөх ёстой. Гэрчилгээ нь Европын Холбооны дүрэм, журмыг дагаж мөрдөж байгааг баталгаажуулах тул гэрчилгээ гаргах, гарын үсэг зурах, олгоход хатуу дүрэм мөрдөнө. Гэрчилгээний эх хувилбар нь Европын Холбооны орнууд руу нэвтрэх ачаа, бараа, бүтээгдэхүүнийг дагалдаж явна. Гэрчилгээг ачаа, бараа, бүтээгдэхүүн илгээгч улсын хэл болон очих газар, тээвэрлэлтийн явцад хилийн хяналт, шалгалт хийгдэх гишүүн орнуудын аль алиных нь хэлээр үйлдсэн байх шаардлагатай боловч хэрвээ эдгээр гишүүн орнууд нь өөрийн улсын хэлнээс өөр Европын Холбооны албан ёсны аль нэг хэлээр хүлээн авахыг зөвшөөрч байвал тухайн хэлээр үйлдсэн байх боломжтой. Мал, амьтан болон бараа, бүтээгдэхүүний ангилал тус бүр нь өөрийн гэсэн мал, амьтдын болон/эсвэл нийгмийн эрүүл мэндийн шаардлагуудтай байдаг бөгөөд үүнд аюулгүй байдлын шаардлага (жишээ нь, нядалгаа, нядалгааны үеийн стандарт) багтсан байж болно. Үүний тулд тохирох гэрчилгээг ашиглаж, түүний бүх холбогдох заалтыг хангасан эсэхэд онцгойлон анхаарах хэрэгтэй.

Зарим тохиолдолд, ялангуяа техникийн хэрэгцээнд зориулагдсан мал, амьтны дайвар бүтээгдэхүүнийг импортлоход мал эмнэлгийн гэрчилгээний оронд арилжааны баримт бичиг болон (эсвэл импортлогчийн (хувь хүн, компани)) мэдүүлгийг зөвшөөрдөг.

Гурав. Импортын бараа, бүтээгдэхүүний лабораторийн дээжийн шинжилгээний дүгнэлт: Арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүний зарим төрөл, зүйлийг импортлоходоо импортлогч нь магадлан итгэмжлэгдсэн лаборатори (импортлогч улсын эрх бүхий) - иос дээжийн шинжилгээний дүгнэлт авах ёстой. Импортын арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүнээс гурван багц дээж авч байгаль орчин болон ойн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэж лабораторид хүргүүлнэ. Дээжийн шинжилгээний дүгнэлтийг хамгийн багадаа хоёр жилийн хугацаанд хадгална. (Арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүн импортлогчийн үүргээ биелүүлсэн эсэхийг баталгаажуулах зорилгоор). Гэрчилгээг арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүний импортыг хариуцах улсын гаалийн газрын байршлын хамт хүргүүлдэг. Арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүн импортлоходоо импортлогч нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Аюултай хог хаягдлын менежмент, тээвэрлэлт болон тэдгээрийн хил дамнасан зохицуулалттай холбоотой дүрэм журмын дагуу аюултай хог хаягдлыг (ирсэн өдрөөс хойш 90 хоногийн дотор) импортлогч орон руу гаргана.

Тухайн улсад орж ирж буй бараа, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд гаалийн байгууллагад шаардлагатай бүх гэрчилгээг хараат бус, баталгаатай лабораториос гаргаж өгөх нь чухал юм. Хэрэв эдгээр бараа, бүтээгдэхүүний импортын талаар сонирхож буй улс нь Европын Холбооны гишүүн орон бол Европын Холбооны хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах нь чухал юм.

Бараа, бүтээгдэхүүнээс гадна арьс шир боловсруулах байгууламжид ("арьс шир боловсруулах үйлдвэрүүд") цөөнгүй стандартыг дагаж мөрдөхөөс гадна бараа, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах шаардлагатай. Дараах шалгууруудад үндэслэн арьс шир үйлдвэрлэгчид нь стандарт, шаардлага хангасан эсэхийг үнэлнэ. Үүнд:

- Ус болон эрчим хүчний хэрэглээ
- Хатуу хог хаягдал болон бохир усны менежмент.
- Хорт хий болон дуу чимээний бохирдол
- Гарал, үүслийн баталгаа
- Эрүүл мэнд болон аюулгүй байдал.
- Химийн бодисын менежмент.
- Хязгаарлагдмал бодис, хяналт болон хром VI (CrVI)-ийн менежмент.

4.3 Европын Холбооны дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх

Европын Холбооны зах зээлд арьс шир болон арьс ширэн бүтээгдэхүүн импортлоход хууль, эрхзүйн хэд хэдэн шаардлагуудтай тулгарна. Сарлагийн арьс шир болон арьс, ширэн бүтээгдэхүүн импортлоход мөн хамаарах эдгээр шаардлагуудыг дор үзүүлэв. Үүнд:

- бүтээгдэхүүний аюулгүй байдал,
- хязгаарлагдмал химийн бодис ашигласан эсэх,
- зохиогчийн эрх,

Европын Холбооны орнуудад худалдаалагдах аливаа арьсан хувцас нь дараах дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх шаардлагатай.

Нэг. ЕХ-ны Бүтээгдэхүүний аюулгүй байдал тавигдах ерөнхий заавар (GPSD: 2001/95/EC). Европын Холбооны гишүүн орнууд тухайн бүтээгдэхүүн нь аюулгүй байдлын стандартыг хангаж байгаа эсэхийг шалгана. Эдгээр дүрэм журмын зорилго нь зах зээлийн үйл ажиллагааг сайжруулах, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчдийг хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино. Бүтээгдэхүүн борлуулах, туршиж үзэх, хүн бүрт аюулгүй гэдгийг нотлохын тулд уг заавар нь үйлдвэрлэлийн явцад дагаж мөрдөх ёстой үйл дүрэм журмыг тусгасан болно. Энэхүү зааварт үйлдвэрлэгч болон борлуулагч нарын аль алиных нь хариуцлагыг тусгасан бөгөөд үүнийг дараах холбоосоор үзэх боломжтой: <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/ALL/?uri=CELEX:32001L0095>

Хоёр. Химийн бодисыг бүртгэх, үнэлэх, зөвшөөрөл олгох, хязгаарлах (REACH) журам. Энэхүү журам нь арьс ширэнд хэд хэдэн төрлийн химийн бодис хэрэглэх, зарим тодорхой материалыг гоёл чимэглэлийн зориулалтаар ашиглахыг хязгаарладаг/хориглодог. Арьс ширэн гоёлын дагалдах хэрэгсэлд эдгээр химийн бодисыг хэрэглэхийг хязгаарладаг (эсвэл хориглодог). Бодис гэдэгт байгаль дах хэлбэрээрээ эсвэл үйлдвэрлэлийн аливаа процессоор гаргаж авсан химийн элемент болон түүний нэгдлүүдийг ойлгох ба тэдгээрийг ашиглах явцад бодисын тогтвортой байдлыг/чанарыг хадгалах болон аливаа бохирдлоос сэргийлэх зорилгоор ашигласан нэмэлт бодисууд мөн багтах боловч бодис болон түүний найрлагын өөрчлөлтөөр чанарын ямар нэг өөрчлөлтгүйгээр ялгаж, салгаж болох аливаа уусгагчийг оруулаагүй болно. (REACH-ийн 3(1) заалтыг үзнэ үү).

Энэхүү журмаар арьс шир болон түүнийг боловсруулалтад химийн бодис хэрэглэхийг хязгаарласан. Үйлдвэрлэл эрхлэн Европын Холбооны зах зээлд борлуулж буй компаниуд нь бүтээгдэхүүнийхээ бүх эрсдлийг хүлээн зөвшөөрч, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Нэмж дурдахад компаниуд эдгээр эрсдлийг

хариуцах чадвараа батлан харуулж, авах арга хэмжээний талаар худалдан авагч нартаа мэдээлэл өгөх ёстой.

Энэхүү журмаар (REACH) арьс ширэн гоёлын дагалдах хэрэгсэл үйлдвэрлэхэд дараах химийн бодисуудыг ашиглахыг хязгаарлах эсхүл хориглодог:

- Мөнгөн Ус
- Кадми
- Хар тугалга
- Хром VI
- Никель
- Арьсны тоос
- Пентахлорфенол
- Алкилфенол этоксилатууд (APEOs)
- Азо Будаг
- Полициклик үнэрт нүүрс ус төрөгч (PAHs)
- Формальдегид

Сарлагийн арьсан бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл (SYL) төслийн зорилго нь арьс ширний боловсруулалтыг эхнээс нь зөв гүйцэтгэх ажлыг баталгаажуулах, химийн бодисын хэрэглээг аль болох багасгаж улмаар хамгийн сайн боловсруулалт хийх явдал юм.

Монгол сарлагийн арьсыг боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэж Европын орнууд руу экспортлох нь урт удаан үргэлжлэх үйл явц бөгөөд хамгийн чухал алхам нь арьс ширийг идээлэн боловсруулах үйл явц юм.

Энэхүү журам (REACH)-аас гадна цөөнгүй нэрийн брэндүүд, **сүлжээ дэлгүүрүүд** тус журмаас илүү хатуу хориглосон бодисын жагсаалтыг (RSLs) гаргасан байдаг. Тэдгээрийг ихэвчлэн Химийн аюултай бодисын хаягдлын сан (ZDHC) -гаас гаргасан зааварчилгаа (аюулгүй химийн бодис ашиглах) -наас санаа авсан байдаг. Энэ тохиолдолд үйлдвэрлэгч нь ЕХ-ны Ерөнхий дүрмээс гадна худалдан авагчийн тавьсан шаардлагыг үргэлж дагаж мөрдөх ёстой. Худалдан авагч нь түншлэлийн талаар тохиролцохын өмнө өөрийн тусгай шаардлагын талаар үйлдвэрлэгчид мэдэгдэх ёстой.

Гурав. ОЕКО-ТЕХ Стандартууд (Олон улсын ОЕКО-ТЕХ Association байгууллагаас гаргасан <https://www.oeko-tex.com/en/>) -ыг нэхмэл болон арьс ширэн бүтээгдэхүүнд тавигдах мэргэжлийн шаардлагад зориулж гаргасан байна. Тус байгууллага нь ЕХ-ны хууль, эрх зүйн шаардлага болон барууны орнуудын ихэнх зах зээлийн (АНУ, Канад, Скандинавын орнууд, Япон гэх мэт) хууль, тогтоомжийг хангаж чадсан тул эдгээр стандартууд Европын Холбооны зах зээлд аль хэдийн ашиглагдаж эхэлсэн бөгөөд одоогоор олон улсын бусад зах зээл рүү тархаж байна.

REACH, RSL-ийн шаардлагыг биелүүлэх үүргийг Европын Холбоонд байгуулагдсан импортлогчид хүлээх ба Европын Холбоонд байгуулагдсан Европын Холбооны гишүүн бус үйлдвэрлэгчийн төлөөлөгч нь зөвхөн REACH-ийн өмнө үүрэг хүлээнэ. Харин Европын Холбооны импортлогчид Европын Холбооны бус ханган нийлүүлэгчиддээ хандаж, зохицуулалтын үүргээ биелүүлэхийн тулд шаардлагатай мэдээллийг авах шаардлагатай. Европын Холбооны гишүүн бус үйлдвэрлэгч нь REACH журмын дагуу импортлогчдын хүлээсэн үүргийг биелүүлэх онцгой төлөөлөгчийг томилж, үйлчлүүлэгчиддээ (жишээлбэл, ЕХ-нд байгуулагдсан импортлогчид) цаашид дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. REACH журмын дагуу урьдчилан бүртгүүлэх болон бүртгүүлэх явцад бодисын талаар үргэлж дурдагдана. Импортлогч нар Европын Холбооны бус бусад үйлдвэрлэгчдэд Европын Холбооны орнууд уруу импортолж буй арьс ширэн бүтээгдэхүүнд дагаж мөрдөх Европын Холбооны холбогдох дүрэм журмын бүх

шаардлагын талаар мэдэгдэх үүрэгтэй. Үйлдвэрлэгч, албан ёсны болон хууль ёсны төлөөлөгч, эцсийн худалдан авагч эсвэл борлуулагч нь үйлдвэрлэл болон импортоо эхлүүлэхээсээ өмнө энэ бүх асуудлуудыг хэлэлцэж тохиролцсон байх нь зүйтэй юм.

Үйлдвэрлэгчид (энэ тохиолдолд сарлагийн арьс шир боловсруулах үйлдвэрлэгч болон борлуулагчид) нь үйлдвэрлэлд шаардлагатай бүх нэмэлт болон химийн бодисуудын жагсаалтыг гаргаж, төлөөлөгчдөө энэ талын мэдээллээр хангах хэрэгтэй. Төлөөлөгч нь үйлдвэрлэгчид мэдэгдэхээс гадна холбогдох байгууллагад мэдэгдэхийн тулд тухайн экспорт бүрийн бүх бодис, хэмжээг мэддэг байх шаардлагатай. Импортлогч нь үйлдвэрлэх, савлах, тээвэрлэх бүтээгдэхүүн бүр холбогдох дүрэм журмын бүх шаардлагыг хангаж байгааг үргэлж баталгаажуулахыг шаардах үүрэгтэй. Энэ хамтын ажиллагаа нь харилцан ашигтай, тэнцвэртэй байх нь маш чухал юм.

Импорт сонирхогч орнуудын (импортын хувьд) бүх хууль, дүрэм журмыг хангахын тулд үйлдвэрлэлийн явцад тогтмол дээж авч шинжлэх шаардлагатай. Бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулахын тулд хяналтын хоёр өөр стратеги баримталдаг.

- Хараат бус, эрх бүхий гадны орны лабораторид дээж илгээх.
- Үйлдвэрлэлийн явцад бүтээгдэхүүний дээжийг тогтмол шинжлэх

Үйлдвэрлэгчид ихэвчлэн хоёр аргыг хослуульж, бараагаа дотооддоо туршиж, гуравдагч талын лабораторид дээж илгээдэг. Эдгээр лабораторийн лицензийг Европын зах зээлд бараа худалдаалахад ашиглах боломжтой.

2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр ЕХ нь Тогтвортой Бүтээгдэхүүний Зохицуулалт (ESPR)-ын санал болгож буй эко-дизайны дагуу шинэ бүтээгдэхүүний тэргүүлэх чиглэлүүд юу байх талаар [олон нийтийн онлайн хэлэлцүүлгийг](#) эхлүүлсэн. Зорилго нь ЕХ-ны зах зээлд бүтээгдэхүүнээ илүү тогтвортой/найдвартай байлгахад оршиж байна. Үүнийг "эко-дизайны шаардлага" гэгддэг өргөн цар хүрээтэй гүйцэтгэл, мэдээллийн шаардлагуудыг идэвхжүүлж боломж бүрдүүлснээр гүйцэтгэнэ. Энэ нь тэдгээрийн эргэх холбоо, эрчим хүчний гүйцэтгэл болон байгаль орчны тогтвортой байдлын бусад талуудыг сайжруулах болно. ESPR-ийн дүрмийг бүтээгдэхүүн тус бүрээр эсвэл нэлээд төстэй шинж чанартай бүтээгдэхүүний бүлгүүдэд үндэслэн тогтооно. Тиймээс Европын Холбооны зөвлөл нь ESPR-ийн эхний ээлжинд анхаарах шаардлагатай шинэ бүтээгдэхүүний ангилал, арга хэмжээний талаар олон талын санал бодлыг нэгтгэж, улмаар тэргүүлэх чиглэлийг ил тод, хүртээмжтэй байдлаар тодорхойлох болно.

Европын Холбоо нь Европын Холбооны зах зээл дээрх бараг бүх биет бараа, бүтээгдэхүүнийг төлөвлөлтийн үе шатнаас өдөр тутмын хэрэглээний үе, зориулалтыг өөрчлөх үе шат болон ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд байгаль орчинд ээлтэй, эргэх холбоотой, эрчим хүчний хэмнэлттэй болгох шинэ дүрмийг санал болгож байна. Европын Холбооны зөвлөл нь мөн дараах шинэ стратегийг танилцуулж байна. Үүнд:

- нэхмэл эдлэлийг илүү бат бөх, засварлах, дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой болгох,
- загварын хэв маягийг тогтвортой байлгах, нэхмэл эдлэлийн хаягдал болон борлогдоогүй нэхмэл эдлэлийг устгах,
- нийгмийн эрх зүйн орчинг бүрэн хангасан үйлдвэрлэлийг бий болгох.

Гурав дахь зөвлөмж нь барилгын бүтээгдэхүүний дотоод зах зээлийг идэвхжүүлж, баригдсан орчин нь бидний тогтвортой байдал, уур амьсгалын зорилтуудыг хэрэгжүүлэхэд нийцсэн зохицуулалтын тогтолцоог хангах зорилготой юм.

Эцэст нь уг багцад ногоон шилжилтийн үед хэрэглэгчдийг чадавхжуулах шинэ дүрмийн саналыг тусгасан бөгөөд ингэснээр хэрэглэгчид бүтээгдэхүүний байгаль орчны тогтвортой байдлын талаар илүү мэдээлэлтэй болно.

Тогтвортой бүтээгдэхүүний эко-дизайны тухай журмын санал нь бүтээгдэхүүн ашиглагдах боломжгүй болох хүртэлх байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн 80 хүртэлх хувийг тодорхойлдог бүтээгдэхүүний төлөвлөлтийг тусгасан болно. Энэ нь бүтээгдэхүүнийг илүү бат бөх, найдвартай, дахин ашиглах боломжтой, шинэчлэх, засварлах боломжтой, засвар үйлчилгээ хийхэд хялбар (шинэчлэх, дахин боловсруулах), эрчим хүч, нөөцийг хэмнэлттэй болгох шинэ шаардлагыг тавьж байна. Нэмж дурдахад бүтээгдэхүүнд тавигдах мэдээллийн шаардлагуудад хэрэглэгчид худалдан авах бүтээгдэхүүнийхээ байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх боломжтой болох юм. Зөвшөөрөлтэй бүх бүтээгдэхүүнүүд нь Бүтээгдэхүүний цахим паспорттой болно. Энэ нь бүтээгдэхүүнийг засварлах, дахин боловсруулахад хялбар болгож, нийлүүлэлтийн сүлжээний дагуу **хориотой** бодисуудыг хянах боломжийг олгоно. Шошгололтыг мөн нэвтрүүлж болно. Энэхүү саналд мөн борлуулагдаагүй өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг устгах явдлыг таслан зогсоох, төрийн ногоон худалдан авалтыг өргөжүүлэх, тогтвортой бүтээгдэхүүнийг урамшуулах зэрэг арга хэмжээг тусгасан байна.

Арьс ширтэй холбоотой дүрэм журмын товч мэдээлэл:

- **(EX) 1007/2011 тоот дүрэм** нь арьсан бүтээгдэхүүнд хамаарах бөгөөд амьтны нэхмэлийн бус эд эрхтэн агуулсан нэхмэл бүтээгдэхүүнд шошгоны тусгай шаардлага тавигдана.
- **94/11/ЕС заавар** нь гутлын бүтээгдэхүүний орцын шошгоны стандартыг тогтоодог. Энэ нь бусад материалаас гадна гутлын арьсан бүрдэл хэсгүүдэд хамаарах тул ач холбогдолтой юм.
- **2005/29/ЕС заавар:** Шударга бус арилжааны практик/дадлага.
- **Бүтээгдэхүүний аюулгүй байдлын ерөнхий заавар 2001/95/ЕС.**
- Химийн бодисын бүртгэл, үнэлгээ, зөвшөөрөл, хязгаарлалтын тухай журам (ЕС) **No 1907/2006 (REACH)**
- Хүний хэрэглэнд зориулагдаагүй амьтны гаралтай дайвар болон хиймэл/зохиомол бүтээгдэхүүний тухай **журам (ЕС) 1069/2009 болон Комиссын дүрэм (EX) 142/2011.**
- **Арьс ширэн тавилга хийх журам**

4.4 Стандартууд ба гэрчилгээ

Стандарт, баталгаажуулалтыг дагаж мөрдөх нь хэрэглэгчдийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай бөгөөд бизнесийн амжилтад хөтөлдөг. Салбарын стандартыг дагаж мөрдөн гэрчилгээ авсан компаниуд амжилтанд хүрэх магадлал өндөр юм. Ингээгүй тохиолдолд боломжит түншүүдтэйгээ холбоо тогтоож чадахгүйд хүрэх юм. Арьс ширний (болон арьс ширэн бүтээгдэхүүн) салбартай холбоотой хамгийн чухал хоёр стандарт бол ОЕКО-ТЕХ болон Арьс ширний ажлын хэсэг (LWG) юм.

Стандарт гэдэг нь ямар нэг зүйлийг хийх тодорхой арга зам эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхойлолт юм.

Гэрчилгээ олгон баталгаажуулах үйл явц нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох бие даасан үйл

***ОЕКО-ТЕХ** нь хувцсанд химийн бодис хэрэглэх тухайд хэд хэдэн гэрчилгээтэй алдартай шошго билээ. Стандарт 100 нь хүний биед хортой бодис байгаа эсэхийг шалгах хамгийн түгээмэл хэрэглэдэг баталгаажуулах гэрчилгээ юм. Энэхүү гэрчилгээг авсан хувцас нь химийн хорт бодис байгаа эсэхийг тухайн хувцасны хэсэг бүрт шалган эрүүл мэндэд хор хөнөөлгүйг баталсан гэрчилгээтэй хувцас ажээ.*

Шинэ мэдээллээр хангахын тулд шалгалтыг жилд нэг удаа өргөн хүрээний шалгуурт үндэслэн явуулдаг. Үүний үр дүнд OEKO-TEX-ийн мэргэжилтнүүд хэрэглэгчдийнхээ эрүүл мэндийг хувцсанд агуулагдах аюултай химийн бодисоос хамгаалах үүргийг нуруундаа үүрдэг ажээ. Өдөрт нэг алим идэх нь эмчээс хол байлгадаг бол OEKO-TEX нь химийн бодисоос хол байлгадаг юм.

LWG нь арьс ширний үйлдвэр, арьс ширний худалдаа эрхлэгчдийг байгаль орчин хамгаалах удирдамжаа дагаж мөрддөг эсэхийг баталгаажуулдаг. LWG зэрэглэл (Алт, Мөнгө, Хүрэл) нь компаниудын үйлдвэрлэлийн үйл явц нь байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа байдалд суурилдаг ажээ. Хог хаягдлын менежмент, эрчим хүчний хэрэглээ, усны хэрэглээ зэргийг харгалзан үзэж ижил стандарт ашиглан гуравдагч этгээд аудит хийдэг. Энэхүү гэрчилгээ нь байгаль орчинд ээлтэй ханган нийлүүлэгчдээс арьс шир нийлүүлдэг брэндүүдийг урамшуулах зорилготой юм¹⁰.

Арьс ширний ажлын хэсэг (LWG) Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн аудитын стандарт (P7)-ийн хувилбар 7.0-г 2021 оны эхээр боловсруулж гаргасан. Тус стандартад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар илүү нарийвчилсан ойлголт өгөх зорилгоор арьс ширний үйлдвэрүүдийн үнэлгээний талаар томоохон өөрчлөлтүүд оруулсан байна. Хяналт, шалгалт нь ихэвчлэн хоёр өдрийн турш газар дээр нь явагдах бөгөөд гэрчилгээ нь 24 сарын хугацаанд хүчинтэй байдаг.

4.5 Шошго, баглаа боодлын шаардлага

4.5.1. Шошго

Гутлаас бусад арьс ширэн бүтээгдэхүүний шошготой холбоотой Европын зохицуулалт байдаггүй. Европын зарим орнууд арьс ширэн бүтээгдэхүүнд заавал үндэсний шошгоны системийг нэвтрүүлсэн бол зарим нь сайн дурын стандарт, шошгын системийг нэвтрүүлсэн. Ямар ч тохиолдолд Европын Холбооны 1007/2011 журмын дагуу хэрэглэгчдийн дунд төөрөгдөл үүсгэхгүйн тулд материалын агуулгыг шошгон дээр оруулах хэрэгтэй.

Бүтээгдэхүүний материалын агуулгыг шошголохоос гадна бүтээгдэхүүнийг угаах, арчлах заавар бүхий нэмэлт шошготой байхыг зөвлөж байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд Европын Холбоонд бүтээгдэхүүний шошгон дээр устгах зааврыг оруулах нь жишиг болсон. Тэдгээрийг хэрхэн дахин боловсруулах эсвэл аюулгүйгээр устгах тухай зааврыг мөн хавсаргасан байх ёстой.

Өрсөлдөх чадвартай Европын зах зээлд зөв агуулга, засвар үйлчилгээний шошго:

- хэрэглэгчийн бүтээгдэхүүний хэрэглээг хөнгөвчлөх,
- гомдол санал гарах, бараа буцаах эрсдлийг бууруулж
- хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.

Нэмж дурдахад, энэ нь эцсийн бүтээгдэхүүнийг худалдан авахын тулд хэрэглэгч төлөх ёстой үнийг тооцсон болно.

Хэрэглэгчид бүтээгдэхүүн, түүний хэрэглээтэй холбоотой эрүүл мэндээ хамгаалах зардалыг үнэлэх чадвартай байх ёстой. Энэ нь тэдний худалдан авах хүсэл эрмэлзэл, эдгээр бараанд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг ба улмаар хэрэглэгчид өөрсдийн хэрэглэж буй брэнд, бүтээгдэхүүнээ үнэнчээр сонгоно. Мөн шошго нь хэрэглэгчдийг илүү ёс зүйтэй, байгаль орчинд ээлтэй худалдан авалтын шийдвэр гаргахад дэмжлэг болдог. Энэ нь арьсан эдлэлийн ерөнхий тогтвортой байдлыг байгаль орчин, нийгмийн үүднээс сайжруулах боломжтой.

¹⁰ <https://www.sustainably-chic.com/blog/sustainable-certifications>

Энэ бүх мэдээллээр хангавал компаниуд шинэлэг санаа гаргаж, эрүүл өрсөлдөөнд ороход түлхэц болно. Шинэ журам хэрэгжсэнээр маркетингийн шударга бус аргууд хэрэглэж худал мэдээллээр хэрэглэгчийг төөрөгдүүлэх явдал бага гарах болно.

Илүү сайн, үнэн зөв мэдээлэлтэй шошго нь зах зээл дээрх бүтээгдэхүүний эргэлтийг хөнгөвчлөхөөс гадна импортолж буй бүтээгдэхүүний талаар өөр өөр Гишүүн Оруудын дунд илүү нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх боломжийг олгоно.

Шошгон дээр бичсэн мэдээллийн тухай журам нь дараах зүйлийг баталгаажуулдаг. Үүнд:

- Аливаа улсын үндэсний хууль тогтоомж нь түүнийг олон улсын зах зээл дээр арилжаалахад саад болохгүй.
- Компаниудын дунд шударга, эрүүл, зөв өрсөлдөөн бий болно.
- Худалдан авалттай холбоотой үл ойлголцол үүсэхээс сэргийлнэ.
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, хөдөлмөрийн нөхцөлийн талаар үйлчлүүлэгчид бүрэн мэдээлэлтэй байх болно.
- Худалдан авагчид худалдан авсан бараа бүтээгдэхүүнийхээ найдвартай байдал, аюулгүй байдлын талаар ялангуяа Европын нээлттэй зах зээл дээр мэдээлэлтэй байх болно.

Илүү нарийн мэдээлэлтэй ойлгомжтой шошго нь хэрэглэгчдэд ашигтай байх болно. Тэд бүтээгдэхүүний жинхэнэ үнэ цэн, чанар, түүнийг үйлдвэрлэхэд оролцсон нийгэм, хүрээлэн буй орчны нөхцөл байдлын талаар илүү сайн ойлголттой болно. Хэрэглэгчид тухайн бүтээгдэхүүний чанар, хяналт, шалгалт, ёс зүйд итгэж байвал өндөр үнэ төлөх магадлал их байдаг.

Европын Холбооны дүрэм журам нь нэхмэлийн бүтээгдэхүүн, даавуунд тавигдах шаардлага, утаснуудын чанартай холбоотой юм. Доод тал нь 80% даавуу агуулсан бүтээгдэхүүнийг мөн адил журамд хамруулна. Амьтны арьс ширээр хийсэн нэхмэлийн бус зүйлсийн талаарх мэдээлэл ч маш чухал. 20% арьс агуулсан бүтээгдэхүүн (бусад нэхмэл бус материалтай хослуулан) энэ журамд хамаарахгүй. Арьс ширэн бүтээгдэхүүнд тусгайлан зориулсан зохицуулалт байхгүй тул шошгоны аль ч хуульд бүхэлд нь хамрагдаагүй болно. Сарлагийн арьсан бүтээгдэхүүн боловсруулах явцад энэ асуудлыг үл тоомсорлож болохгүй.

Хуурамч бизнесийн эсрэг чиглэсэн Шударга бус арилжааны үйл ажиллагааны удирдамж (UCPD) нь 2015 онд хэрэгжиж эхэлсэн. Маркетингийн бодлого нь дараах тохиолдолд хуурамч гэж тооцогддог:

- Буруу, ойлгомжгүй, хамааралгүй мэдээллийг агуулсан.
- Хэдийгээр өгөгдөл нь үнэн зөв байсан ч хэрэглэгчийг төөрөгдүүлсэн эсвэл төөрөгдүүлэх боломжтой хэвээр байгаа.
- Бүтээгдэхүүнд зайлшгүй шаардлагатай мэдээллийг орхигдуулсан.
- Арилжааны зорилт, арилжааны стратеги хоёрыг ялгаж чадаагүй.

Борлуулагч нь худалдан авалт хийхэд шаардлагатай бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэг, орцын талаар бүх нарийн мэдээллийг худалдан авагчдад үргэлж өгөх ёстой. Тийм ч учраас UCPD нь бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар чансааг баталгаажуулах шошгоны асуудлыг хөндөж байна. UCPD нь дараах төрлүүдийн шошгыг сайжруулахыг эрмэлзэж байна:

Нэг. Арьс ширний баталгаатай байдал. Баталгаатай байдал нь зөвхөн Европын Холбооны цөөн хэдэн гишүүн оронд хамгаалагдсан байдаг. Өөрөөр хэлбэл арьс ширэн бүтээгдэхүүнийг худалдан авагчид мэдэгдэлгүйгээр ашигласан тохиолдолд хууль эрх зүйн үр дагавар гарч болзошгүй юм. Гэсэн хэдий ч энэхүү үйлдэл нь

Үйлдвэрлэлийн хувьд өндөр зардалтай байж болох бөгөөд зөвхөн тодорхой тохиолдолд л ашиглагддаг. Арьс ширэн бүтээгдэхүүнийг баталгаажуулах нийтлэг систем байхгүй байгаа нь худалдан авагчдад худалдан авах гэж буй бүтээгдэхүүнийхээ жинхэнэ материалыг танихад хэцүү болгодог. Ихэнх арьс ширний мэргэжилтнүүд арьс ширний жинхэнэ, хуурамчийг шалгах тестийн арга нь хор хөнөөлтэй байдаг тул шалгахаас зайлсхийдэг. Европын албан ёсны арьсан шошгыг нэвтрүүлэх нь шошгогүй орнуудад маш ашигтай байж болох юм. Хэдийгээр бүх бизнесүүд санал нийлэхгүй байгаа ч ийм шошго нь арьс ширний үйлдвэрлэлийн салбарт ашигтай байх болно гэж салбарынхан үзэж байна.

Хоёр. Байгаль орчны шошго. Арьс ширэн бүтээгдэхүүнд хамаарах ийм шошгоны олон төрөл, арга байдаг. Байгаль орчинд үзүүлэх нөлөө, түүний үр нөлөөний талаар хуваалцах ёстой мэдээлэл нь бүх нийтийн стандартад хамаарахгүй. Ямар ч үед арьс ширэн бүтээгдэхүүнийг байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалсан байдлаар үйлдвэрлэх ёстой. Эдгээр бүтээгдэхүүнд аюултай химийн бодис, ялангуяа зургаан валентат хром байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Мөн усны хэрэглээг харгалзан тэдгээрийг байгаль орчинд ээлтэй байдлаар үйлдвэрлэх ёстой. Байгаль орчны шошго нь компаниудад маш ашигтай гэж үздэг. Чанар, байгаль орчинд үзүүлэх нөлөө, өртгийн тэнцвэрт байдал нь маш чухал бөгөөд ингэснээр сарлагийн арьсыг экспортолж, олон улсын зах зээлд гаргах боломжтой болно.

Гурав. Нийгмийн болон ажлын нөхцөл байдал. Энэ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нөхцөл байдлыг тодорхойлдог, зөвхөн нэг л байдаг; энэ нь хөлбөмбөгт ашигладаг арьсан бөмбөгний шударга худалдааг хэлнэ. Энэ төрлийн мэдээллийн талаар туршлага, итгэл үнэмшил бага байдаг тул энэ талаар албан ёсны шийдвэр тийм ч олон байдаггүй.

Бүтээгдэхүүн бүрийг үйлдвэрлэхэд ашигласан амьтныг гарал үүслээр нь ялгах систем байдаггүй. Төрөл бүрийн амьтдаас гаргаж авсан арьс нь өөр өөр чанартай байдаг гэдгийг хэрэглэгчдэд ойлгуулах хэрэгтэй. Энэхүү мэдээлэл нь ялангуяа сарлагийн арьсны хувьд төдийлөн байдаггүй тул бүтээгдэхүүний борлуулалт, зах зээл дээр байршуулахад тус дөхөм болно.

Олон хүмүүс шошгоны заавал, тогтвортой Европын систем байх ёстой гэж үздэг бол зарим нь сайн дурын систем нь илүү тохиромжтой гэж үздэг. Энэхүү мэдээллийг дараах ерөнхий санаануудад нэгтгэн харуулав:

- Арьс ширний гарал үүслийг харгалзан үзэхэд муж/улс бүр хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлдэг заавал хэрэглэх шошгоны системийг тодорхойлоход хэцүү байдаг.
- Ийм систем нь хэрэглэгчдэд үнэхээр ашигтай байх магадлал багатай.
- Гарал үүслийн улс нь брэндийн хүчийг орлож чадахгүй.

Арьс ширний бүтээгдэхүүнд шошго тавих тухай одоо мөрдөж буй зохицуулалтууд нь олон янз бөгөөд бүрэн хэрэгжиж эхлээгүй байна. Тухайлбал, тухайн улсаас хамааран дараах сайн дурын тогтолцоог бий болгож байна:

Байршил	Сайн дурын шошгоны систем
Олон улсын	-
Европ	ЕХ-ны улс орнуудын байгаль орчны шошго, нэр томъёо, мөрдөх боломжтой холбоотой зарим санаачилга.
Скандинав	Арьсанд тусгайлан зориулсан систем байхгүй. Бүх даавуу тодорхой системд багтдаг. Гэсэн хэдий ч энэ чиглэлээр хөгжил дэвшил гарч байна.
Герман	Арьс шир, байгаль орчны шошгоны RAL зохицуулалт байдаг.
Англи	Арьс шир, байгаль орчны шошгоны RAL зохицуулалт байдаг.
Португал	Байгаль орчны шошго, ургамлаар идээлсэн арьс ширний журам байдаг ч арьс ширний гарал үүсэл, нэр томъёоны хувьд зохицуулалт журам байхгүй.

Энэ төрлийн шошго нь зардал өндөртэй тул бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлнө. Гэсэн хэдий ч өртөг өндөртэй шошго нь тансаг эд зүйлсийн үнэ цэнийг тодорхойлж байдаг. Үүнийг шийдвэрлэх алхамуудын нэг нь “тодорхойгүй” ангилалд байгаа шошгонуудыг Европын стандартад нийцүүлэн өөрчлөх явдал юм.

Гол санаа зовоосон зүйл бол бүтээгдэхүүний өртөг өндөр байгаа нь зөвхөн компанид төдийгүй үйлчлүүлэгчдэд дарамт учруулах болно. Эдгээр үнийн өсөлтийн хамгийн нийтлэг шалтгаанууд нь:

- Шошгоны шинэ системийг хөгжүүлэх.
- Өртөгийн сүлжээг бүхэлд нь мөрдөх тогтолцоог хөгжүүлэх.
- Үйл явцыг байнга шалгаж байх.
- Хэрэглэгчдэд мэдээлэл өгөх.
- Бүтээгдэхүүний дизайн, хөгжил, компаниудын маркетингийн стратегийн нөлөө.
- Урьдчилан таамаглах боломжгүй эрсдэл, тэдгээрийн борлуулалтад үзүүлэх нөлөө.

Хэрэглэгчид бүтээгдэхүүний талаар бүрэн мэдлэгтэй болсноор шошгоны шинэ бодлогын үр дүнд илүү өндөр үнэ төлөхөд бэлэн байж магадгүй юм. Мөн орчин үеийн (блокчейн) технологи нь илүү үр дүнтэй бөгөөд эдгээр олон зардалгүйгээр үйлдвэрлэлийн бүх хүрээг хамарсан шошго, дагаж мөрдөх шинэ журмыг хэрэгжүүлэх боломжтой юм. Ийм өөрчлөлтийг үйлчлүүлэгчид хэрхэн хүлээж авахыг урьдчилан таамаглахад хэцүү. Мөн энэ үйлдэл нь Европын арьс ширний үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөхийг таамаглахад бэрх. Хэрэглэгчид бүтээгдэхүүн худалдан авах хандлагаа өөрчилж чадсан ч арьс ширэн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэх нь өөр бүлгийн бүтээгдэхүүнд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Энэ нь үр нөлөөг бүрэн үнэлэхэд хэцүү гэсэн үг юм. Бүтээгдэхүүний борлуулалт, үнийн аливаа өөрчлөлт нь салбарын өөр өөр төрлүүдийн хооронд дахин хуваарилалтад хүргэж болзошгүй юм.

Одоогоор Европын аль ч улсад заавал шошго тавих нэгдсэн систем байхгүй. Нэгдмэл дүрэм журамгүй байгаа нь хэзээ ч асуудал болж байгаагүй бөгөөд эдийн засгийн бүх гол хүчин зүйлсийн салбарт бий болгохыг хүсэж буй олон улсын шаардлагыг харгалзан үзэх нь чухал юм. Олон улсын худалдааны түвшинд үзүүлж буй хариу үйл ажиллагааны тухайд ийм арга нь илүү хамгаалах хандлагыг Европын худалдааны түншүүдээс харуулна гэдгийг салбарынхан онцолж байна. Энэ нь бусад улс орнууд эсрэг арга хэмжээ авахад хүргэж болзошгүй юм.

Энэ бодлого нь сайн дурын шошго, заавал дагаж мөрдөх шошго, UCPD дээр суурилсан шошготой холбоотой. Арьс шир гэсэн нэрийг ашиглах нь аль хэдийн Европын Холбооны гишүүн орнуудад хэд хэдэн системээр хамгаалагдсан байдаг. Гэвч энэ аргыг дагаж мөрддөггүй олон улс байдаг бөгөөд зах зээл дээр байгаа бүтээгдэхүүний 15-20% (арьс ширэн бүтээгдэхүүн гэх нэрээр) нь арьсан болон хиймэл материалаар хийгдсэн байдаг.

Энэхүү бодлогын үр нөлөөг ойлгосны дараа ихэнх улс орнууд арьс ширэн бүтээгдэхүүнд сайн дурын шошгоны системийг ашиглахыг санал болгож байна, үүнд тусгайлан шошгоны загвар гаргах, боловсруулах зэрэг орно. Шошгожуулснаар "Арьс" гэдэг үгийн буруу хэрэглээ арилна. Энэхүү шошгыг бий болгосноор тухайн салбар болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хууль эрх зүйн хувьд ашигтай юм. Сайн боловсруулсан хууль эрх зүйн суурь нь үйлчлүүлэгчдийг төөрөгдүүлснээс үүдэлтэй хохирлын хэмжээг бууруулах юм. Энэ нь хэрэглэгчид арьс шир болон арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд илүү итгэхэд тусална.

Зардал багатай, хэрэглэгчид болон борлуулалтад илүү их нөлөө үзүүлдэг учраас сайн дурын шошго нь бизнес, үйлдвэрүүдэд хамгийн сайн сонголт юм шиг санагддаг. Өндөр өртөг нь арьс ширэн бүтээгдэхүүний экологийн шалгуурыг боловсруулахтай холбоотой

юм. Эдгээр шалгуурыг боловсруулахад маш олон хүмүүс оролцдог тул энэ процесс нь хамгийн их цаг хугацаа шаарддаг. Шинэ шошго гарч ирэх тул хэрэглэгчдэд мэдээлэл өгөх нь энэ удаад тийм ч чухал биш байх болно. Гэсэн хэдий ч энэхүү шинэ гарын авлагыг улс орондоо хэрхэн зөв хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгөхийн тулд Европын Холбооны гишүүн орнуудаас тусдаа эрх бүхий байгууллагууд оролцох шаардлагатай болно.

Энэхүү үйлдвэрлэл нь шошгонд зохицох, дараах шаардлагыг дагаж мөрдөх зардлыг хариуцах ёстой:

- Шинэ хяналт шалгалт.
- Хэрэглэгчдэд мэдээлэл өгөх.
- Үнэ болон борлуулалтад үзүүлэх нөлөө.
- Олон улсын худалдаанд үзүүлэх нөлөө.
- Европын хил дээр худалдаа хийх хялбаршуулсан дүрмийн нөлөө.

Байгаль орчинд ээлтэй арьс ширний зах зээлийн цар хүрээг харгалзан үзвэл энэхүү өөрчлөлт нь дэлхийн гуравдагч орнуудтай хийх худалдаанд ноцтой нөлөө үзүүлэх боломжгүй санагддаг. Гэсэн хэдий ч, энэ сонголт нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний нийлүүлэлтэд богино хугацаанд нөлөөлнө, харин байгальд ээлтэй эсэх нь тодорхойгүй бүтээгдэхүүнийг зах зээлээс шахна.

Шошгон дээр төөрөгдүүлсэн мэдэгдэл байхгүй гэдэгт итгэлтэй байх нь эерэг нөлөө үзүүлнэ. Гэсэн хэдий ч энэ шошгыг хэрэглэх нь хэцүү байж магадгүй. Европын шинэ удирдамж нь одоогийн олон улсын удирдамжаас илүү үр дүнтэй байх эсэх нь тодорхойгүй байна. Бүтээгдэхүүний дийлэнх төрлийг хамруулах нь илүү сайн арга бөгөөд зардлыг илүү жигд, үр дүнтэй хуваарилах юм. Урт хугацаандаа гарал үүслийн улс нь эдийн засгийн хувьд хамгийн их хохиролтой, ашиг багатай байх нь харагдаж байна. Энэхүү хэрэглээтэй холбоотой томоохон сорилтууд байгаа хэдий ч одоо байгаа бодлогоос үл хамааран зохих шошгоны ач холбогдол, үнэ цэнийн талаар хэрэглэгчдэд мэдээлэх, түүнчлэн салбар эдгээр асуудлыг шийдвэрлэх баталгааг өгөх нь SYL төслийн эцсийн үр дүнд маш чухал юм.

Нөлөөлөлд өртсөн	Нөлөөлөл		
	Эдийн Засгийн	Нийгмийн	Байгаль орчны
Аж Үйлдвэр	Зардал/ачаа <ul style="list-style-type: none"> • Захиргаа. • Үйлдвэрлэл. • Шошголох. • Хэрэглэгчдэд мэдэгдэх. Зардал/ашиг <ul style="list-style-type: none"> • Хууль зүйн тодорхой байдалд үзүүлэх нөлөө. • Борлуулалтад үзүүлэх нөлөө. • Импорт-экспортод үзүүлэх нөлөө. • Үнэд үзүүлэх нөлөө-түүхий эдээс бүтээгдэхүүн. 		
Хэрэглэгч	Бүтээгдэхүүний өртөг	Ашиг Тус <ul style="list-style-type: none"> • Хэрэглэгчийн мэдээлэлд үзүүлэх нөлөө. • Арьс шир, бүтээгдэхүүний 	

		чанарт нөлөө.	үзүүлэх	
Эрх Баригчид	Хөгжлийн зардал. Хэрэглэгчдэд мэдээлэл өгөх зардал. Хяналт шалгалтын зардал.			
Бусад	Зардал/ашиг <ul style="list-style-type: none"> Хөгжиж буй орнуудтай хийх худалдаанд үзүүлэх нөлөө. Европын өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөө, үйлдвэрлэлийн хэв маягийн өөрчлөлт. Хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө. 	Ашиг Тус <ul style="list-style-type: none"> Хөгжиж буй орнуудын хөдөлмөрийн нөхцөлд үзүүлэх нөлөө. Европын хөгжил цэцэглэлтэд үзүүлэх нөлөө. 	Ашиг Тус <ul style="list-style-type: none"> Хэрэглээний өөрчлөлтөөс болж байгаль орчинд үзүүлэх нөлөө. Арчилгааны шинэ арга барилын улмаас байгаль орчинд үзүүлэх нөлөө. 	

Эцэст нь, бүртгэлтэй хувцасны барааны тэмдэг, загварыг хууль бусаар хуулбарлах нь Европын загварын салбарт ноцтой аюул заналхийлэл гэж тооцогддог. Хэрэв хэн нэгэн нь Европын зах зээл дээр өөрийн загвараа зарж байгаа бол оюуны өмчийн (IP) эрхийг зөрчсөн эсэхээ шалгах ёстой. Хэрэв худалдан авагч нь загварыг өгсөн бол оюуны өмчийн эрхийг зөрчсөн нь тогтоогдвол тэд ч мөн хариуцлага хүлээх болно.

4.5.2. Сав, баглаа, боодол

Ихэнх тохиолдолд худалдан авагч, захиалагчийн хүсэлт, санал болгосноор сав, баглаа боодлыг хэрхэн шийдэх зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. Арьс ширэн хувцас үйлдвэрлэлийн салбарт жишиг болсноор хэрэв худалдагч нь импортолж буй улсын гаалийн бүрдүүлэлтийг хийнэ гэж худалдан авагчтай тохиролцсон бол тэрээр Европын Холбооны импортын журамд нийцэж байгаа эсэхийг мөн шалгах үүрэгтэй.

Сав баглаа боодлын гарын авлага нь баглаа боодлын талаархи бичмэл зааврыг агуулна. Энэхүү баримт бичигт шаардлагатай сав баглаа боодлын зааврыг агуулсан болно:

- Таны хэрэглэх савлагааны материалын төрөл, чанар.
- Таны хэрэглэх дүүргэлтийн материалын төрөл, чанар (хэлбэрийг хадгалахын тулд арьсан цүнхэнд түгээмэл хэрэглэдэг).
- Баглах материалын хэмжээ.
- Загварын лавлагаа, тоо, хэмжээнүүд, хэсгүүдийн тоо, өнгөний схем зэрэг нь сав баглаа боодол дээр дурдсан байх ёстой зүйлс юм.
- Зураасан кодын байршил.
- Баглах арга.
- Хайрцаг эсвэл олон уутанд хийх дээд хэмжээ.
- Экспортын хайрцагны дээд жин.
- Баглаа боодлын материал нийлүүлэгчид.

Арьс ширэн загварын дагалдах хэрэгслийн үйлдвэрлэл нь бүтээгдэхүүнийг хуурай, агааржуулалт сайтай газар хадгалах, савлах, тээвэрлэх шаардлагатай байдаг. Арьс нь агаараас чийг шингээх хандлагатай байдаг бөгөөд энэ нь гялалзсан байдлаа алдаж, эвгүй үнэр, толбо, хөгц мөөгөнцөр үүсэхэд хүргэдэг. Тээвэрлэлтийн явцад хэт их чийгийг

багасгахын тулд савхин бүтээгдэхүүнийг савлахдаа чийг шингээгчийг ихэвчлэн ашигладаг.

Худалдан авагч нь хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, сав баглаа боодлын материалын өртөгийг бууруулахын тулд хийсэн бүх тооцоог үнэлэх ёстой. Экспортлогчдын гаргасан жингийн гэрчилгээ нь янз бүрийн нөхцөл байдал, тэр дундаа нислэгийн ачааны даац, хөлөг онгоцны ачааны даац, олон улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, импорт, экспортын татварын тооцоо, экспорт/импортын хөнгөлөлтийг төрөөс шаардах гэх мэт үед хэрэгтэй байдаг.

4.6 Ургамлын идээлгээр идээлэх арга, арьс ширэн бүтээгдэхүүний чанарын шаардлага

Энэ нэр томъёо нь арьсны өнгө үзэмж, бүтцийг тодорхойлдог идээлэх аргуудтай холбоотой боловч үүнийг эцсийн ("дуусгах") үе шатанд зохицуулж болно. Арьсыг дараах байдлаар хийж болно:

- Ургамлын идээлгээр идээлэх.
- Хагас ургамлын идээлгээр идээлэх.
- Хромын идээлгээр идээлэх.
- Хромын идээ багатай идээлэх.
- Хромгүй идээлэх.

Янз бүрийн төрлийн арьс нь өөр өөр бүтээгдэхүүнд тохиромжтой. Жишээлбэл, ургамлын идээлэгтэй арьс нь харьцангуй хатуу, зузаан, гүн дулаан өнгөтэй байдаг. Үүнийг ихэвчлэн цүнх, бүс хийхэд ашигладаг. Ургамлын идээлгээр идээлсэн арьс шир нь ялангуяа хойд Европын орнуудад түгээмэл байдаг бөгөөд хэрэглэгчид үүнийг байгалийн үнэр, өнгө үзэмжээр нь үнэлдэг. Хромоор идээлэх нь арьсыг илүү зөөлөн, нимгэн, уян хатан болгох ба үүнийг ямар ч бүтээгдэхүүнд хэрэглэж болно. Энэ шалтгааны улмаас саяхныг хүртэл түрийвч, бээлий нь бараг бүгд зөвхөн хромоор идээлсэн арьсаар хийгддэг байв. Өнөө үед зарим ургамлын идээлэгт, хромгүй идээлсэн арьс шир нь ижил шинж чанарыг хангаж чаддаг болжээ.

Тогтвортой байдал, хэрэглэгчийн аюулгүй байдлын асуудал нь худалдан авагчид тодорхой төрлийн арьсыг сонгох шалтгаан болдог. Ургамлын идээлэгтэй арьс үйлдвэрлэгчид өөрсдийгөө байгаль орчинд ээлтэй гэж сурталчилдаг Европын брэндүүдийн дунд түгээмэл байдаг ч бүтээгдэхүүн бүрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нарийн тодорхойлоход хэцүү байдаг ба энэ нь арьс ширний үйлдвэрүүд орц, хог хаягдлаа хэрхэн зохицуулж байгаагаас ихээхэн хамаардаг.

Уламжлалт аргыг дэмжих, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс хромгүй идээлсэн арьс улам бүр түгээмэл болж байна. Сарлагийн арьс идээлэх ажлыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хийх ёстой.

Бэлэн боловсруулсан арьс нь бүрэн ба хагас анилин ширхэгтэй, пигментээр будсан толигор арьс, нубук, илгэн, хуваасан арьс, наасан арьс гээд сайнаас муу хүртэлх олон төрлийн шинж чанартай байдаг. Сорви, зүслэг, байгалийн гаралтай өө сэвээр ялгаж А (хамгийн цөөн тооны гэмтэл согогтой буюу хамгийн чанартай), В, С (хамгийн олон тооны гэмтэл согогтой нь хамгийн муу чанартай) гэж ангилдаг. Ихэнх худалдан авагчид өөрсдийн хүссэн арьс ширний төрлийг тодорхойлдог. Доод зэрэглэлийн арьс нь харьцангуй хямд боловч бүтээгдэхүүн хийхэд өө сэвийг арилгах ажиллагаа ихтэй, хог хаягдал их гардаг учир ашиг багатай. Ямар ч тохиолдолд өө сэв, гэмтэл согог ихтэй арьс нь бүтээгдэхүүний өнгө үзэмж, чанарыг муутгадаг тул худалдан авагчдын эрэлт хэрэгцээнд нийцэхгүй гэсэн үг.

Худалдан авагч нь хүлээн авах чанарын хязгаар/түвшин (AQL)-ийг тохиролцох хүсэлт гаргаж болно. Энэ нь тэвчиж болох чанарын хамгийн бага түвшинг илэрхийлдэг. Жишээлбэл, AQL 2.5 нь хэд хэдэн үйлдвэрлэлийн хугацаанд нийт захиалгын үнийн дүнгийн 2.5% -иас илүү нь гэмтэлтэй байвал худалдан авагч тухайн багцаас татгалзах болно гэсэн үг юм. Бэлэн савхин загварын дагалдах хэрэгслийн чанарын нийтлэг дутагдалд дараах зүйлс орно:

- тэгш бус, жигд бус зүсэгдсэн арьсан эд анги, нөхөөс,
- тэгш бус, жигд бус оёдлын шугамтай
- доод зэрэглэлийн буюу гэмтэлтэй арьс хэрэглэсний улмаас материалын гэмтэл үүссэн

Арьс ширний чанар нь гэрээ, худалдан авагчийн хүсэлтэд үндэслэсэн эсэхийг үргэлж анхаарч үзэхийг зөвлөж байна. Худалдан авагч нь ялангуяа илэг төрлийн арьсанд тодорхой өнгө, бат бөх байдлыг шаардаж болно.

Чанарын шаардлагыг зөвхөн худалдан авагч тогтоодог бөгөөд ханган нийлүүлэгчид тэдэнтэй худалдааны гэрээ байгуулсан бол дагаж мөрдөх ёстой. Европ дахь ихэнх худалдан авагчид үйлдвэрийн тогтвортой, найдвартай үйл ажиллагаа, гэрээний үүргээ чанд биелүүлэх шаардлагаа нэмэгдүүлж байна. Худалдан авагч хүсэлт гаргавал үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах, хувийн хяналт шалгалт хийх эрхтэй юм.

Арьс шир, савхин эдлэл, гутлын чиглэлээр чухал брэнд компаниудтай хамтран ажиллах чанарын шалгуур үзүүлэлтүүдийн тогтсон хувийн систем бол LWG систем юм. Гэхдээ LWG нь үйлдвэрлэлийн баталгаажуулах систем (өөрийгөө баталгаажуулах) бөгөөд OEKO-TEX нь илүү тохиромжтой, боломжийн хувилбар байх магадлалтай.

LWG нь арьс ширний үйлдвэрлэл, худалдааны сүлжээний тогтвортой ирээдүйг бий болгохыг эрмэлздэг дэлхийн олон талт нийгэмлэг юм. Энэ бол хариуцлагатай арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нийгэм, байгаль орчны стандартыг хэрэгжүүлдэг ашгийн бус байгууллага юм.

2005 оноос хойш LWG Арьс Үйлдвэрлэгчийн Аудитын Стандарт нь арьс ширний үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хувийн үнэлгээний хамгийн өргөн тархсан систем юм. Цаг хугацаа өнгөрөхөд энэхүү үнэлгээний хэрэглүүрийн хамрах хүрээ өргөжиж, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээн дэх үүрэг оролцоо, ач холбогдол нь нэмэгдсээр байна.

Дараах зүйлсийг хэрэгжүүлснээр байгаль орчин, түүнчлэн олон нийтэд эерэгээр нөлөөлөхийг зорьж байна:

- Нийлүүлэлтийн сүлжээг хянах, ил тод байдлыг нэмэгдүүлсэн.
- Мэдлэг мэдээлэл болон өгөгдөл ашиглалт нэмэгдсэн.
- Арьс ширний үйлдвэрлэлийн нөөцийн үр ашгийг дээшлүүлсэн.
- Хог хаягдал үүсэх, байгаль орчинд ялгарах утаа багасна.
- Химийн бодисын менежментийг сайжруулж, химийн хоргүй бодисын хэрэглээг нэмэгдүүлсэн.
- Ой мод устах, мал амьтныг хамгаалах тал дээр анхаарах ажлыг нэмэгдүүлсэн.
- Хөдөлмөрийн нөхцөл сайжирч, ажилчдад шударга хандах.

LWG гэрчилгээжүүлэх тогтолцооны хүрээнд арьс ширний үйлдвэрлэлийн сүлжээн дэх янз бүрийн үйл ажиллагааны үнэлгээний хэрэгцээг хангах аудитын дөрвөн стандарт байдаг. LWG-ийн эдгээр дөрвөн стандарт нь түүхий эдийн худалдаачид, арьс шир үйлдвэрлэгч, туслан гүйцэтгэгч, бэлэн материалын худалдаачид хүртэл хамрагдах ба:

- Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн стандарт.
- Арьс ширний худалдаачны стандарт.

- Ашиглалтанд оруулах үйлдвэрлэгчийн стандарт.
- Туслан гүйцэтгэгчийн стандарт.

Стандарт бүр аж ахуйн нэгжийн тодорхой төрлөөс хамааран хэд хэдэн тусдаа хэсгүүдэд анхаарлаа хандуулдаг. Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн стандарт нь дараах 17 өвөрмөц салбарыг хамарна. Үүнд.

1. Ерөнхий байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл
2. Туслан гүйцэтгэгчээр хийх үйл ажиллагаа
3. Нийгмийн аудит
4. Үйл ажиллагааны зөвшөөрөл
5. Үйлдвэрлэлийн өгөгдөл
6. Ирж буй материалын ул мөр
7. Гарч буй материалын ул мөр
8. Байгаль орчны удирдлагын систем (EMS)
9. Хязгаарлагдмал бодис, дагаж мөрдөх, хром VI (CrVI) менежмент
10. Энерги зарцуулалт
11. Усны хэрэглээ
12. Агаар ба дуу чимээний ялгарал
13. Хог хаягдлын менежмент
14. Бохир ус цэвэрлэх
15. Эрүүл мэнд, аюулгүй байдал, яаралтай үеийн бэлэн байдал
16. Химийн менежмент
17. Үйл ажиллагааны менежмент

Энэхүү судалгааны хүрээнд LWG стандартын дагуу баталгаажуулалтын ач холбогдлыг онцолж, Монголын үйлдвэрлэгчид хамтран ажиллах томоохон боломж бүхий Европын брэнд худалдан авагчид болон түншүүдтэй ойртож чаддаг байх нь чухал юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг LWG вэбсайтаас авах боломжтой.

<https://www.leatherworkinggroup.com/>

4.7 Татвар, хураамж

Европын Холбоо нь нэг талаас гаалийн холбоо учраас улс орон харгалзахгүйгээр нэвтрэх цэг дээр нийтлэг импортын татвар ногдуулдаг. Бүтээгдэхүүн нь Европын зах зээлд нэвтэрсний дараа нэмэлт гаалийн хураамж төлөхгүйгээр эргэлдэж болно. Эдгээр хураамжийн төлбөр нь худалдагч болон худалдан авагчийн хооронд байгуулсан гэрээнээс хамаарна. Импортлогчийн хувьд нэвтрүүлэх татвараа төлөх нь элбэг байдаг.

Европ руу импортлох үеийн татвар, үнэ тарифын талаарх мэдээллийг 3.4-р хэсэг буюу татвар ба үнэ тариф хэсэгт оруулав.

Европын Холбоо болон зорилтот улс хооронд худалдааны гэрээ байгуулсан тохиолдолд бүтээгдэхүүний татварыг бууруулах эсвэл бүр хасах боломжтой. Жишээлбэл:

- Ад валорем татварыг төлөх.
- Ад валорем татварын хувь хэмжээ нь тухайн бүтээгдэхүүн гарал үүслийн дүрэм журмын заалттай нийцэж байгаа эсэхээс хамаарна.
- Тодорхой төрлийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд арилжааны гэрээ эсвэл Европын бодлогод үндэслэн ноогдол хэрэглэж болно.

Одоогоос 50 гаруй жилийн өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD) хөгжиж буй орнуудыг дэлхийн эдийн засагт нэгтгэхэд нь туслахыг өндөр хөгжилтэй орнуудаас хүсчээ. Улмаар Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GSP:ХЕС) бий болж одоогоор тус механизм 40 гаруй улс оронд хэрэгжиж байна.

Хөгжиж буй орнуудад дараах тохиолдолд ХЕС автоматаар олгоно:

- Дэлхийн банкнаас "дундаас дээш орлоготой"-оос доогуур орлоготой гэж ангилдаг.
- Тэдэнд ЕХ-ны зах зээлд давуу эрх олгох өөр зохицуулалтаас (Чөлөөт худалдааны гэрээ гэх мэт) ашиг тус хүртээгүй байх.
- Эрх бүхий орнуудын жагсаалтад орсон.

Хэрэв тухайн улс ХЕС+ үнэлгээ авах хүсэлт гаргасан бол ашиг хүртэгч улс нь олон улсын 27 конвенцийг соёрхон батлах, мөн байгаль орчин, уур амьсгалыг хамгаалахтай холбоотой конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр ЕХ-той хамтран ажиллах, түүнчлэн ХЕС-ийн журамд заасан сайн засаглалыг нэвтрүүлэх шаардлагатай.

Импортын татварыг тэглэснээр Европын Холбооны ХЕС нь хөгжиж буй орнуудад хөдөлмөр, хүний эрх, уур амьсгал, байгаль орчины хамгаалалт, сайн засаглал зэрэг олон улсын үнэт зүйл, зарчимд тулгуурлан ядуурлыг бууруулж, ажлын байр бий болгоход тусалдаг. Эдгээр улсууд дараахь асуудлаар олон улсын 27 конвенцийг дагаж мөрдөх ёстой. Үүнд:

- Хүний эрх.
- Ажиллах эрх.
- Хүрээлэн буй орчин.
- Зөв засаглал.

Үүний хариуд эдгээр улс орнуудад экспортын тарифынх нь гуравны хоёрын импортын татварыг бууруулсан (эсвэл тэглэсэн). Монгол Улс 2023 оныг дуустал уг жагсаалтад хамрагдах боломжтой орнуудын нэг юм¹¹. Энэхүү гэрээ нь хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах, олон улсын үнэт зүйл, зарчимд тулгуурлан ажлын байр бий болгоход туслах зорилготой юм.

2017 онд Европын Холбоо, Монгол Улс хоорондын Түншлэл, хамтын ажиллагааны гэрээ (РСА) хүчин төгөлдөр болсон. Худалдааны асуудлаарх Түншлэл, хамтын ажиллагааны гэрээ (РСА)-гээр талууд хүнсний аюулгүй байдал, ургамал, амьтны эрүүл мэндийн асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах, худалдааг хөнгөвчлөх, олон улсын стандартыг хэрэгжүүлэх, түүнчлэн ХЕС+ дээр хамтран ажиллах, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг.

Европын Холбоо, Монгол Улсын хооронд 2017 онд хүчин төгөлдөр болсон Түншлэл, хамтын ажиллагааны гэрээний хүрээнд дараах асуудлыг хэлэлцэн тохиролцсон. Үүнд:

- Европын Холбооны хөнгөлөлтийн ерөнхий схемийн нэг хэсэг болох тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих тусгай зохицуулалтын (ХЕС+) хүрээнд Монгол Улс тарифын хөнгөлөлтийг илүү сайн ашиглах арга замын талаар ярилцсан.
- Хүүхдийн хөдөлмөр, байгаль орчныг хамгаалах чиглэлээр Монгол Улсын ХЕС+ амлалтуудыг мөрдөж ажиллав.
- ЕХ-ны Монголын Худалдааг Дэмжих Төсөл (TRAM) -ийн эерэг үр дүнг тэмдэглэв.
- Газарзүйн заалтын талаар хоёр талт хэлэлцээр хийх боломжийн талаар ярилцав.
- Хүнсний аюулгүй байдал, амьтан, ургамлын эрүүл мэндийн талаар тогтмол яриа хэлэлцээ хийх боломжийг судалсан.

¹¹ <https://trade.ec.europa.eu/access-to-markets/en/content/generalised-scheme-preferences-plus-gsp>

Мөн хоёр зах зээл дэх хөрөнгө оруулалтын орчин, гадаадын хөрөнгө оруулалтад саад учруулж буй Монгол Улсын зарим хууль тогтоомжийн талаар Европын Холбооны зүгээс санаа зовж буй асуудлуудыг хэлэлцэв.

2019 онд Европын Холбоо, Монгол Улсын худалдааны хэмжээ 562 сая евро болж, Европын Холбоо нь Монгол Улсын дөрөв дэх том худалдааны түнш боллоо. ЕХ-ны экспортын үнэ 486 сая еврог эзэлж, гол төлөв аж үйлдвэрийн бараа (82.6%), хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (17.2%) байна. Мөн онд Монгол Улсаас ЕХ-нд экспортолсон нийт бүтээгдэхүүний үнэ болох 76 сая еврогийн 87 хувийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, 33 хувийг аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн эзэлжээ.

Монгол Улс 2023 оныг дуустал ХЕС-д хамрагдах орнуудын нэг хэсэг байх бөгөөд энэ түншлэлийн бүх ашиг тусыг хүртэж байна. Гэсэн хэдий ч нэмэлт зардлыг бүтээгдэхүүний үнэд оруулж болно, тухайлбал:

- нэмэлт татвар,
- савлагааны зардал,
- зөөвөрлөлтийн хураамж,
- борлуулалтын ашиг
- зар сурталчилгааны зардал

Нийлүүлэгч нь гэрээний гарал үүслийн журмын дагуу бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг үзүүлэх шаардлагатай болдог. Батлагдсан буюу бүртгэлтэй ХЕС+ экспортлогч нь бүртгэл, лицензээ гаргаж өгөх боломжтой бөгөөд уг гэрчилгээг гарал үүслийн гэрчилгээ эсвэл албан ёсны гарал үүслийн мэдүүлгийн хэлбэрээр гаргаж болно.

Бүртгэгдсэн экспортлогч (REX) систем нь барааны гарал үүслийг өөрөө баталгаажуулах боломжийг олгодог. Хэрэглэгчид эрх бүхий байгууллагад бүртгүүлж, "бүртгэгдсэн экспортлогч" болох ёстой. REX системийг ЕХ-ны экспортлогчид зарим Чөлөөт Худалдааны Хэлэлцээр (ЧХХ), ХЕС+ гэх мэт хүрээнд ашигладаг. Компьютерт суурилсан программд хэрэглэгчийн нэр, нууц үгээ ашиглан интернетээр нэвтэрнэ.

Европ тодорхой нэг улсын импортолсон бүтээгдэхүүнд хязгаарлалт тогтоох арга хэмжээ авах тохиолдолд нэмэлт татвар ногдуулж болно. Европын гаалийн байгууллагууд бүтээгдэхүүн болон нэмэлт татварын талаар мэдээлэл өгөх боломжтой. Нэмэгдсэн өртгийн албан татварыг Европын зах зээлд борлуулж буй бүтээгдэхүүн, улмаар Европын Холбооны гаднах орнуудаас импортолж буй бүтээгдэхүүнд ногдуулдаг. Нэмэгдсэн өртгийн албан татвар улс орон бүрт өөр бөгөөд ихэвчлэн импортлогч өөрөө төлдөг.

4.8 Шаардлагатай бичиг баримт

4.8.1. Арьс ширийг түүхийгээр нь импортлох гарал үүслийн гэрчилгээ

Импортын (түүхий) арьс шир, (идээлсэн) арьс ширний гарал үүсэл тодорхой байх шаардлага бараг бүх улс оронд байдаг. Тиймээс, арьс шир (түүхий), арьс шир (идээлсэн) импортлоход экспортлогч улсад шаардлагатай зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас олгосон гарал үүслийн гэрчилгээтэй байх хэрэгтэй. Гарал үүслийн гэрчилгээ нь импортын татвар, хураамжаас чөлөөлөгдөх боломжийг олгодог. Улс хоорондын нэг талт, олон талт, хоёр талт гэрээ хэлэлцээрүүд нь мөн импортын татвараас чөлөөлсөн импорт, экспортыг зөвшөөрдөг бөгөөд гарал үүслийн гэрчилгээ нь "түүхий арьс" нэрийн дор бараа импортлоход гарал үүслийг тодорхойлсон үндсэн нотолгоо болдог.

Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээнд ил тод байдал, хяналт тавих эрэлт Европт нэмэгдэж байна. Дэлхий даяар цөөхөн үйлдвэрлэгчид одоогоор худалдан авагчдын шаардлагыг (арьс ширний боловсруулах үйл явц) дагаж мөрдөж чаддаг тул ил тод нийлүүлэлтийн сүлжээтэй байх нь өрсөлдөөний хувьд давуу талыг бий болгож байна.

Гарал үүслийг гаалийн байгууллагын зарчмын дагуу “*Материалын гарал үүсэл нь хамгийн их олборлосон, боловсруулсан газар*” гэж тодорхойлдог.

Дүрэм гаргах ажлыг худалдааны газар биш гаалийн байгууллага хариуцдаг. Үүний үр дүнд Киотогийн Конвенц нь олон улсын гаалийн байгууллагыг тодорхойлох дэлхийн журам болж байна. Хоёр үндсэн зөвлөмж нь бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох болно:

- Хэрэв зөвхөн нэг улс оролцож байгаа бол тэдгээрээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний байгалийн байдалтай холбоотой байх ёстой.
- Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хоёр ба түүнээс дээш улс оролцож байгаа бол эцсийн үйл явц явагдсан улс нь гарал үүслийн улс юм.

4.8.2. Гаалиар нэвтрэх бичиг баримт

Гаалиар нэвтрэх баримт бичиг (экспортлогч улсын гаалийн байгууллагаас тодорхойлсон) шаардлагатай бөгөөд экспортлогчийн гаалийн зуучлагч эсвэл экспортлогч бэлтгэнэ. Тэд мөн бүтээгдэхүүний импорт нь тухайн улсад авчрах ашиг тусын талаар танилцуулахыг шаардаж болно. Олон улс орон импортлохыг зөвшөөрөхийн тулд Элчин сайдын яамнаас бичиг баримт шаарддаг.

Барааг экспортлохоор савлаж дууссаны дараа шаардлагатай экспортын гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгийг (экспортлогч улсын ачааны боомтын гаальд шаардлагатай) бэлтгэдэг. Экспортын ачааг тухайн улсын гаалийн боомт руу шилжүүлэхээс өмнө нэхэмжлэх, баглаа боодлын жагсаалт болон экспортлогч улсын гаальд шаардлагатай бусад экспортын бичиг баримтыг бүрдүүлдэг. Экспортын баримт бичгийг экспортлогч улсын гаальд цахим хэлбэрээр бүрдүүлж өгнө. Ачаа экспортлогчийн байршлаас олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг гаалийн газар руу шилжүүлдэг. Экспортын ачааг экспортлогч улсын гаалийн баталгаат талбайд ачаа харгалзагчийн хяналт дор буулгана. Экспортын боомт дээр экспортын ачааг тээвэрлэх ажлыг экспортлогч улсад ачаа харгалзагч нь гүйцэтгэдэг.

Экспортлогч улсын гаалийн байгууллага энэ үйл явцыг дуусгасны дараа экспортын ачааг зөөх зөвшөөрөл олгодог. Шаардлагатай тохиолдолд шалгалтын үйл явцыг экспортлогч улсын гаалийн байгууллага гүйцэтгэдэг.

Бөглөх шаардлагатай гаалийн бичиг баримтад дараах зүйлс орно:

- **Гаалийн мэдүүлэг** шаардлагатай бүх газар. Тухайн улсын засгийн газрын тогтоосон форматын дагуу экспортлогч улсын экспортын гаалийн бүрдүүлэлтийн мэдүүлэг. Гаалийн ажилтан энэ чухал асуудлаар заавар зөвлөгөө өгөх боломжтой.
- **Нэвтрэх Хураангуй Мэдэгдэл (НХМ)**. Ачаа ирэхээс өмнө Европ руу нэвтрэх эхний хэсэг.
 - НХМ-ийг тээвэрлэгч эсвэл импортлогчийн төлөөлөгч ЕХ-ны улсын анхны гаалийн газарт бөглөж илгээх ёстой.
 - НХМ илгээх эцсийн хугацаа нь ачааг шилжүүлэх аргаас хамаарна.
- **Нэг удаагийн Захиргааны баримт бичиг (SAD)**. ЕХ-ны улс бүрт хэрэглэдэг импортын нийтлэг баримт бичиг.
- Бүтээгдэхүүний төрлөөс хамааран гаалийн байгууллага нэмэлт баримт бичиг шаардаж болно, тухайлбал:
 - Арилжааны Нэхэмжлэх
 - Тээврийн бичиг баримт

- Гарал үүслийн гэрчилгээ
- Импортын лиценз
- Туршилтын үр дүн болон бусад гэрчилгээ
- Хяналт, Шинжилгээний гэрчилгээ

Европын Холбооны гаалийн хуулийн дагуу гаальтай холбоотой бүх асуудлыг шийдвэрлэх импортлогч буюу импортлогчийн томилогдсон гаалийн төлөөлөгч гаалийн бүрдүүлэлтийг хийж ирүүлсэн байх ёстой.

Импортлогч нь шаардлагатай бичиг баримт, журмын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл худалдааны танхим (худалдааг дэмжих байгууллага) эсвэл импортлогч улсын гаалийн газартай холбогдож болно.

Гаалийн бүрдүүлэлт дууссаны дараа бүтээгдэхүүнийг Европын зах зээлд ямар ч хязгаарлалтгүйгээр шилжүүлж, борлуулах боломжтой бөгөөд энэ нь Европт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй ижил нөхцөлд байх болно.

- Европын Холбооны гаднаас импортолж буй бүх бараанд Европын улс бүрт ижил хураамж ногдуулдаг.
- Европын зах зээлд аль улсаас бүтээгдэхүүн оруулж ирэхээс үл хамааран импортын дүрэм журам ижил үйлчилдэг.

4.3.3. Санал зөвлөмж

Энэхүү гарын авлагад дурдсан зөвлөмжүүд нь бүтээгдэхүүнийг экспортлоход зайлшгүй мөрдөх шаардлагагүй (хуулийн дагуу) боловч бараа, бүтээгдэхүүн экспортоор худалдаалах явцыг илүү хялбар, чирэгдэл бага болгоно.

Сарлагийн арьс, арьс ширэн бүтээгдэхүүн экспортлохын тулд: тухайн улс эсвэл сонирхож буй улс орнууд дахь боломжит худалдааны түншүүд болон бизнесийн харилцаа холбоо тогтоохоос эхэлдэг, тухайлбал:

- **Худалдаа аж үйлдвэрийн танхимууд** зах зээл болон бизнесийн түншүүдээ шаардлагатай бүх мэдээллээр хангах боломжтой.
- Зах зээлийн шинжилгээ, бизнесийн боломжуудын үнэлгээг хамарсан **худалдааны мэдээ, худалдааг сурталчлах агентлагууд.**
- **Маркетингийн зөвлөхүүд болон банкууд** боломжит түншүүдэд зөвлөгөө өгөх боломжтой.
- Худалдан авагч, худалдагчдад зориулан тусгайлан зохион байгуулдаг **худалдааны үзэсгэлэн.** Жишээлбэл, “Enterprise Europe Network” нь эдгээр сэдвээр дэлхийн гуравдагч орнуудын компаниудыг багтаасан олон үзэсгэлэн зохион байгуулдаг.

Бараа, бүтээгдэхүүнийг экспортлоход ихэвчлэн экспортлогч/импортлогчоор ажиллахын тулд нэг удаагийн экспортын бүртгэл хангалттай байдаг. Гэсэн хэдий ч хязгаарлалттай барааг экспортлох тохиолдолд экспортлогч улсад тусгай экспортын лиценз шаардлагатай байж болно. Ийм бүтээгдэхүүнийг зохицуулахын тулд экспортлогч улс нь экспортын лиценз эсвэл экспортын зөвшөөрөл олгодог тусдаа төрийн байгууллагатай байдаг.

Европын Холбооноос гадуурх үйлдвэрлэгч нь Европын Холбоонд байдаг хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөгчөөр томилохоор харилцан тохиролцож болно. Энэ хувь хүн тухайн улсын иргэн ч бай, хууль ёсны оршин суугч ч бай компанийн цорын ганц төлөөлөгчөөр ажиллаж, хүлээсэн үүргээ биелүүлнэ. Энэ нь импортлогчдын хүлээх үүрэг хариуцлагыг хөнгөвчилдөг. Европын Холбооны бус үйлдвэрлэгчид импортлогчдод хэрэгтэй мэдээллийг хуваалцах нь арилжааны хувьд зохисгүй тул итгэж болох хүнээ сонгох хэрэгтэй гэж үзвэл энэ боломжийг ашиглахыг хүсэж болно. Импортлогчдын хангах ёстой бүх шаардлагыг биелүүлэх нь төлөөлөгчийн үүрэг байх болно.

Барааг тээвэрлэхээс өмнө ханган нийлүүлэгч болон импортлогч-худалдан авагч хоёр бизнесийн харилцааны нөхцөлөө тохиролцдог. Үнэ, чанарын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, төлбөрийн нөхцөл, тээвэрлэлтийн нөхцөл, бусад олон асуудлыг захиалгад тусгана; мөн импортыг зааврын дагуу хийнэ. Барааг импортлоход цөөн хэдэн баримт бичиг шаардлагатай бөгөөд улс бүр дагаж мөрдөх журмын талаар өөр өөр бодлого баримтлах тул тээвэрлэлтийн өмнө үүнийг хийж гүйцэтгэх ёстой.

Импортлох асуудлын талаарх мэдээллийг тухайн улсын импортлогч агентлагаас авч болно. Бүх шаардлагыг дагаж мөрдөх хариуцлага нь төлөөлөгчийн Европын импортлогчид (Европын бус үйлдвэрлэгчийн томилсон) оногдоно. Импортлогчид эдгээр шаардлагыг хангах хэрэгтэй тухай Европын бус ханган нийлүүлэгчид нь тэдэнд мэдээлэл өгсөн байх ёстой. Бүтээгдэхүүнийг ангилал, шошго, баглаа боодлын (CLP) журмын дагуу ангилсан, шошголсон, савласан эсэхийг баталгаажуулах үүрэг нь ЕХ-ны импортлогчид оногдоно. Гэсэн хэдий ч ЕХ-ны бус бодис (эсвэл хольц) үйлдвэрлэгч нь импортлогчтойгоо хамтран бүтээгдэхүүнийхээ сав баглаа боодол, шошготой холбоотой шаардлагыг шалгах ёстой. Тэд мөн бүтээгдэхүүний аюул байдлыг баталгаажуулахын тулд хамтран ажиллах ёстой.

Нийлүүлэгч нь орон нутгийн бүх зардлыг хариуцах ёстой, тухайлбал:

- Бүтээгдэхүүнийг тээвэрлэх боомт руу шилжүүлэх.
- Ачилтын зардал.
- Экспортлогч улсын гаалийн бүрдүүлэлтийн журам.
- Хураамж.
- Бүтээгдэхүүн хүрэх газартаа хүрэх хүртэлх даатгал.

Худалдан авагч нь дараах зардлыг хариуцна:

- Тээвэрлэлтийн боомтоос шилжүүлэх.
- Даатгал.
- Ачаа буулгалт.
- Тээвэрлэлтийн боомтоос хүрэх газар руу зөөвөрлөх.

Хөнгөвчилсөн харилцаа холбоо нь бүх худалдан авагчдад тавигдах албан бус шаардлага юм. 24 цагийн дотор бүх цахим шууданд хариу өгөх ёстой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг дараа нь явуулж болно.

Европын үйлчлүүлэгч анхны захиалгадаа дараах зүйлийг шаарддаг:

- материалын өндөр чанар, өөгүй хийц.
- ердийн захиалгын доод хэмжээнээс (MOQ) доогуур тоо хэмжээ.
- бага хэмжээгээр худалдан авах үед зөвшөөрч болох үнээс доогуур үнэ.

Монголоос бараа импортлохтой холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг доор оруулсан Европын албан ёсны цахим хуудсаас авах боломжтой:

https://www.eeas.europa.eu/mongolia/european-union-and-mongolia_en?s=171#top

5. ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖИТ ТҮНШҮҮД/ХАМТРАГЧИД

5.1. Танилцуулга

Европ нь олон улсын арьс ширний худалдааны чухал төлөөлөгч юм. Европ нь дэлхийн арьс ширний үйлдвэрлэлийн 25 орчим хувийг эзэлдэг бөгөөд арьс ширэн бүтээгдэхүүний хэрэглээний хамгийн том, эрэлт хэрэгцээтэй зах зээлийн нэг төдийгүй арьс шир боловсруулах чиглэлээр олон улсын бизнесийн хүрээний тэргүүлэгч нийгэмлэг гэдгээрээ ялгардаг.

Тус салбарт 3,000 гаруй компани, 50,000 орчим хүн ажил эрхэлж 8.0 тэрбум орчим еврогийн эргэлттэй үйлдвэрлэл явуулж байна. Европын арьс ширний үйлдвэрүүд дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа харуулж байна. Тэдний бүтээгдэхүүнүүд чанар, загварлаг байдлаараа дэлхий даяар алдартай бөгөөд үйлдвэрлэгчдийн талархлыг хүлээдэг. Европын арьс ширний дэлхийн өнцөг булан бүрт экспортолж, хамгийн өндөр стандарт, экологийн хамгийн хатуу дүрэм журам, чанарыг эрхэмлэдэг гэдгээр хэрэглэгчдийн хүлээлтийг хангадаг.

Европ дахь арьс ширний үйлдвэрүүд бүх төрлийн арьс ширний үйлдвэрлэдэг эртний уламжлалтай бөгөөд тэдний туршлага, мэдлэг, ур чадвар нь гутал, хувцас, тавилга, савхин эдлэлийн тэргүүлэх үйлдвэрлэгчдийн амжилтад хувь нэмэр оруулдаг. Энэхүү олон жилийн туршлага, мэдлэг ур чадвараа мэ“know-how” олон улсын томоохон яармагуудад харуулдаг. Энэ бүхэн нь олон улсын зах зээл дээр тэдний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ тасралтгүй өндөр байгааг харуулж байна.

Европ дахь салбар нь ихэвчлэн жижиг, дунд үйлдвэрлэлээс бүрддэг хэдий ч үндэстэн дамнасан томоохон компаниуд амжилттай ажиллаж байна. Европын Холбооны арьс ширний жижиг дунд үйлдвэрүүд нь одоо дунджаар 21 ажилтантай бөгөөд 2000 онд 24 ажилтантай байсныг дурдах нь зүйтэй. Энэхүү төлөв нь “**Жижиг бол чанартай**” гэсэн уриаг дэмжиж буй бөгөөд шинэ мянганы эхнээс эхлэн салбарт тулгарч буй томоохон өөрчлөлтүүдийг эдгээр компаниуд даван туулахад илүү дээр байсныг харуулж байна.

Франц, Испани, Итали, Португал зэрэг Өмнөд Европын арьс ширний хамгийн чухал салбарууд нь ихэвчлэн загварын чиглэлийн арьс ширний үйлдвэрлэлээр мэргэшсэн жижиг, дунд үйлдвэрлэгчидээс бүрддэг. Эдгээр жижиг, дунд үйлдвэрлэл нь ихэвчлэн гар урлалын чиглэлээр ажилладаг тул томоохон компаниудын хувьд хүндрэлтэй байх талтай. Үүний зэрэгцээ Австри, Герман, Нидерланд, Швед, Их Британи гэх мэт төв болон хойд Европын арьс ширний томоохон компаниуд энэ чиглэлээр эдийн засгийн өндөр үр ашигтай ажиллаж байна.

5.2. Европын Холбооны түншүүд болон үйлчлүүлэгчидтэй харилцаа тогтоох стратеги

5.2.1. Ерөнхий мэдээлэл

Шинэ болон хөгжиж буй зах зээл дэх үйлдвэрлэгчид Европын түншүүдтэй харилцаагаа хөгжүүлж, тэдэнтэй нягт хамтран ажиллах сонирхолтой байна. Ийм харилцааг өрсөлдөөний давуу талаа түшиглэн байгуулж болно. тухайлбал:

- өндөр чанартай түүхий эд,
- технологийн дэвшил, инноваци
- уян хатан байдал, дасан зохицох болон эрэлт хэрэгцээнд хурдан хариу үйлдэл үзүүлэх чадвар
- нийгэм, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл
- эко дизайн, тогтвортой загвар

- үйлчлүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээний давуу тал

Монголын арьс ширний кластер нь дээр дурдсан стратегийн ерөнхий тэнхлэгт тулгуурлан тодорхой давуу талтай, өрсөлдөх чадвартай бизнесийн загварыг бий болгох ёстой.

5.2.2. Өвөрмөц дүр төрх, загвар бүхий өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний багцыг бий болгох

Европын Холбооны түншүүд болон үйлчлүүлэгчидтэй урт хугацааны, тогтвортой харилцааг бий болгохын тулд эхлээд гутал, цүнх гэх мэт эцсийн хэрэглээнд зориулагдсан сайн чанартай бүтээгдэхүүний багцыг бий болгоход анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Бүтээгдэхүүний чанар, гүйцэтгэл өндөр, сэтгэл татам, үндэсний онцлогийг шингээсэн өвөрмөц загвар хийцтэй барааг дээж болгон үйлдвэрлэх нь чухал юм. Үүний зэрэгцээ бүх эцсийн бүтээгдэхүүнд ижил стандарт чанарыг хангахын тулд үйлдвэрлэлийн бүх дамжлага практик, үйл явцыг оновчтой болгож, стандартчилах ёстой. Ингэснээр Монголын арьс ширний үйлдвэрлэл эцсийн бүтээгдэхүүнээ тогтвортой, чанартай болгох боломжтой болно. Эдгээр бүтээгдэхүүнүүд Европын зорилтот зах зээлд тодорхой, өвөрмөц, танигдахуйц дүр төрхийг бий болгосноор бүтээгдэхүүн тус бүр онцлог дүр төрхтэй болох юм.

Өвөрмөц, сэтгэл татам загвартай, чанартай бүтээгдэхүүнийг амжилттай хөгжүүлж, эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд уламжлалт арга барил, техник технологи, туршлагад тулгуурлан шинэ дэвшилтэт “ноу хау”-г судлан нэвтрүүлэх нь онцгой ач холбогдолтой. Эрт үеэс уламжлалтай, арвин туршлагатай, олон өрсөлдөгчтэй Европын зах зээлд өөрийн үндэсний онцлог, давуу байдлыг шингээсэн бүтээгдэхүүнээр өрсөлдөх нь цаашид эрэлт хэрэгцээ бий болох үндэс суурийг тавьж чадна.

5.2.3. Үзэсгэлэн, яармаг худалдаанд оролцох

Европын олон үзэсгэлэн, яармагт зочилж Европын түншүүд болон боломжит үйлчлүүлэгчидтэй харилцаа холбоо тогтоох ажлыг шуурхай эхлүүлэх нь чухал ач холбогдолтой юм. **Европт зохиогддог үзэсгэлэн яармагууд:**

Линеапел “Lineapelle” (<https://www.lineapelle-fair.it/en/lineapelle>) Милан (Итали). 1981 онд анх нээгдсэн энэхүү үзэсгэлэн нь арьс шир, дагалдах хэрэгсэл, эд анги, нийлэг эдлэл, арьсан эдлэл, хувцас, тавилганы олон улсын хамгийн чухал үзэсгэлэн болжээ. Энэ арга хэмжээ жилд хоёр удаа болдог. Зуны улиралынх нь 2-р сард, өвлийнх нь 9-р сард. Байршил нь Миланы үзэсгэлэнгийн төв юм. Линеапел нь чанар, загварын шинэчлэлд байнга манлайлагч гэдгээрээ онцлог бөгөөд энэ нь дэлхий даяар арьс ширний эрэлт хэрэгцээг бий болгоход зайлшгүй шаардлагатай арга хэмжээ болдог.

Симак идээлэх технологи (Simac Tanning Tech) нь гутал, арьс шир, арьс ширний үйлдвэрүүдэд зориулсан техник, технологийн хамгийн өргөн хүрээг хамарсан олон улсын арга хэмжээ юм. Линеапелтэй зэрэгцэн Миланд болно. Симак Арьс Ширний Технологи–д оролцогчид дараах чиглэлийн машин үйлдвэрлэгчдийг багтаадаг. Үүнд:

- гутал, савхин эдлэл, арьс ширний үйлдвэр
- дагалдах хэрэгсэл, эд анги нийлүүлэгчид
- химийн бодис
- загварчлалын систем, лабораторийн тоног төхөөрөмж
- хэрэглээний материал
- автоматжуулалт
- хог хаягдал боловсруулах систем тоног төхөөрөмж

- хэв ба хэв зүсэгч
- менежмент ба үйлдвэрлэлийн мөчлөг
- логистик
- бэлэн бүтээгдэхүүний туршилт
- дамжуургын систем гэх мэт...

МИКАМ Милано “MICAM Milano” (<https://themicam.com/en/>) - Дэлхийн тэргүүлэгч гутлын үзэсгэлэн бол дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн бараа худалдагчдад зориулсан жишиг арга хэмжээ юм. Гуравдугаар сард намар/өвөл, есдүгээр сард хавар/зун гэсэн хоёр удаагийн үзэсгэлэнд шилдэг гутлын брэндүүд өөрсдийн цуглуулгаа танилцуулдаг.

Internationale Ledermesse, Offenbach (<https://www.ilm-offenbach.de/en/>) нь жилд хоёр удаа болдог бөгөөд шинэлэг, өндөр чанартай арьсан эдлэл, цүнх, ачаа тээшний олон улсын үзэсгэлэн худалдаанд бүх чухал брэндүүд болон салбарын тоглогчид оролцдог.

Монгол дахь кластерийн гишүүн нь технологи, зах зээлийн чиг хандлага, боломжит бизнесийн түнш, үйлчлүүлэгчдийн талаар хэрэгтэй мэдээлэл авахын тулд үзэсгэлэнд тогтмол оролцох нь чухал юм. Дараах линкээс - <https://10times.com/top100/leather> - арьс ширэн бүтээгдэхүүнтэй дэлхий дээрх хамгийн чухал 100 үзэсгэлэн, арга хэмжээг үзэх боломжтой.

5.2.4. Европын Холбооны гол аж үйлдвэрүүдийн холбоодтой харилцаа холбоо тогтоох

Европын томоохон аж үйлдвэрийн байгууллагуудтай ойр дотно харилцаа тогтоох нь зорилтот зах зээлд үр дүнтэй нэвтрэх стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Ийм байгууллагуудын үйл ажиллагааг дагаж, тэдний сүлжээнээс ашиг хүртэх нь чухал. Европын арьс, савхин бүтээгдэхүүний хамгийн нөлөө бүхий аж үйлдвэрийн байгууллагууд бол:

Европын гутлын аж үйлдвэрийн холбоо (СЕС). СЕС (<http://cec-footwearindustry.eu/>) нь ЕХ-ны үндэсний гутлын холбоодыг нэгтгэдэг. Эдгээр холбоод нь гутал үйлдвэрлэлийн 88 орчим хувийг эзэлж байна. Үндэсний холбоо, салбар холбоодоор дамжуулан СЕС нь материал, эд ангиудыг цуглуулахаас эхлээд дахин боловсруулах нийтлэг зорилго хүртэл нийлүүлэлтийн сүлжээний бүх оролцогч талуудын хамтын ажиллагааг хөнгөвчлөх зорилготой.

Мөн СЕС нь:

- Европын салбарын өрсөлдөх чадвар, тогтвортой өсөлтийг дэмжинэ.
- Европын гутал үйлдвэрлэлд нөлөөлөх бодлого, зохицуулалтын талаар ЕХ-ны байгууллагууд болон олон улсын байгууллагуудын өмнө Европын гутлын ашиг сонирхлыг дэмждэг. (жишээ нь тэгш өрсөлдөөний талбарт гуравдагч зах зээлийг нээх, ЖДҮ-ийг олон улсын болгох, хуурамч бараа бүтээгдэхүүнтэй тэмцэх, байгаль орчин, нийгмийн хариуцлага гэх мэт).
- Даяаршлын шинэ сорилтод дасан зохицоход тус салбарыг дэмжих, ЕХ-ны төслүүдэд оролцох замаар судалгаа, инновацийг дэмжих. Тухайлбал: уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмэр оруулах, эрчим хүчний хэмнэлт, материалын хомсдол, цахим худалдаа, бизнесийн шинэ загвар, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ гэх мэт.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх, түүнчлэн залуу хойч үеийнхний хувьд салбарын сонирхол татахуйц байдлыг дэмжих, Европын санаачилгуудаар (жишээлбэл, Erasmus+хөтөлбөр, ЕХ-ны түвшний Нийгмийн Яриа Хэлэлцээ гэх мэт),

СЕС нь Монголын арьс ширний салбарын хувьд гутлын бүх сонирхогч талууд хооронд мэдээлэл, сайн туршлага солилцох, Европын дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд зориулсан платформ, харилцааны суваг болдог.

СЕС-ны холбоо барих хүн нь Кармен Ариас Кастеллано (Ерөнхий Нарийн Бичгийн Дарга) бөгөөд цахим шуудангийн хаяг нь info@cec-footwearindustry.eu. СЕС-р (эсвэл шууд) Монголын арьс ширний кластер нь дараах Европын үндэсний аж үйлдвэрийн үндсэн холбоодтой холбогдох боломжтой.

- Италийн Гутал Үйлдвэрлэгчдийн Холбоо (Assocalzaturifici) (<https://www.assocalzaturifici.it/en/home-en/>)
- Португалийн Гутлын Аж Үйлдвэрийн Холбоо (APICCAPS) (<https://www.apiccaps.pt>)

Монголын кластерийн гишүүдийг мөн www.worldfootwear.com цахим платформд хандаж, дэлхийн гутлын салбарын талаарх өдөр тутмын мэдээ мэдээлэл авахыг зөвлөж байна.

Дэлхийн гутал “World Footwear” нь APICCAPS-ийн санаачилга бөгөөд Дэлхийн Гутлын Эмхэтгэлийг жил бүр гаргадаг.

Дэлхийн гутлын эмхэтгэл нь дэлхийн гутлын салбарын гол чиг хандлагыг задлан шинжилдэг иж бүрэн тайлан юм. Энэхүү эмхэтгэлийн зорилго нь гутлын салбарын тоглогч болох холбогдох улс орнуудын байр суурийг янз бүрийн хувьсах хэмжигдэхүүнээр (Үйлдвэрлэл, экспорт, импорт, хэрэглээ) дүн шинжилгээ хийж, салбарын тоглогчдын стратегийн байр суурийг үнэлэхэд оршино.

Францын гутлын аж үйлдвэрийн холбоо (Fédération Française de la Chaussure), <https://www.chaussuredefrance.com/sites/en>

Испанийн Гутлын Аж Үйлдвэрийн Холбоо (FICE) (Federación de Industrias del Calzado Español), <http://www.fice.es/inicio>

Британийн гутлын холбоо (BFA) <https://britishfootwearassociation.co.uk/>

Грекийн гутал үйлдвэрлэгч, экспортлогчдын Холбоо (ELSEVIE) <https://www.hellenicshoe.eu/en/>.

ELSEVIE нь 2023 оны 6-р сард Брюссельд болсон СЕС-ны Ерөнхий Ассамблейн үеэр SYL төслийн талаар илтгэл тавьсан. ELSEVIE гишүүдээ Монголын арьс ширний кластерийн хэтийн төлөв, зорилт, тодорхой зах зээл дэх Европын түншүүд болон үйлчлүүлэгчидтэй харилцаа холбоо тогтоож, аажмаар туршилтын хамтын ажиллагааг эхлүүлэх талаар мэдээлэл хийлээ. Мөн гишүүн компаниудын Монголын арьс ширний кластертэй хамтран ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор СЕХ-ны Хэрэг эрхлэх газраар дамжуулан үндэсний үйлдвэрүүдийн бүх холбоодод захидал илгээсэн. Тодорхой болгох шаардлагатай нээлттэй асуудлууд байгаа тул боломжит түншүүдийн хариу үйлдэлд болгоомжтой хандсан. Гол анхаарах асуудал нь:

- Монгол сарлагийн арьс, техникийн шинж чанар,
- эцсийн бүтээгдэхүүний хэрэглээ,
- ЕХ-ны стандартад нийцсэн байдал, гэрчилгээ, үйлдвэрлэлийн хүчин чадал г.м.

Европын боломжит түншүүд болон үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийн дараа ELSEVIE өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний багцыг яаралтай бий болгохыг зөвлөж байна. Мөн шинэ зах зээлд хандах хандлагыг системтэйгээр бэлтгэх, төлөвлөхийг санал болгож байна. Үүнд бүтээгдэхүүний цуглуулга бий болгох, салбарын чухал үзэсгэлэн худалдаанд оролцох, үндэсний салбарын аж үйлдвэрийн холбоодтой харилцаа холбоо

тогтоох зэрэг чухал ач холбогдолтой хамтын ажиллагааг аажмаар эхлүүлэх, ЕХ-ны орон зайг бий болгох, зах зээлд нэвтрэх зэрэгт ойрын гурван жилд системтэй хүчин чармайлт гаргах шаардлагатай гэж үзэж байна.

ELSEVIE нь Монголын Арьс Ширний Үйлдвэрлэлийн Кластерийн энэхүү хүчин чармайлтад СЕХ-ны хүрээнд байгаа бүхий л боломж, нөлөөгөөр туслах болно.

- **Италийн арьс ширний холбоо** (UNIC) <https://www.unic.it/> нь (1946 оноос хойш) арьс ширний компаниудын дэлхийн хамгийн чухал холбоо болсон. UNIC нь салбарынхаа эрх ашгийг дэмжиж, бүх түвшинд төлөөлж, инновацийг хөгжүүлж, нийгэм, байгаль орчны үүргийг дээшлүүлж, салбарын зах зээлд нийцсэн арилжааны компаниудыг байгуулдаг.
- **Арьс шир үйлдвэрлэгчдийн олон улсын зөвлөл** (ICT) <https://leather-council.org/> нь 1926 онд байгуулагдсан арьс шир үйлдвэрлэлийн дэлхийн байгууллага юм. Энэ нь арьс, ширний олон улсын худалдааг хөнгөвчлөх, зохицуулах, дэмжих зорилготой.
- **Европын нийгэмлэгийн арьс шир, хувцас үйлдвэрлэгчдийн үндэсний холбоодын холбоо** (COTANCE) <https://www.cotance.com/> нь Европын арьс ширний үйлдвэрлэлийн төлөөлөх байгууллага юм. Энэ нь Европын арьс ширний үйлдвэрлэлийн ашиг сонирхлыг олон улсын түвшинд дэмждэг. Европын арьс шир, хувцас үйлдвэрлэгчдийг төлөөлөхөөс гадна Европын болон олон улсын зах зээлд Европын арьс ширийг сурталчлах эрхэм зорилготой.

5.3. Санал болгож буй боломжит бизнесийн түншүүд ба үйлчлүүлэгчид

5.3.1. Арьс ширний үйлдвэрүүд

Арьс ширний үйлдвэр Stefania SPA “Conceria Stefania SPA” нь 1944 онд Миланд байгуулагдсан арьс ширний компани бөгөөд 200 гаруй ажилтантай, өдөрт 6000 м² арьс шир үйлдвэрлэдэг. Тус компани нь 80 орчим жилийн турш арьс шир боловсруулах, өнгөлгөө боловсруулах уламжлалаа үргэлжлүүлж буй, ихээхэн туршлагатай, байгаль орчин, орчин үеийн дэвшилтэт технологийг хүндэтгэсээр ирсэн юм.

Мотта алфредо SPA “Motta Alfredo SPA” нь 1978 онд Италийн Синиселло Балсамо хотод үүсгэн байгуулагдсан бөгөөд оёдлын үйлдвэрлэлд зориулсан арьс шир, боловсруулаагүй арьс зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээ (арьс ширний үйлдвэр) нийлүүлдэг.

Кончециа кориум арьс шир SRL “Concezia Corium Leather SRL” нь Италийн Санта Кроче сулл Арно дахь уламжлалт гэр бүлийн арьс ширний үйлдвэр юм.

Василиадис арьс ширний үйлдвэр нь 1942 онд байгуулагдсан бөгөөд Грекийн Афин хотын Вотаникост байрладаг гурав дахь үеийн компани юм. Тус компани нь Грекийн хурганы арьс боловсруулах чиглэлээр тэргүүлэгч, наппа гутал, цүнхний хамгийн чанартай түүхий эдүүдийн нэг. Зах зээлд 70 гаруй жил ажиллаж байгаа тус компани нь олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, дээд зэргийн чанар, ул мөр (түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртэл) харах чадварыг бий болгосон. Холбоо барих хүн нь Цанис Василиадис.

Монголын арьс ширний кластерийн гишүүдийг Испанийн арьс ширний үйлдвэрүүдтэй холбоо барихыг зөвлөж байна. Ялангуяа гэр бүлийн эзэмшдэг, жижиг, туршлагатай арьс ширний үйлдвэрлэгчдээс бүрддэг Барселона хотод байрлах арьс шир, савхин бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн урт удаан жилийн уламжлалыг хадгалсаар ирсэн үйлдвэрүүд бол:

- Себастьян Кастелл Торт СЛ
- Магин Пуиг Губерн
- Индустиас Пере Де Кармэ СА
- Куртитс Вич Галиманы СЛ
- Куртитс Фонт Валлес СЛ
- Куртидос Кастанер СЛ
- Куртидос Лансина СА
- Антони Ллакуна СЛ
- Акабадос Де Ла Пиэл Окана SCP

Испанид байгаа бусад арьс ширний үйлдвэрүүд нь:

- Валенси дахь Куртидос Жин SL, болон
- Валлс Таррагона дахь Грийнкиур SL

5.3.2. Гутал, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон брендүүд

- Италийн Фучеккио (Флоренц) дахь **Giancarloponi SRL** нь фермийн түүхий эдийг боловсруулах (голчлон арьс шир), худалдаа, бөөний худалдаа, түүнчлэн гутлын үйлдвэрлэл эрхэлдэг. Холбогдох хүн бол Жианкарло Капони.
- **Geox Italia SPA** нь олон улсын амьдралын хэв маягийн гутлын зах зээлд тэргүүлэгч брэнд бөгөөд ус үл нэвтрэх, амьсгалах чанарыг баталгаажуулсан бүтээгдэхүүнүүдэд шинэлэг шийдэл, технологийг нэвтрүүлэхэд чиглэдэг. Geox технологи нь 61 өөр патент болон сүүлийн үеийн таван патентын мэдүүлгээр (Италид бүртгэлтэй, олон улсын хэмжээнд өргөжсөн) хамгаалагдсан. Холбоо барих хүн бол Хуан Карлос Венти.
- **Franco Romanogli & G** нь хүчтэй арьсан гутал үйлдвэрлэгч юм. ялангуяа хүүхдүүдэд (хөвгүүд, охид). Тус компани нь Италийн Марке мужийн Морровале хотод байрладаг. Холбоо барих хүн бол Тонино Сианнавэй.
- Францын алдартай брэнд **Mephisto**, Мартин Михаэли 1965 онд Сарребургт үүсгэн байгуулсан; 1975 онд "*The Originals*" хэмээх маш онцгой гутлын санааг олсон алсын хараатай нэгэн. Тус компани нь 1975 оноос хойш яг ижил төрлийн гутал үйлдвэрлэж байна. *Originals* нь дэлхий даяарх хувь хүн, босогчдыг нэгтгэдэг гутал бөгөөд сүүлийн 42 жилийн турш ийм гутал хийж байна. Гүйцэтгэх захирал нь Фрэнк Вебер юм.
- Германы Розенхайм-ийн **Gabor Shoes AG** нь гурван брэндийг эзэмшдэг:
 - **Gabor**. Сүүлийн үеийн загвар, дээд зэргийн чанар; материал болон боловсруулалтын аль алинд хамаарна.
 - **Pius Gabor**. Үнэ цэнтэй, тогтвортой байдал, өмсөхөд тав тухтай эрэгтэй загварлаг гутал, пүүз.
 - **Rollingsoft**. Фитнесс, эрүүл мэндэд зориулагдсан уян ултай, спорт загвартай шинэлэг чөлөөт гутал. Холбоо барих хүмүүс бол доктор Маркус Рехайс, хатагтай Катарина Готвальд нар юм.
- Германы Лангенфельд (Rheinland)-ын **Ara Shoes GmbH** нь арьсан эдлэл, ачаа тээш, хувцас, дагалдах хэрэгсэл зэрэг гутал болон холбогдох бүтээгдэхүүнийг '*ara*' брэндийн дор үйлдвэрлэж, түгээдэг.
- **Bari Kbk Groop Ltd** нь Пештера Болгар дахь арьс, хувцас үйлдвэрлэгч.
- **Astir Shoe Factory Ltd** нь 1960 оноос эхэлсэн гэр бүлийн эзэмшлийн бизнес бөгөөд арьсан гутал (гол төлөв шаахай, сандаал) үйлдвэрлэдэг. Никосия Киприйн хамгийн найдвартай компаниудын нэг юм.
- **S. Piero Ltd**. Грекийн Мосчато Афин дахь эмэгтэй гутал үйлдвэрлэдэг гэр бүлийн компани.
- **Д.Ж. Фидас СА** Компанийн түүх 1919 онд Пелопоннесийн Каламата хотоос эхэлсэн бөгөөд Жон Фейдас 12 жилийн дараа АНУ-аас буцаж ирэхдээ гутлын

урлалын талаар бүгдийг сурчээ. Дэлхийн 2-р дайны дараа Фейдасын гэр бүл Афин руу нүүж, 1974 оноос хойш өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд томоохон хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд тус үйлдвэр өдөрт 8500 хос гутал үйлдвэрлэх хүчин чадалтай болжээ. Д.Ж. Фидас СА нь алдартай "Boxer" брэндийг эзэмшдэг.

Мэдээж ELSEVIE болон төслийн бусад бүх түншүүд SYL төслийн гэрээний хугацаанд мөн түүнийг дууссаны дараа дээр дурдсанчлан Грек болон бусад газар дахь компаниудтай харилцахад бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх болно.

Хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор харилцаа холбоо, мэдээлэл солилцох, харилцан үйлчлэлийг эхлүүлэх зорилгоор Монголын арьс ширний кластерт санал болгож буй компаниудыг дараах хүснэгтэд үзүүлэв

Монголын Арьс Ширний Кластерийн гишүүдтэй холбогдож болох компаниуд

Name	Location	Activity	Description	Contact
Conceria Stefania SPA	Милан, Итали	Арьс Ширний Үйлдвэр	https://www.stefania.it/en/	stefania@stefania.it
Motta Alfredo SPA	Синисэлло Балсамо, Итали	Арьс ширний үйлдвэр	www.mottaalfredo.com	https://globalcatalog.com/mottaalfredospa.it/en/contact
Concezia Corium Leather SRL	Санта Кроче Сулл Арно, Итали	Арьс ширний үйлдвэр	https://www.cylex-italia.it/santa-croce-sull-arno/corium-leather-s-r-l-11212317.html	https://web.facebook.com/coriumleather/?_rdc=1&_rd
Vasiliadis Tannery	Афин, Грек	Арьс ширний үйлдвэр		vasiliadis_tannery@mail.com
Sebastien Castell Tort Sl	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		tcastelltort@hotmail.com
Magin Puig Gubern	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		magipulg@telefonica.net
Industrias Pere de Carme SA	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		ipecasa@gmail.com
Curtits Vich Galimany Sl	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		josepramonvich@hotmail.com
Curtits Font Valles Sl	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		fontegenoves@empresas.inescop.com
Curtidos Castaner Sl	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		administracion@curtidocastaner.com
Curtidos Lancina SA	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		lancina@lancina.com
Antoni Llacuna Sl	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		llacunet@filnet.es
Acabados de la Piel Ocana SCP	Барселона, Испани	Арьс ширний үйлдвэр		acabadospiel@terva.es
Curtidos Jin Sl	Валенсиа, Испани	Арьс ширний үйлдвэр	https://www.curtidosjin.com/	https://www.curtidosjin.com/
Greencuir Sl	Валлс Таррагона, Испани	Арьс ширний үйлдвэр		administracion@greencuir.com
Giancarloponi SRI	Фирэнз, Итали	Худалдаачин, Бөөний Худалдаачин, Борлуулагч	https://fashionindex.it/item/giancarloponi-srl/	info@giancarloponi.it
Geox Italia SPA	ИталийнТревизо		https://www.geox.biz/en/index.html	juancarlos.venti@geox.com
Franco Romanogli & G	мужийн Монтебеллуна		https://romagnoli.com/	https://web.facebook.com/100063119864718/videos/100639333295812
Mephisto	хотын Биадене	Үйлдвэрлэгч, Бөөний Худалдаачин, Брэнд, Борлуулагч	https://originals.mephisto.com/en/	press@mephisto.com
Gabor Shoes Ag	Морровале, Марке, Итали	Үйлдвэрлэгч, Брэнд, Бөөний худалдаачин	https://www.gabor.de/en_int	presse@gabor.de
Ara Shoes GmbH	Сарребург, Франц	Үйлдвэрлэгч, Брэнд, Бөөний худалдаачин	https://www.ara-shoes.com/arahome	https://www.ara-shoes.com/arahome

Bari Kbk Groop Ltd	Розенхайм, Герман	Үйлдвэрлэгч, Брэнд, Бөөний худалдаачин	www.barishoes.com	https://www.bulgariantextile.com/en/leather-clothing/bari-kbk-group-ltd/1936
Astir Shoe Factory Ltd	Лангенфельд, Герман	Үйлдвэрлэгч, Брэнд, Бөөний худалдаачин	https://www.europages.co.uk/ASTIR-SHOE-FACTORY-LTD/00000004457061-308782001.html	https://www.europages.co.uk/ASTIR-SHOE-FACTORY-LTD/00000004457061-308782001.html
S. Piero Ltd	Пештера, Болгар	Үйлдвэрлэгч, Бөөний худалдаачин	https://www.spiero-shop.gr/el/	info@spiero.gr
D.J. Fidas SA	Никосия, Кипр	Үйлдвэрлэгч, Брэнд, Борлуулагч	https://fidas.gr/en/	fidas@fidas.gr

Хавсралт 1. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний худалдаатай холбоотой Монгол улсын хууль тогтоомж

Монгол Улсад экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн урт, дунд, богино хугацааны төрийн бодлого, хөтөлбөр төсөл хэрэгжиж байгаа бөгөөд эдгээрийн нэр, хэрэгжих хугацаа, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн гол үйл ажиллагаа болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортод хамаарах хуулиуд, тэдгээрийн голлох заалтуудыг нэгтгэн дараах хүснэгтэд харуулав.

Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлогчид эдгээр бодлогын баримт бичигт заасан боломжуудыг ашиглах, түүнчлэн зорилтыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, мөн эрх зүйн зохицуулалтын хүрээнд ямар боломж, хязгаарлалт байгаа эсэхийг сайтар судлах шаардлагатай.

Монгол Улсаас мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын талаар баримталж буй хууль тогтоомж

Баримт бичгийн нэр	Экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого
<p>“АЛСЫН ХАРАА 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</p> <p>Монгол Улсын Их Хурал</p> <p>2021-2050 он</p>	<p><i>Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд</i></p> <p>I үе шат (2021-2030): Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе.</p> <p>2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинийг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна.</p> <p><i>Тогтвортой хөдөө аж ахуй</i></p> <p>I үе шат (2021-2030): Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид илрэх үе.</p> <p>5.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ.</p> <p>II үе шат (2031-2040): Хөдөө аж ахуйн нөөцийг бүрэн ашиглах, тогтвортой үйлдвэрлэл, үр ашиг, бүтээмжээр өрсөлдөх үе.</p> <p>3.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлж, зарим нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний импортыг халж, экспортыг нэмэгдүүлнэ.</p> <p>III үе шат (2041-2050): “Ухаалаг” хөдөө аж ахуйг хөгжүүлэх үе.</p> <p>3.Оюуны багтаамж өндөртэй, органик, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр экспортыг нэмэгдүүлж, эдийн засагт орлогын шинэ эх үүсвэрийг бүрдүүлнэ.</p>
<p>“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p>	<p><i>Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд</i></p> <p>4.2.1.Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ,</p>

<p>Монгол Улсын Их Хурал</p> <p>2021-2030</p>	<p><i>жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.</i></p> <p><i>4.2.2.Хөдөө аж ахуй, тээвэр логистик, төрөлжсөн аялал жуулчлалын салбарыг бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих замаар хөгжүүлнэ.</i></p> <p><i>4.2.5.Олон улсын зах зээлийн үнийн нөлөөлөлд бага өртдөг эко цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын таатай орчныг бүрдүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангана.</i></p> <p><i>4.2.7.Барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.</i></p> <p><i>4.2.23. Мал, амьтны гаралтай арьс, шир, ангийн үс, ноосыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.</i></p> <p><i>Тогтвортой хөдөө аж ахуй</i></p> <p><i>8.3.7. Хөдөө аж ахуйн эрчимжүүлсэн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулан, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжинэ.</i></p> <p><i>8.3.31. Бүс нутаг дахь малын гаралтай түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглах, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулж, экспортыг дэмжинэ.</i></p> <p><i>Алслагдсан бүс нутаг дахь малын гаралтай түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлнэ.</i></p> <p><i>8.3.36. Боловсруулах салбарын хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлнэ.</i></p>
<p>Монгол экспорт хөтөлбөр</p> <p>Монгол Улсын Засгийн газар</p> <p>2018-2022</p>	<p>Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын талаар эдгээр бодлогын баримт бичиг байгаа боловч үйлчлэх хугацаа дуусгавар болсон эсхүл хожим хүчингүй болгосон байх тул энэхүү судалгаанд хамааралгүй гэж үзэж байна.</p>
<p>Үндэсний чанарын хөтөлбөр</p> <p>Монгол Улсын Засгийн газар</p> <p>2016-2020</p>	
<p>Төрөөс малчдын талаар баримтлах бодлого</p> <p>Монгол Улсын Их Хурал</p> <p>2015-2025</p>	
<p>Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>/богино хугацааны бодлого/ Монгол Улсын Их Хурал</p>	<p><i>1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.</i></p> <p><i>1.1.5. Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.</i></p>

	<p>3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>3.1.17. Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.</p> <p>3.1.20. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна.</p> <p>3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.</p> <p>3.3.4.Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, “Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <p>3.3.6.Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.</p> <p>3.3.8.Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.</p> <p>3.3.9.Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.</p> <p>3.3.10.Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.</p>
--	---

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортод хамаарах Монгол Улсын хуулиуд

Хуулийн нэршил	Тайлбар
Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай 2002.11.28	1.1. Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Мал, амьтны эрүүл мэндийн тухай	1.1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах,

2017.12.08	<i>нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</i>
Малын генетик нөөцийн тухай 2017.12.14	<i>1.1.Энэ хуулийн зорилт нь мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтан /цаашид "мал" гэх/-ны генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</i>
Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай 2010.06.10	<i>1.1.Энэ хуулийн зорилт нь бараа, үйлчилгээний тэмдэг /цаашид "барааны тэмдэг" гэх/, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</i>
Гаалийн тухай 2008.05.20	<i>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</i>
Гаалийн тариф, гаалийн татварын тухай 2008.05.20	<i>1.1.Энэ хуулийн зорилт нь гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</i>
Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай 2011.06.02	<i>1.1. Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</i>
Иргэний хууль 2002.01.10	<i>1.1. Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.</i>

Дүгнэлт: Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт нь Монгол Улсын төрөөс баримталж буй урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцэж байна. Энэ салбарт баримталж буй богино хугацааны бодлогын баримт бичиг одоогоор байхгүй байна. Мөн малын гаралтай бүтээгдэхүүний экспортод хамаарах ерөнхий зохицуулалт бүхий 6 хууль нарийвчилсан буюу тухайлан зохицуулсан 2 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хууль тогтоомж байхгүй гэж дүгнэж байна.